

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**04 дүгээр сарын 01-ний өдөр, Мягмар гараг**

**Хуралдааны тэмдэглэлийн агуулга**

**Хуралдааны товч тэмдэглэл:** 1-6

**Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:** 7-78

---

1.Монголбанкны Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны талаарх Монголбанкны Ерөнхийлөгч, Монголбанкны Хяналтын зөвлөлийн мэдээллийг сонсох	8-43
2.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.03.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	43-67
3.Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	67-78

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы  
Эдийн засгийн байнгын хорооны  
04 дүгээр сарын 01-ний өдөр /Мягмар гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 13 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Ш.Бямбасүрэн, С.Цэнгүүн;

Эмнэлгийн чөлөөтэй: Б.Найдалаа;

Тасалсан: Н.Батсүмбэрэл, Х.Баттулга, П.Сайнзориг.

**Нэг.Монголбанкны Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны талаарх  
Монголбанкны Ерөнхийлөгч, Монголбанкны Хяналтын зөвлөлийн  
мэдээллийг сонсох**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга Н.Ууганбаатар, мөн зөвлөлийн гишүүн Т.Тэлмэн, Г.Тэлмэн, У.Хосжаргал, Д.Энхжаргал, Г.Эрдэнэбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Монголбанкны Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга Н.Ууганбаатар нар танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар, Л.Соронзонболд, Б.Мөнхсоёл, Г.Лувсанжамц, О.Цогтгэрэл, Ж.Алдаржавхлан, Р.Батболд, О.Батнайрамдал, М.Энхцэцэг, Г.Тэмүүлэн, Д.Энхтүвшин, О.Номинчимэг нарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Р.Сэддорж, Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга Н.Ууганбаатар, мөн зөвлөлийн гишүүн Д.Энхжаргал нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Монголбанкны Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны талаарх Монголбанкны Дэд ерөнхийлөгч, Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга нарын мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 13 цаг 19 минутад хэлэлцэж дуусав.

**Хоёр.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай  
хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар  
2025.03.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Б.Батцэцэг, мөн газрын Хууль, эрх зүйн газрын ахлах референт Х.Сүрэнхорол, Салбарын бодлого, зохицуулалтын референт Б.Золбоо, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Н.Жамъянхүү, Цагдаагийн ерөнхий газрын дарга Т.Сүхболд, мөн газрын Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газрын дарга С.Тайван, Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг, Монополын эсрэг газрын дарга Б.Билгүүн, Харилцаа холбооны зохицуулах хорооны Ажлын албаны дарга А.Лувсан-Очир, мөн хорооны Зохицуулалтын газрын дарга Т.Батболд, Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн захирал С.Гантулга, мөн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн профессор Л.Бат-Очир нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, О.Номинчимэг, Г.Уянгахишиг, Б.Жаргалан, Р.Сэддорж нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Н.Жамъянхүү, Цагдаагийн ерөнхий газрын дарга Т.Сүхболд, Харилцаа холбооны зохицуулах хорооны Зохицуулалтын газрын дарга Т.Батболд нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, Г.Уянгахишиг, Б.Мөнхсоёл, М.Энхцэцэг, О.Батнайрамдал, Н.Учрал нар үг хэлэв.

**Р.Сэддорж:** 1.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 6  
Бүгд: 18

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

*Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, Д.Энхтүвшин нарын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.*

2.Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 9  
Бүгд: 18  
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёлын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Р.Сэддорж:** Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёлын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 7  
Бүгд: 18  
61.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

2.Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 7  
Бүгд: 18  
61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

*Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэгийн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.*

3.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 7  
Бүгд: 18  
61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

*Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлангийн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.*

4.Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 7  
Бүгд: 18  
61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

*Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлангийн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.*

5.Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 8  
Бүгд: 18  
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 6  
Бүгд: 18  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 6  
Бүгд: 18  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 9  
Бүгд: 18  
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Р.Сэддорж:** Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 6  
Бүгд: 18  
66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

8.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 6  
Бүгд: 18

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

*Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингийн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.*

9.Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 8  
Бүгд: 18

55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 14 цаг 54 минутад хэлэлцэж дуусав.*

***Гурав.Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Монголбанкны Банк бус санхүүгийн байгууллагын газрын дарга Б.Итгэлсүрэн, мөн банкны Хууль, эрх зүйн газрын захирал Д.Аюуш, мөн газрын мэргэжилтэн М.Тэмүүлэн, Зээлийн мэдээллийн албаны дарга М.Баттулга, мөн албаны ахлах хянан шалгагч Л.Дөлгөөн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Л.Батмөнх, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, Б.Мөнхсоёл, О.Номинчимэг, О.Батнайрамдал, Р.Сэддорж нарын тавьсан асуултад

хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар, Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Монголбанкны Банк бус санхүүгийн байгууллагын газрын дарга Б.Итгэлсүрэн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, Б.Мөнхсоёл нар үг хэлэв.

**Р.Сэддорж:** 1.Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 7

Бүгд: 18

61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.“Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 7

Бүгд: 18

61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 15 цаг 36 минутад хэлэлцэж дуусав*

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 4 цаг 23 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 76.0 хувийн ирцтэйгээр 15 цаг 36 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:

ЭДИЙН ЗАСГИЙН

БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ

ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр,  
Мягмар гараг  
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим  
11 цаг 13 минут.

### ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Р.Сэддорж:** Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя. Хуралдаанд Алдаржавхлан, Батболд, Батчимэг, Батшугар, Ж.Ганбаатар, Лодойсамбуу, Лувсанжамц, Мандхай, Мөнхсоёл, Соронзонболд, Ундраа, Цогтгэрэл, Сэддорж нарын гишүүд хүрэлцэн ирсэн байна. Ирц 52 хувьтай байна. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 52 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.  
1.Монголбанкны хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны талаарх Монголбанкны Ерөнхийлөгч, Монголбанкны хяналтын зөвлөлийн мэдээллийг сонсох.  
2.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, ЗГ-аас 2025 оны 3 дугаар сарын 26-ны өдөр өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэх. 3.Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төсөл Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх тухай. Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Алга байна хэлэлцэх асуудалдаа оръё.

#### Нэг.Монголбанкны Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны талаарх Монголбанкны Ерөнхийлөгч, Монголбанкны Хяналтын зөвлөлийн мэдээллийг сонсох

Хэлэлцэх асуудал нэг. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 116 дугаар зүйл, Монголбанкны хяналтын зөвлөлийн ажиллах журам батлах тухай Улсын Их Хурлын 2003 оны 39 дүгээр тогтоолыг үндэслэн Монголбанкны Ерөнхийлөгчөөс ирүүлсэн санал болон Монголбанкны Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны талаарх Монголбанкны Хяналтын зөвлөлийн мэдээллийг хэлэлцэж эхэлье. Монголбанкны Дэд ерөнхийлөгч Энхтайван танилцуулна микрофоныг нээе. 4 Номер.

**Г.Энхтайван:** Байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Монголбанкны хяналтын зөвлөлийн 2025 оны эхний улиралд Хяналтын зөвлөл 7 удаа хуралдсан. Тэгээд үүн дээр холбогдох үйл ажиллагааны тайлангуудыг Монголбанкны удирдлагатай.../үг тасрав/

**Р.Сэддорж:** Энхтайван Ерөнхийлөгч түр хүлээж байгаарай. Манай Эдийн засгийн байнгын хороонд Монголбанкны Ерөнхийлөгчөөс Улсын Их Хурлаас баталсан 2003 оны 39 дүгээр тогтоолоор баталсан Монголбанкны хяналтын



зөвлөлийн ажиллах журмын 6.2-т заасны дагуу шинээр томилогдсон Монголбанкны хяналтын зөвлөлийн даргад сар бүр 2 сая төгрөг, хяналтын зөвлөлийн ажлын албаны гишүүдэд сар бүр 1 сая 800 мянган төгрөгийн цалин хөлс олгох энэ саналыг ирүүлсэн. Тэгээд энэ саналын талаар Энхтайван Ерөнхийлөгч танилцуулга хийх юм.

**Г.Энхтайван:** Эдийн засгийн байнгын хорооны гишүүдийн амгаланг айлтгая. Монголбанкны Ерөнхийлөгчөөс Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд Хяналтын зөвлөлийн үйл ажиллагаатай холбогдуулан Хяналтын зөвлөлийн дарга, гишүүдийн, шинээр томилогдсон дарга, гишүүдийн цалинтай холбоотой танилцуулгыг хүргүүлсэн байгаад байгаа. Хяналтын зөвлөл түрүүн Байнгын хорооны даргын хэлж байгаагаар хяналтын зөвлөлийн дарга нь 2 сая төгрөг, хяналтын зөвлөлийн гишүүд 1 сая 800 мянган төгрөгийн цалин олгох саналтай байгаад байгаа. Энэхүү саналыг Монголбанкны хувьд урьд нь Хяналтын зөвлөлийн гишүүдийн авч байсан цалин өөрчлөгдөөгүй 10 жилийн хугацаанд үргэлжлээд явсан байгаад байгаа. Энийг тэгээд сүүлийн 10 жилийн инфляцын дундажтай уялдуулан тодорхой хэмжээнд нэмэгдүүлээд энэ саналыг оруулж ирсэн.

**Р.Сэддорж:** Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга Нинжбатын Ууганбаатар мэдээлэл хийнэ. Микрофоныг нээе. 3 номер.

**Н.Ууганбаатар:** Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Би уг нь хэдэн слайдтай ирсэн, слайдууд маань гарах болов уу? Би товчхон өнгөрсөн 1 дүгээр улирлын Монголбанкны хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны талаар товчхон танилцуулга хийе. Энэ хүрээнд үндсэндээ би 4 асуудлыг авч үзнэ. 1 дүгээрт хяналтын зөвлөлийн хурлаар бид юуг хэлэлцэв, 2 дугаарт Монголбанкин дээр байгаа нөхцөл байдалтай танилцаад гаргасан үр дүнгүүд юу байна вэ, дараа нь Монголбанканд өгөхөөр хүлээгдэж байгаа зөвлөмжүүд маань юу байх вэ, тэгээд сүүлд нь бид нарыг томилох үед зээлийн хүүгийн тухай асуудал нэлээн яригдсан учраас өнгөрсөн хугацаанд өнгөрсөн 3 сарын хугацаанд бид зээлийн хүүг бууруулах чиглэлд авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн талаар тодорхой хэмжээний судалгаа хийсэн байгаа. Тэр судалгаагаа урьдчилаад ерөнхийд нь танилцуулна. Ингээд 4 багц юуг танилцуулга хийх гэж байгаа юм.

Энэ яригдах бүх сэдвүүдтэй холбоотой та бүхэнд сануулах нь оновчтой гэж үзэж байгаа 3 хууль, эрх зүйн заалт байгаа. Энэ дээр яах вэ гэхээр Төв банк Монголбанкны тухай хуулийн 27<sup>1</sup> гэдэг заалт байгаа. Энд Монголбанкны хяналтын зөвлөлийн тухай 5 чиг үүргийг зааж өгсөн байдаг. Нэг нь Монголбанкны дотоод хяналтын үйл ажиллагаа, хөндлөнгийн аудитын санал зөвлөмжийн хэрэгжилт, хөрөнгө оруулалтын багц болон Монголбанкнаас санхүүгийн тайлангаа Улсын Их Хурал, олон нийтэд тайлагнаж, мэдээлж байгаа байдал, Монголбанкны зөвлөлийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавина гэсэн ийм 5 чиглэлийг хуульд бид зааж өгчээ. Ингээд энийг жоохон задлаад харвал эндээс юу байгаа вэ гэхээр 3 нь үндсэндээ тайлан баланс болон тэднийг мэдээлэхтэй холбоотой ийм асуудал байгаа. 2 нь арай жоохон бусдаасаа өөр түүн дотор юу орох вэ гэхээр Монголбанкны зөвлөлийн үйл ажиллагааны үр дүн болоод, хөрөнгө оруулалтын багц гэдэг бусдаас арай жоохон өөр байгаа. Нөгөөдүүл нь цэвэр аудиттай холбоотой, тайлан баланстай холбоотой ийм зүйлүүд байгаа. Дээрээс нь яах вэ гэхээр хөндлөнгийн аудитын санал зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавина гэж байгаа. Тэгэхээр энд бид нараас гарах зөвлөмжүүд ямархуу байдалтай байна вэ гэхээр хөндлөнгийн

аудитын өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэхийг зөвлөж байна гэсэн иймэрхүү байдлаар зөвлөмжүүд гарахаар иймэрхүү нөхцөл байдал харагдаж байгаа.

Дараагийн нэг чухал заалт Төв банкны Монголбанкны тухай хуулийн 38<sup>1</sup> дээр байдаг. Төв банкны алдагдалтай холбоотой энэ заалт Монголбанкны пассив нь актив хөрөнгөөс хэтэрсэн тохиолдолд ЗГ үнэт цаас гаргах замаар уг зөрөөг нөхөх асуудлыг Улсын Их Хурал шийдвэрлэнэ гэсэн нэг ийм заалт байгаа энэ рүү анхаарал хандуулахыг хүсэж байна та бүхнээс.

Дараагийн нэг асуудал Улсын Их Хурлын 2003 оны 39 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан Монголбанкны хяналтын зөвлөлийн ажиллах үйл ажиллагааны журам гэж байгаа. Энэ журам дээр нөгөө үндсэн 5 чиг үүргээ хэрхэн хэрэгжүүлэх вэ гэдэг тал дээр нарийвчилсан ийм заалтууд орсон. Гэхдээ зарим нэгэн 1 дүгээрт цаг үеийн асуудлуудтай холбоотой, үүнээс хойш 2003 оноос хойш Монголбанкны Төв банкны тухай хуульд маань өөрөө хэд хэдэн удаа өөрчлөлт орчихсон. Энэнтэй холбоотойгоор болон шинэ үүссэн нөхцөл байдалтай холбоотойгоор зарим нэгэн нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулах шаардлагатай болов уу гэсэн ийм дүр зураг харагдаж байгаа.

Ерөнхийдөө юу гэж заасан байх вэ Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр хурал байна. Хурлыг улиралд ядаж нэг удаа хуралдана. Зөвлөл яах вэ гэхээр дүгнэлт, санал, зөвлөмж гаргаад тэгээд тэрийгээ Монголбанкны удирдлагад хүргүүлнэ. Тэгээд үйл ажиллагааны талаар Улсын Их Хурал мэдээлнэ гэсэн ерөнхийдөө 1 иймэрхүү заалтууд байгаа. Дүгнэлт, санал зөвлөмж гурвуулаа нэг дор байгаа. Гэхдээ зөвхөн тухайлбал хөрөнгө оруулалтын багц дээр бид дүгнэлт гаргана. Бусад юмнууд дээр ерөнхийдөө санал, зөвлөмж гаргаад тэгээд тэр зөвлөмжөө Монголбанкны удирдлагад хүргүүлээд Монголбанкны удирдлага эргээд хэрэгжилтийг нь Хяналтын зөвлөлийн хуралд танилцуулдаг байхаар ийм зохицуулалтуудтай байгаа одоогийн эрх зүйн зохицуулалт бол. Нэгэнт үйл ажиллагааны үндэс нь хурал байна гэсэн учраас бид өнгөрсөн хугацаанд буюу 1 сарын 16-наас 3 сарын 31-ний хооронд 7 удаа хуралдсан байна. Улиралд нэг удаа хуралдах байсан. Энийг бид 7 хуралддагийн үндсэн шалтгаан 1 дүгээрт шинээр томилогдсонтой холбоотой. Дээрээс нь Монголбанк маань бүтэц, үйл ажиллагааны хувьд нэлээн өргөжсөн ийм юутай. Хуульдаа гуравласан мандат дээрээс 8 чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Дээрээс нь цаг үеийн нөхцөл байдалтай холбоотойгоор тэр 8 үндсэн чиглэл дээр нэмэгдээд магадгүй 3-аас 4 өөр үндсэн чиглэлүүд нэмэгдсэн байхаар ийм нэлээн өргөн бүтэцтэй их олон ажлыг хийдэг, олон функцтэй ийм байгууллага болж хувирсан байна.

Тэгэхээр энэ хооронд бид яах вэ гэхээр ер нь эхний ажил 24 онд хийгдсэн хяналтын зөвлөлийнхөө өмнөх хяналтын зөвлөлийн ажлын үр дүнтэй танилцаад, 25 оны ажлын төлөвлөгөөгөө боловсруулаад баталсан байгаа. Энийг та бүхэнд хавсралтаар хүргүүлсэн. Монголбанкны бүтцэд байдаг газар, албадтай бол танилцуулах ажлыг эхлүүлсэн, хийгээд энэ дунд шатандаа ороод явж байгаа. Энэ дотор дотоод аудит, хөндлөнгийн аудит, нөөцийн удирдлага, санхүү бүртгэл, хууль, эрх зүй, банкны хяналт шалгалт, банкны бүтцийн өөрчлөлт болон бодлогын газруудтай одоогийн байдлаар бид мэдээлэлтэй нь нарийвчлан танилцаад байж байна.

Дараагийн нэг тулгамдсан асуудал нөгөө үндсэн 5 үүргээ хэрэгжүүлэхийн тулд бид энийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд ер нь Монголбанкныхаа

удирдлагатай хэрхэн үр өгөөжтэй зохистой харьцаж ажиллах тухайгаа хэлэлцэх энийгээ тодорхойлох ийм шаардлага үүссэн. Энэ чиглэлээр тодорхой ахиц дэвшлүүд гарсан байгаа. Нэг чухал асуудал нь яах вэ гэхээр Төв банкны засаглал, бүтэц, зохион байгуулалтын өнөөгийн байдал энд бол олон улсын байгууллагуудаас өгч байгаа санал, зөвлөмж болон хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрүүдтэй танилцах ийм шаардлага үүссэн. Яагаад гэхээр ялангуяа ОУВС-ийн сүүлд өгсөн үнэлгээнүүд хяналттай холбоотой, манай хяналтын зөвлөлтэй холбоотой ийм нэлээн детальтай ийм дүгнэлтүүдийг зөвлөмжүүдийг өгсөн байсан. Тэгэхээр энэ болгонтой нарийвчлалтай танилцах ийм шаардлага үүссэн.

Дараагийн сүүлийн багц ажил яах вэ гэхээр бидний сонсголын үед нэлээн их яригдсан учраас энэ зээлийн хүүг бууруулах, зээлийн хүүг бууруулах чиглэлд 2011-ээс 23 оны хооронд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний агуулга, боловсруулсан аргачлал, үр дүнг бид судлан танилцчихаад байж байгаа.

Монголбанкны одоогийн нөхцөл байдалтай холбоотойгоор хөндлөнгийн байгууллагуудын өгсөн санал зөвлөмжүүд дотроос зарим нэгэн анхаарал татмаар зүйлүүдийг танилцуулъя. Энэ дотор юу байх вэ гэхээр ОУВС-гаас өгч байгаа түрүүчийн 2022 онд хийсэн энэ үнэлгээ дээр үндсэндээ 3, 4 чухал асуултыг хөндсөн байгаа. Нэг нь Төв банкны тухай хуулийн 4 дүгээр заалтад заасан энэ 4.1-д болон 4.2 дээр байгаа хос мандаттай байх энэ бол зохистой эсэх асуудлыг хөндсөн байна. ... гэж ярьдаг хагас төсвийн шинжтэй зарим үйл ажиллагааг санхүүжүүлсэн байна. Төв банкны Ерөнхийлөгчийг яах вэ гэхээр хуулийн хугацаанаас нь өмнө солих явдал түгээмэл байдаг гэдэг асуудлуудыг дүгнээд энд Монголбанкны хараат бус байдлыг эргэн харах шаардлага үүсэж байгаа талаар энэ тайлан дээр нэлээн дэлгэрэнгүй тусгасан байна.

Дараагийн нэг ажил Төв банкны засаглалд хамтын шийдвэр гаргах механизм дутмаг байгаа. Тэгээд хяналт тэнцэл алдагдсан, хяналтын хараат бус бүтэц дутмаг байгаа талаар нэлээн детальтай авч үзсэн байна. Хамтын шийдвэр гаргах хэсэг дээр 2018 онд орсон өөрчлөлтүүдээр зарим нэгэн юунуудыг ялангуяа хууль дээр байгаа 2 хороо Мөнгөний бодлогын хороо болон Хяналт шалгалтын хороон дээр шийдвэрийг хамтын шийдвэр гаргадаг болсон учраас тодорхой хэмжээний ахиц дэвшил гарсан хэдий ч одоо дутагдалтай байгаа хэсэг нь юу байна вэ гэхээр энэ дээр хяналт тэнцэл буюу дотоод хяналт нь хараат бусаар ажиллахгүй байгаатай холбоотой заалтуудыг зүйлүүдийг нэлээн нарийвчилж энэ тайлан дээр тусгасан байсантай бид танилцсан. Дараагийн нэг асуудал нь хуримтлагдсан алдагдлын асуудал байгаа. Энэ болохоор 23 оны аудитлагдсан тайлан дээр 7,4 их наяд төгрөгийн хуримтлагдсан алдагдал байгаа. Тэгээд түрүүчийн миний дурдаад эшилсэн 38<sup>1</sup> дүгээр заалт өнөөдрийг хүртэл хэрэгжээгүй байна гэдэг зүйлийг ОУВС-ийн тайлан дээр тодорхой бичсэн байсан.

Хөндлөнгийн аудитын 2023 оны тайланг харвал энэ дээр байгаа нэг асуудал нь 25 онд гүйлгээнд гараад 38 онд татан төвлөрүүлсэн зэс мөнгөн зоосны асуудал байгаа. Энийг 18 онд дахин үнэлгээ хийгээд, тэгээд Монголбанк маань яах вэ гэхээр Эрдэнэсийн санд буюу өөрийн актив хөрөнгөд бүртгэсэн байдаг. Энэ дээр 2 асуудал гарч ирдэг. 1 дүгээрт банк өөрийнхөө ... хийсэн зоосыг актив дээрээ бүртгэх тухай асуудал шууд ингэх боломжгүй. Энэ дээр ямар 3 дахь этгээд оролцсон байх ёстой. Тэгээд тэрийгээ баримтаар нотлох ёстой гэдэг зүйлийг хөндлөнгийн аудит хөндөж тавьдаг.

Дараагийн асуудал нь яах вэ гэхээр энэ үнэлгээтэй холбоотой нэг асуудал яригдаг. Ерөнхийдөө энэ заалтаас болоод Монголбанкны хөндлөнгийн аудит бол хязгаарлалттай гэдэг дүгнэлтийг сүүлийн жилүүдэд өгөөд явж байгаа. Дараа нь 12-оос 23 оны хооронд он дараалан алдагдалтай ажилласан зүйл байна. 23 онд 5 жилд нэг удаа хийгдэх ёстой байсан зарим хөрөнгийн үнэлгээг хийгээгүй байсан гэдэг ийм дүгнэлтийг өгсөн байсан. Энийгээ 24 онд Монголбанк сайжруулсан гэж бидэнд мэдээлсэн. Хөндлөнгийн санал, дүгнэлт нэг иймэрхүү.

Түрүүчийн нөгөө 38.1 дүгээр заалттай холбоотойгоор энэ 2011 онд тухайлбал анх алдагдалтай гараад, энийгээ яах вэ гэхээр тухайн үеийн Ерөнхийлөгч Пүрэвдорж Ерөнхийлөгч Эдийн засгийн байнгын хороонд мэдээлээд, тэгээд энийг нь Эдийн засгийн байнгын хороо маань тухайн үеийн Эдийн засгийн байнгын хороо маань хэлэлцээд тэгээд шийдвэрлэсэн буюу 11 оны үйл ажиллагааны үр дүнг Монголбанкны 10 оны алдагдлыг асуудлыг гаргалгүйгээр түр хүлээх ийм шийдвэр гаргаад байна гээд орхичихсон байгаад байгаа. Тэгээд түрүүчийн тэр 38.1 дүгээр заалт эффективный байдлаар үр дүнтэйгээр ер нь хэрэгжихгүй байна уу даа гэсэн ийм зүйл харагдаж байгаа юм.

Манайх болохоор Хяналтын зөвлөл өөрөө юу гэж үзэж байна вэ гэхээр 1 дүгээрт Төв банкны тухай хуулийн энэ 38<sup>1</sup> дүгээр заалтыг хэрэгжүүлэх талаар эрх бүхий байгууллагуудтай Монголбанкны хамтран идэвх чармайлт гаргаж ажиллаасай гэсэн ийм зөвлөмжийг хүргүүлэх бодолтой байгаа. Энэ дээр дахиад эргэж харах ёстой зүйлүүд бий. Тухайлбал 38.1 хуримтлагдсан алдагдал биш, тухайн жилийн алдагдалтай холбоотой ч гэдэг юм уу хуулийн ийм нарийн ширийн асуудлууд давхар хөндөгдөхөөр харагдсан. Түрүүний ярьсан нөгөө зоостой холбоотой хөндлөнгийн аудитын өгсөн зөвлөмжийг бид хэрэгжүүлэх нь зүйтэй болов уу гэсэн ийм байр суурь дээр байгаа. Энийг манай өмнөх хяналтын зөвлөл мөн ялгаагүй Төв банкны удирдлагад ийм зөвлөмжийг хүргүүлсэн байдаг.

Дараагийн нэг асуудал нь эрсдэлийн удирдлагын нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх ийм шаардлагатай байна. Тэр дундаа магадгүй ОУВС-ийн элерик гээд аргачлал байдаг гэдэг юм уу иймэрхүү аргачлалуудыг хэрэглээд эрсдэлийн удирдлагын системийг цогцоор нь эргэн харж, энэ дээр боловсронгуй болгох талаар илүү идэвхтэй ажиллах ийм зөвлөмжийг хүргүүлэхээр бодож байгаа Засаглалын хяналт тэнцлийг хангах буюу дотоод аудит, дотоод хяналтын үйл ажиллагааны бие даасан хараат бус байдлыг хангаж, дотоод хяналтын үйл ажиллагааны үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр анхаарч ажиллах нь зүйтэй болов уу гэсэн ийм зөвлөмжийг хүргүүлж байгаа. Тэгээд яах вэ дотоод аудитын газар болон эрсдэлийн удирдлагын алба зэрэг үндсэн чиг үүргийн газруудад орон тоо дутуу ажилладаг ийм зүйл анзаарагдсан. Хэдийгээр нийт хүний орон тоо нь хүний тоо нь магадгүй нэлээн их байгаа ч гэсэн яг үндсэн чиг үүргийн газрууд нь жоохон орон тоо дутуу яваад байгаа ийм дүр зураг харагдсан. Тэгээд энэ дээр анхаарах нь зүйтэй гэж үзэж байгаа.

Дахиад бидний танилцах явцад юу ажиглагдсан бэ гэхээр зарим нэгэн чиг үүргийн давхцал байгаа юм болов уу гэж харагдсан. Мөнгө угаахтай тэмцэх хяналт шалгалтын ажиллагаа яах вэ гэхээр нэг талдаа банкны хяналт шалгалтын газар нэг хэлтэс байгаад байгаа, нөгөө тал нь санхүүгийн мэдээллийн алба гээд бие даасан нэг нэгж байгаа. Тэгээд энэ 2 дээр хоёулан дээр нь яах вэ гэхээр мөнгө угаахтай тэмцэх гэдэг чиг үүрэг тухайлбал байгаа. Нөгөө талд нь энэ цаг үед магадгүй чухал болж ирж байгаа ногоон тогтвортой хөгжлийн талаарх ийм нэгдсэн ийм юу

бол нэгдсэн бодлого арай дутмаг байна уу, хэсэгчлээд энд, тэнд орчихсон байгаа юм болов уу гэсэн иймэрхүү зүйлүүд ажиглагдсан. Тэгэхээр бид яах вэ гэхээр энэ зөвлөмжүүдээ эцэслээд энэ 4 сард хурлаараа эцэслээд, Монголбанкны удирдлагад хүргүүлэхээр одоогийн байдлаар урьдчилаад гаргачихсан байгаа. Манай хяналтын зөвлөлөөс өгч байгаа зөвлөмжүүд эдгээр байна.

Ингээд үйл ажиллагаа явуулахад ерөнхийдөө ямархуу сорилтууд тулгамдахаар цаашид харагдаж байна вэ гэхээр 1 дүгээрт түрүүчийн ярьсан ОУВС-ийн хараат бус байдлын үнэлгээ дээр манай хяналтын зөвлөлийн тухай нэлээн олон зүйл орсон. Энийг багцлаад хэлбэл манай Монголбанкны хяналтын зөвлөл нь бусад орны Төв банкнуудын хяналтын зөвлөл болон аудитын хороо зэрэг хяналтын чиг үүрэг бүхий этгээдүүдтэй харьцуулахад эрх зүйн хувьд хангалттай бус, сул бөгөөд Монголбанкны удирдлагатай нэгэн адил эрх зүйн хариуцлага хүлээхгүй байгаа гэдэг ийм зүйлийг хэлж байгаа.

Дараа нь санхүү банкны олон улсын болон хувийн байгууллагуудын жишгээр ингээд харвал аливаа хяналтын зөвлөл нь дотоод аудит хяналтыг бүрэн хариуцахаас гадна байгууллагын жилийн төсвийг баталдаг, удирдлагын багийн цалин урамшууллын тогтоох зэрэг эрх, үүргийг хэрэгжүүлдэг ийм олон улсын жишиг байгаа. Энэ асуудлыг мөн 2018 онд Төв банкны тухай хуулийн өөрчлөлт яригдаж байх үед тухайн үеийн Улсын Их Хурлын гишүүд зарим Дэмбэрэл гэх мэтийн гишүүд хөндөж ярьж байсан ийм баримтууд байна. Одоо ажиглаж байгаа бол манайд нөхцөл байдал яг эсрэгээрээ Хяналтын зөвлөлийн тухайлбал цалинг Монголбанк болон Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо нь тогтоодог энэ ерөнхий жишиг нөгөө тал руугаа байх жишээтэй.

Манай өмнөх Хяналтын зөвлөл буюу 18-аас 24 онд ажилласан Хяналтын зөвлөл хурлаараа энэ үйл ажиллагааны журам, хяналтын зөвлөлийн чиг үүргийг 2003 оны журам маань хангалтгүй байгаа, хүрэлцээтэй бус байгаа талаар их олон удаа хуралдаж тодорхой санал зөвлөмжийг Төв банкны тухай хуульд тусгуулахаар Төв банкны Хууль, эрх зүйн газарт хүргүүлсэн ийм олон баримтууд байгаа. Цаашид бид 25 ондоо ерөнхийдөө юу хийхээр харагдаж байна вэ гэхээр 1 дүгээрт холбогдох хууль журамд нийцтэй байдлаар хяналтынхаа үйл ажиллагааг тогтмол, тэгээд Монголбанкны үйл ажиллагаанд аль болох хүндрэл учруулалгүйгээр хэрэгжүүлээд, хараат бусаар санал, зөвлөмжөө гаргаад танилцуулах энэ ажлыг хийнэ.

Зөвлөлийн гаргасан дүгнэлт, зөвлөмжийн тэнцвэрт байдал болон шийдвэрийн хэрэгжилтийн үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэх зорилгоор бид юу төлөвлөж байгаа вэ гэхээр Монголбанкны удирдлагатай буюу захирлын зөвлөлтэй улирал бүр тогтмол хурал хийдэг байхаар иймэрхүү жишиг тогтоохоор ажиллаж байгаа. Энэ талаар Монголбанкны удирдлагатай Ерөнхийлөгчтэй тохиролцсон. Ер нь өмнөх үе үеийн зөвлөл болон бидний энэ үед тулгарах сорилтыг даван туулах, магадгүй үйл ажиллагаагаа боловсронгуй болгох, дахиад түрүүнээс түрүүн ярьсан миний Төв банкны хяналт, засаглалын тогтолцоог шат ахиулах зорилгоор бид магадгүй Төв банкны тухай хуулийн 27<sup>1</sup> заалт болон 2003 онд батлагдсан Зөвлөлийн үйл ажиллагааны журамд өөрчлөлт оруулах саналыг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороондоо хүргүүлж гэж бодож. Энэ дээр дахиад гол ажил яах вэ гэхээр хяналт тэнцлийг хангах, хяналтын хараат бус байдлыг нэмэгдүүлэх талаар ажиллах нь зөв болов уу гэж ерөнхий чиглэлийн хувьд бодож байгаа.

Нөгөө нэг асуудал бол зээлийн хүү дахиад, 11-ээс 23 онд хэрэгжүүлсэн зээлийн хүүг бууруулах 4 бодлогын баримт бичиг байгаа. Эд нарын талаар дүгнэлт гаргаад, Улсын Их Хурал болон Монголбанкны удирдлагадаа бид хүргүүлээд, энэ чиглэлд магадгүй дараагийн 5 дахь бичиг баримт боловсруулагдах байх. Энэ дээр бид тодорхой саналаа өгөхөөр ингэж төлөвлөөд ажиллаж байгаа. Зээлийн хүүг бууруулах чиглэлд ер нь юу хийгдэж вэ гэдэг дээр би, бид урьдчилсан байдлаар танилцсан дүнтэйгээ бол дүнгээсээ та бүхэндээ хуваалцъя. Энэ дээр би түрүүн хэлсэн 11-ээс 23 оны хооронд ийм 4 том бодлогын бичиг баримтыг баталжээ. Эхнийх нь 11-ээс 13 оны хооронд зээлийн хүү бууруулах эдийн засгийн болон хууль, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх хөтөлбөр гэж баталсан байна. 14-өөс 16 оны хооронд зээлийн хүү бууруулах, зах зээлийн орчныг бүрдүүлэхэд чиглэсэн 14-өөс 16 онд хэрэгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр гэж баталсан байна. 18-аас 23 оны хооронд зээлийн хүү бууруулах стратеги гэж баталсан байна. 20-оос 23 оны хооронд зээлийн хүү бууруулах стратеги гэж баталжээ.

Эдгээрээс эхний 3-ыг нь ерөнхийдөө Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүд, дээрээс нь магадгүй тухайн үеийн эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж байсан сайдын оролцоотойгоор хамтын тушаал хамтарсан тушаал маягаар баталж боловсруулсан байдаг бол сүүлийн 20-оос 23 онд хэрэгжүүлэх стратегийг Улсын Их Хурлын тогтоолоор баталсан байгаа юм. Эдгээр 4 бичиг баримт нь нөгөө талаасаа юутай нийцтэй байна вэ гэхээр 4 Төв банкны Ерөнхийлөгчийн юутай холбоотой хугацаатай нийцтэй байгаа. Эхнийх нь бол магадгүй Пүрэвдорж Ерөнхийлөгчийнх, дараагийнх нь Золжаргал Ерөнхийлөгчийн үед, дараагийнх нь Баярсайхан Ерөнхийлөгчийн үед, сүүлийнхийг нь Лхагвасүрэн Ерөнхийлөгчийн үед ингээд баталсан байна. Үүгээр юу баримт бичиг болгондоо ерөнхийдөө юу хийгдчихэв гээд харвал ерөнхийд нь харахаар макро орчныг сайжруулах, инфляцыг бууруулах, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, банкны салбарт шударга өрсөлдөөнийг бий болгох, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, мөнгөний бодлогын нөлөө нэмэгдүүлэх эхний бичиг баримтын гол агуулга тиймэрхүү. Дараа нь мөн ялгаагүй үнэ тогтворжуулах, инфляц бууруулах, банкны шударга зохистой байдалд анхаарах, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, эрх зүйн орчны бусад зохицуулалтууд тухайлбал барьцаа хөрөнгөтэй холбоотой хөдлөх хөрөнгө, ипотек, зээлийн батлан даалтын сан гэх мэт энэ зүйлүүдийг тусгасан байна.

Инфляцыг бууруулах асуудал үе үеийн юун дээр байгаа стратеги дээр байгаа. Мөнгөний бодлогын нөлөөг нэмэгдүүлэх, тэгээд макро эдийн засаг, банк санхүү гэсэн ийм 3 тулгууртайгаар 11 зорилттойгоор 18-аас 23 оны хөтөлбөр батлагдсан. 20-оос 23 оны хамгийн сүүлийн хөтөлбөр үндсэндээ банкны засаглалыг сайжруулах гэж нэг том багц байгаа. Эрсдэл даван туулах чадварыг нэмэгдүүлэх, шүүх болон эрх зүйн орчинд шаардлагатай өөрчлөлтийг оруулах, улмаар чанаргүй зээлийг бууруулах гэсэн иймэрхүү зүйлүүдийг тусгагджээ. Ингээд харахаар үндсэндээ маш товчоор энэ зээлийн хүү бууруулах стратегиудын цаад талын үндсэн логик нь юунд байна вэ гэхээр тэр дээр бичсэн ганц тэгшитгэл дээр ерөнхийдөө суурилж явж байгаа.

Суурь судалгаанууд хийгдсэн байдаг. Түүн дээр яах вэ гэхээр зээлийн хүү бол юутай тэнцүү байна вэ гэхээр нэг талдаа эх үүсвэрийн зардал, нөгөө талдаа банкны нэмэгдэл гэсэн энэ 2 рүү салгаад, энэ эх үүсвэрийн зардал гэдэгт нь яах вэ гэхээр дандаа салбар дундын бөгөөд ерөнхий эдийн засгийн орчинтой холбоотой зүйлүүдийг оруулж байгаа юм. Тухайлбал инфляц, тухайлбал макро эдийн засгийн тогтвортой байдал гэх мэтийн салбар дундын ерөнхийдөө санхүүгийн зах зээлийн

хөгжил гэдэг юм уу иймэрхүү нэлээн макро түвшний үзүүлэлтүүд бол энэ эх үүсвэрийн зардалд шууд нөлөөлж байна гэж ингэж үзэж байгаа юм. Нөгөөдөх нь банкны нэмэгдэл гэдэг нь илүү банкны сектортой холбоотой, банк илүү үр ашигтай ажиллах юм бол энэ дээр бид тодорхой хэмжээний бууруулалтууд сайжруулалтууд хийх боломжтой гэсэн ийм байдлаар хандаж байгаа. Ингээд харахаар үндсэндээ эхнийх нь хэсэг дээр салбар дундын зохицуулалтууд хийгдэх ёстой, 2 дахь хувьсагч дээр илүү Монголбанкны зохицуулалтаар хийгдэх ёстой ийм ажлууд ажлууд эндээс цаашаа ингээд задарч гарч ирж байгаа юм.

Тэгэхээр зээлийн хүүг бууруулна гэвэл энэ 2-ын аль алийг нь бууруулна. Тэгээд аль дээр нь бууруулах ямар орон зай байна вэ гэдэг байдлаар ингэж хандаж энэ стратегиудыг боловсруулсан байна. Түрүүн би хэлсэн макро эдийн засгийн орчныг сайжруулах, инфляц бол бүх зээлийн юун дээр байгаа зээлийн хүүгийн стратеги дээр байгаа. Санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх гэдэг зүйл юу бол стратеги бол бодлогын энэ бол бүгд дээр нь тусгасан байгаа. Банкны үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлд, дээрээс нь банкны итгэлцлийг нэмэгдүүлэх гээд энэ дээр иймэрхүү ерөнхий зүйлүүд бүгдэд нь тусгагдсан байгаад байдаг. Ингээд харахаар эцсийн дүндээ юу болчихсон байж болох байна вэ гэхээр ер нь 4-ийн 4 стратеги байгаа. Тэгээд энийг ингээд уншаад үзвэл маш олон шийдлүүд санал болгосон байна. Хэрэгжилт нь харьцангуй арай жоохон бага байна уу гэж харагдсан. Нөгөө олон шийдэлтэйгээ харьцуулах юм болбол. Энэний цаана олон шалтгаанууд байгаа байх. Магадгүй түрүүчийн нөгөө тэгшитгэлээ харахаар эх үүсвэрийн зардлыг бууруулах чиглэлд авах арга хэмжээнүүд магадгүй богино хугацаанд хэрэгжих нь тийм үр дүнтэй биш байж мэдэхээр боломжгүй байж хэцүү байж мэдэхээр иймэрхүү зүйлүүд тусгасан.

Банкны хэсэг дээр нэлээн олон реформууд хийгдсэн гэдгийг та бүхэн мэдэж байгаа байх. Тэгэхээр олон шийдэлтэй хэр нь цөөвтөр хэрэгжилттэй байгаа юм болов уу гэсэн эхний дүгнэлт гарч ирж байгаа. Ингээд харахаар дахиад дараагийн магадгүй өмнөх стратеги маань 23 онд хэрэгжиж дуусчихсан гэж үзэж байгаа учраас шинэ стратеги боловсруулах шаардлага үүсэх байх. Энэ дээр өмнөх аргачлалаа бид нэг эргэн хармаар, үнэлгээ хиймээр санагдсан. Түрүүний миний дурдаад байсан удаа дараа тусгагдсан хэдий ч хэрэгжээгүй эсвэл хагас хэрэгжээд байгаа энэ арга хэмжээнүүдийг дахиад тусгах эсэх дээрээ бодмоор юм болов уу гэж бодсон. Ер нь нөгөө урд талын хувьсагч буюу эх үүсвэрийн зардлыг бууруулах чиглэлд энэ салбар дундын шийдвэрүүд уялдаануудыг хангах зайлшгүй шаардлагатай байгаа юм шиг санагдсан. Түүн дээр зөвхөн Монголбанк ганцаараа ажиллаад энэ буурахгүй юм байна гэсэн ийм дүгнэлт гарсан. Энэ дээр энийг хангуулах чиглэлээр хяналт тавьж ажиллах нь зөв юм болов уу гэж бодсон.

Тэгээд сүүлд нь магадгүй дахиад дараагийн бид юуг батлахдаа стратегийг батлахдаа ер нь энэ авч хэрэгжүүлэх арга хэмжээгээ 1 дүгээрт хэрэгжүүлэхэд боломжтой эсвэл нэлээн хугацаа орох гэдэг өнцгөөс нь нэг хараад, үр дүн нь шууд байна уу, дам нөлөөтэй байна уу гэдгээр нь нэг харж байгаад тэгээд шууд нөлөөтэй.../үг тасрав/

**Р.Сэддорж:** Ууганбаатар дарга товчлоорой.

**Н.Ууганбаатар:** За дууслаа. Илүү их анхаарлаа өгөх ёстой юм болов уу гэмээр иймэрхүү дүр зураг ажиглагдсан. Миний илтгэл дууслаа. Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Р.Сэддорж:** Баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя. Монголбанкны Дэд ерөнхийлөгч Энхтайван, Монголбанкны хяналтын зөвлөлийн дарга Ууганбаатар, Монголбанкны хяналтын зөвлөлийн гишүүн Эрдэнэбаяр, гишүүн Т.Тэлмэн, гишүүн Г.Тэлмэн, Хяналтын зөвлөлийн гишүүн Энхжаргал, гишүүн Хосжаргал. Монголбанкны Дэд Ерөнхийлөгч болон Монголбанкны хяналтын зөвлөлийн мэдээлэлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье. Лувсанжамц гишүүнээр тасаллаа. Батболд гишүүнээр тасаллаа. Ж.Ганбаатар гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**Ж.Ганбаатар:** Баярлалаа. Энэ Монголбанкны хяналтын зөвлөлийг ажил хийх бололцоог нь гаргах ёстой энэ зөв асуудал орж ирж байна. Тэгээд хэлэлцэхээсээ өмнө нэг цалингийн юм ярих юм. Энэ яаж байгаа юм бэ? Цалин яриулж Их Хурлын гишүүдийг хэрэлдүүлэх гэж байгаа юм уу? Энхтайван юу яриад нэг сонин юм яриад нэг цалин яриад байх юм. Тэр Ууганбаатар энийгээ мэдэж байсан юм байгаа биз дээ, энэ чинь тэгээд үйл ажиллагаа явуулах нөхцөл бололцоо энэ тэрээ хангах гэж хуульд өөрчлөлт орох гэж байгаа юм байгаа биз дээ? Журамд юм уу? Тэгэхээр Монголбанк нэг хяналтаа ажиллуулах сонирхолгүй байна даа. Наад нэг алдагдлыг чинь бүүр намайг Эдийн засгийн байнгын хорооны дарга байхад жил болгон л энэ жил хийнэ, энэ жил хийнэ. Тэр Ерөнхийлөгч хаачсан юм бэ? Маргааш хийнэ, маргааш хийнэ, энэ жил хийнэ, одоо алдагдалгүй болно л гэсэн. Тэгээд 7,4 их наядын алдагдалтай.

Тэгээд наад энэ хяналтын зөвлөлтэй болоод энэ ер нь өмнө нь байж байсан зөвлөлөө зүгээр өөрсдөө зүгээр л нэг тийм юуны төдий ажиллуулдаг. Энэ зөвлөл сайн ажиллах гэж байгаа нь сайн байна. Тэр битгий хэл энэ Их Хурлаас хяналт шалгалт ер нь оруулах хэрэгтэй. Эдийн засгийн байнгын хороо юм уу, Их Хурал юм уу. Тэгэхгүй бол энэ эдийн засгийн нөхцөл байдлаа ер нь хар даа. Эхний 2 сарын байдлаар энэ орлогын албан татвар, Амнат 2 бол ёстой бүүр маш их хэмжээгээр буусан байна шүү дээ 24 онтой харьцуулахад, 23 онтой ч гэсэн харьцуулахад. Тэгээд юу өссөн байгаа юм гэхээр зүгээр НДШ өссөн байгаа юм. Энэ юу харуулж байна гэвэл ААН-үүд хөөрхий нэг юм ажиллаад байна гэсэн үг. Нэмэгдсэн өртгийн албан татвар, НӨАТ өссөн байгаа юм. Өссөн биш нэг хэмжээндээ. Орлогын албан татвар маш их хэмжээгээр буусан. Энэ маш том юмны дохио шүү. Энхтайван Ерөнхийлөгч, энэ Лхагвасүрэн 2 мэдэж байгаа энийг. Тэр нэг алт урьдчилж зараад ч юм уу хоёр, гурван зуун сая доллар оруулаад нэг их юм болохгүй дээ. Нэг их том өөрчлөлт ер нь гарахгүй. Эрс шинэчлэлт өөрчлөлт оруулах л хэрэгтэй. Тэгээд энэ Ууганбаярын тайлан нэг л тийм бүрхэг, яг юу гээд байгаа нь мэдэгдэхгүй нэг тийм. Сайн гээд байгаа юм уу, муу гээд байгаа юм уу, энүүгээрээ явъя гээд байгаа юм уу, энүүгээрээ явахгүй гээд байгаа юм уу тодорхой хэлэх хэрэгтэй байна шүү дээ. Тэгээд та бүхнийг анх байгуулаад явж байхдаа их л олон юм хүссэн байгаа даа.

Энэ 3 ханштай байна доллар. Энэ арван хоёрхон секунд үлдсэн байна. Энэ ер нь Монголбанк нэг ийм хомсдолын үеэр далимдуулж янз янзын юм гаргадаг ийм юутай шүү. Би нэг минутаа авчихъя.

**Р.Сэддорж:** Ганбаатар гишүүн 1 минут.

**Ж.Ганбаатар:** Энэ хомсдолыг далимдуулж янз янзын дээр, дооргүй янз янзын асуудал үүсдэг шүү. Юу ярьж байгааг ойлгож байгаа байх. Энэ хяналтын зөвлөл энэ дээр маш сайн анхаараарай. Зарим нөхцөлд ер нь хомсдолыг удаан



байлгах сонирхолтой ч байхыг үгүйсгэхгүй. Хаана хаанаа энийг сайн анхаарахгүй бол энэ үеэр чинь далимдуулж янз янзын юм гардаг, ханшийг бараг 4, 5 ханштай болгохыг зорьдог байхыг ч үгүйсгэхгүй шүү. Тийм учраас хяналтын зөвлөл сайн ажиллах хэрэгтэй. Их Хурал хяналт шалгалт сайн явуулах хэрэгтэй. Яаж давах вэ, яаж давж гарах вэ гэдгийгээ маш сайн тооцоолох хэрэгтэй. Энэ чинь бүүр тусдаа байгууллага шүү дээ. Хэний ч хараанд биш. Энийгээ барих хэрэгтэй шүү. Их энгийн, би Энхжаргал энэ тэрийг сайн мэднэ. Энийгээ тэгээд ажлаа хий, өөрсдөө энэ салбарын хүмүүс ажлаа сайн.../минут дуусав/

**Р.Сэддорж:** Саяын би эхлээд нэг ирсэн бичгээ тайлбарлачихъя. 2025 оны 3 сарын 21-нд энэ саяын хүсэлт ирсэн Монголбанкны Ерөнхийлөгчөөс. Энэ нь Монголбанкны хяналтын зөвлөлийн ажиллах журам батлах тухай Улсын Их Хурлын 2003 оны одоогоос 22 жилийн өмнөх 39 дүгээр тогтоолын хавсралтын 6.1 дэх заалтад Хяналтын зөвлөлийн дарга, гишүүдэд түүний Хяналтын зөвлөлийн ажилд оролцсон байдлыг харгалзан ажлын хөлс олгох бөгөөд түүний хэмжээ, ажлын хөлс, олгох журмыг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороотой зөвшилцөн Монголбанкны Ерөнхийлөгч батална гэж заасны дагуу саналаа ирүүлсэн байна. Нэмэлт асуултад хариулъя. Хэн бэ? 4 номер.

**Г.Энхтайван:** Ганбаатар гишүүний асуултад тодруулъя. Хяналтын зөвлөлийн үйл ажиллагаатай холбогдуулсан хяналтын зөвлөлийн үйл ажиллагааг хэвийн горимоор явуулахтай холбогдуулсан тэр цалин хөлсний асуудлыг Эдийн засгийн байнгын хороотой зөвшилцөх үүрэгтэй Монголбанк. Яг энэ хүрээнд Монголбанкны Ерөнхийлөгч маань энэхүү албан бичгийг илгээсэн гэж ойлгосон.

Гишүүний тэр ханштай холбоотой асуудал дээр тайлбар хэлье. Өнгөрсөн 2024 оны эцсээр Монгол Улсын валютын нөөц 5,5 орчим тэрбум доллартой гарсан. Яг өнөөдрийн байдлаар нөөц 4,7 тэрбум орчим доллартой байна. Энэ нь юуг илэрхийлж байна гэхээр яг өнөөдрийг хүртэл төлбөрийн тэнцэл 800 орчим сая долларын алдагдалтай гарсан байна гэсэн үг. Оны эхний 2 сарын байдлаар төлбөрийн тэнцэл 717 сая ам.долларын алдагдалтай гарсан. Тэгэхээр төлбөрийн тэнцлийн алдагдал гэдэг маань өөрөө ханшийг богино хугацаанд сулруулах тийм эрсдэлийг дагуулж байгаа. Тэгээд Төв банкны зүгээс энэ төлбөрийн тэнцлийн алдагдлыг бууруулах, төлбөрийн тэнцлийн болзошгүй хямралаас сэргийлж 3 дугаар сард Мөнгөний бодлогын хороо хуралдаад, бодлогыг хүүг мөнгөний бодлогын орон зайгаа чангаруулсан байгаад байгаа.

Тэгэхдээ мөнгөний бодлогын орон зай чангарснаар энэхүү болзошгүй эрсдэлээс бүрэн сэргийлж чадахгүй. Нэг талаасаа бид бүхэн гарах урсгал дээр импортын хэрэглээг хязгаарлах тийм саналуудыг ЗГ-т тавьж байгаа. Нөгөө талаасаа валютын орох урсгал дээр бид бүхэн өөр өөрсдийн бололцооны хүрээнд зохицуулалтуудыг хийж явж байгаа. Энэ дээр бид бүхэн Хадгаламжийн даатгалын корпорацын гадаад бонд эзэмшиж байсан хэмжээг буцааж дуудаж оруулж ирж байгаа. Энэ хүрээнд 230 орчим сая долларыг оруулж ирнэ. Мөн арилжааны банкнуудыг гадаад эх үүсвэрээс хямд өртөгтэй эх үүсвэр татаж, энийгээ эргээд зах зээл дээр нийлүүлж, валютын хомсдолыг арилгах чиглэлээр банкнуудтай бол бид бүхэн харилцан ярилцаад тохиролцоод явж байгаа.

Ханшийн хувьд 8 шаргын ханш, арилжааны банкны ханш бол зөрөөд явж байгаа гэдэг дээр Ганбаатар гишүүн анхаарал хандуулж байна. Энэ бол тийм маш эмзэг асуудал. Ийм параллель ханштай удаан явах юм бол мэдээж валютын

хомсдолын асуудал байдаг. Тэгээд энэ дээр параллель ханшийг аль болохоор богино хугацаанд бууруулах, энэ 2 ханшийг нийлүүлэх талаар бид бүхэн ажиллаад явж байгаа. Гэхдээ нөгөө талаасаа валютын орох урсгал хязгаарлагдмал байгаад байгаа. Үүнтэй холбогдуулаад Төв банкнаас зах зээл дээр нийлүүлж байгаа интервенцийг 100 хувь хангаж чадахгүй байгаад байгаа. Тэгэхээр энэ ханшийн асуудал бол мэдээж Төв банкны үндсэн үйл ажиллагааны хуульд заагдсан мандат биш. Гэхдээ бид бүхэн ханшийг тогтвортой барих үүднээс тогтвортой байлгах, огцом савлагаа үүсгэхгүйн зүгээс зах зээл дээр тохируулгуудыг хийгээд явж байгаа.

**Р.Сэддорж:** Хариулт хангалтгүй гэж үзэж байна. 1 минут Ганбаатар гишүүн.

**Ж.Ганбаатар:** Ханш чинь 1 битгий хэл, 2 битгий хэл 3, 4 ханш байгаа л даа. Тэр 2, 3 ханшны цаана ААН-үүд, хувь иргэд л хохирч байгаа. Зарим нэг нөхдүүд хонжоо олдог юм шүү. Энийг шалгах ёстой, энийг байхгүй болгох ёстой. Тэгээд ярьж байгаа зүйлүүд чинь ингээд л бэлгэдлийн чанартай зүйл яриад, одоо энэ байна шүү дээ өмнөхтэйгөө өмнөхөөсөө өөр шүү. 1, 2-хон арга хэмжээ аваад наад зүйлүүд чинь засарчихна гэж би бодохгүй байна. Ул суурьтай хөдлөхгүй бол нүүрсээ үнэтэй зарж чадахгүй. Би ингээд ярихаар мөнгө байна шүү дээ чи юу яриад байгаа юм манай валют цаашаа өснө шүү дээ гээд байсан. Хаана байна тэгээд. Чимээгүй байгаарай л гээд байсан тэгээд хаана өсгөөд байгаа юм бэ?

**Р.Сэддорж:** Нэмж хариулъя 4 номер, хариулт байна уу?

**Г.Энхтайван:** Гишүүний Ганбаатар гишүүний саналтай санал нэг байгаа. Эдийн засаг хүндрэлтэй байгаа, экспортын орох урсгал тодорхой хэмжээгээр буурсантай холбогдуулаад төлбөрийн тэнцэл алдагдалтай гараад энэ бол маш хүндрэлтэй байгаа. Энэ дээр гишүүнтэй санал нэг байгаа. Параллель ханшийг мэдээж ойртуулах талаар бид бүхэн ажиллаж байгаа. Гэхдээ нөхцөл байдал амаргүй байна. Орох урсгал бага байна. 4,7 гэдэг маань цэвэр нөөц биш. Цэвэр нөөцийг тооцдог олон улсын хэд хэдэн аргачлал байдаг. Энэ дээр хамгийн бид бүхний ашигладаг ОУВС-ийн тооцдог цэвэр аргачлалаар манай цэвэр нөөц 1,3 орчим тэрбум доллартой байгаа.

**Р.Сэддорж:** Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн.

**Л.Соронзонболд:** Эдийн засгийн байнгын хорооны гишүүддээ энэ өглөөний мэндийг хүргэе. Энэ хяналтын зөвлөлийн ирүүлсэн тайлантай танилцахад Монголбанкны 2023 оны санхүүгийн тайланд хийгдсэн хөндлөнгийн аудитаар хязгаарлалттай гэдэг гэсэн дүгнэлт авсан байна. Тэгэхээр хязгаарлалттай гэдэг дүгнэлт өөрөө тодорхой хэмжээний материаллаг ийм хохирол байж болзошгүй гэдэг ийм тохиолдол гардаг. Тэгэхээр энэ материаллаг дүнгийн асуудал хэдэн төгрөгийн асуудал вэ гэж Монголбанкнаас тодруулж асуумаар байна. Тэгээд энэ асуудал 2024 онд засварлагдаж шийдэгдсэн үү 1 дүгээр асуулт.

2 дугаар асуулт болохоор энэ хяналтын зөвлөл болон Монголбанкны захирлуудын зөвлөлийн энэ хамтарсан хурлыг шинээр улирал болгон хийж хэвшвэл зүгээр байна гэсэн ийм дүгнэлтийг Хяналтын зөвлөл гаргасан байна л даа. Тэгэхээр яагаад ийм дүгнэлт гаргах болсон бэ? Ингэснээрээ ямар ажил сайжрах вэ гэж.

3 дугаар асуулт Төв банкны засаглалд хамтын шийдвэр гаргах механизм дутмаг байна, хяналт тэнцэл алдагдсан, хяналтын хараат бус бүтэц дутмаг байна

гэсэн энэ ОУВС-ийн ийм дүгнэлт байгаа юм байна. Тэгэхээр энэ дүгнэлтийн дагуу хийсэн ажил байвал танилцуулаач гэж.

4 дүгээрт нь энэ 2003 онд батлагдсан энэ хяналтын зөвлөлийн ажиллах журам гэж байгаа. Тэгэхээр 2025 оны төлөвлөгөөгөө та бүхэн ирүүлсэн байна. Энэ дээр хяналтын зөвлөл дээр яг энэ зөвлөлийнхөө журмыг өөрчлөх талаар ерөөсөө тусгагдаагүй харагдаад байх юм. Энэ дээр ямар төлөвлөгөө тавьж байгаа юм бэ?

Дараагаар нь энэ зээлийн хүү буурах асуудал дээр ингээд тодорхой ажлууд судалгаа хийсэн юм байна. Зүгээр яах вэ ер нь би Эдийн засгийн байнгын хорооны даргад хэлэхэд энэ зээлийн хүү бууруулах энэ стратегиудыг хэрэгжүүлэх, энэ гүйцэтгэлийг нь сайжруулах талаас энэ Эдийн засгийн байнгын хорооноос тодорхой хэмжээний ажлын хэсэг гаргаж ажиллавал ямар вэ гэсэн ийм саналыг дэвшүүлж байна.

**Р.Сэддорж:** Хариулт 3 номер.

**Н.Ууганбаатар:** Соронзонболд гишүүний зарим асуултад хариулъя. Хамтарсан хурлыг яагаад хийх болсон бэ гэдэг асуултыг асууж байна. Яах вэ манай нөгөө үндсэн 5 чиг үүргийн нэг дээр нь захирал, Монголбанкны зөвлөлийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавих гэдэг ийм заалт байдаг. Зөвлөлийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавина гэхээр их тийм жоохон ойлгомжгүй байгаа. Тэгээд журам дээр энэ их тодорхой тусгагдаагүй. Энийг юугаар хэмжих вэ, яаж хэмжих вэ? Зөвлөл гэж тухайлбал Монголбанкны зөвлөл гэж тухайлбал юуг хэлэх вэ ч гэдэг юм уу ингээд олон асуудал бол гарч байна. Яах вэ бид урьдчилсан байдлаар захирлын зөвлөл гэж ерөнхийдөө өмнөх хяналтын зөвлөл маань ч ингэж ойлгож ирсэн байгаа. Бид иймэрхүү маягаар ойлгох нь зөв юм болов уу гэсэн ингэж ойлгоод захирлын зөвлөлийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавина гэхээр болоод өнгөрчихсөн жилийн турш хуралдсан, магадгүй 24 онд 7 удаа хуралдсан ч гэдэг юм уу, хурлынх нь тайланг аваад ингээд энэ болсон юм уу, болоогүй юм уу гэдэг юмыг араас нь хэлэлцэж явах бол нэг жилийн хугацаа гэдэг 1 дүгээрт арай илүү хол юм уу гэж ингэж харсан. Хяналт байнгын үргэлжийн байдлаар явагдах нь зүйтэй юм болов уу гэж ингэж ойлгож байгаа.

2 дахь асуудал нь бид ингээд зөвлөмж гаргаад өгчихнө. Тэгээд зөвлөмжийг хэрэгжүүлэх эсэх нь дахиад заавал хэрэгжих ийм юутай бол биш. Тэгээд энийг буцаагаад яах вэ хэрэгжилтийг нь хяналтын зөвлөлийн хуралд тайлагнана гэсэн, танилцуулна гэсэн иймэрхүү зохицуулалт явж байгаа. Тэгэхээр дахиад л мөн энэ дээр зөвлөмж гаргаад, нөгөөдөх нь хэрэгжээд ингээд явж байтал нэлээн хугацаа орох юм болов уу гэж ингэж бодсон. Тэгээд зарим нэгэн тодорхойгүй зүйлүүдийг тодорхой болгох ийм шаардлага байгаад байгаа. Нөгөө талаас мэдээллийн хувьд мөн ялгаагүй Төв банк дээр, Төв банк маань мэдээлэлдээ нэлээн хямгатай анхааралтай ханддаг. Тэрний онцлогийг харгалзаж үзэхгүй бол болохгүй ийм нөхцөл байдлууд үүсээд байгаа. Жишээ нь хөрөнгө оруулалтын багц дээр хяналт тавина гэхээр хөрөнгө оруулалтын багц руу орно гэхээр цаанаа юу гэдэг юм нууцын зэрэглэлтэй мэдээлэлтэй иймэрхүү юмнууд орох гээд байдаг иймэрхүү нөхцөл байдал руу орчихдог. Тэгэхээр шууд 1 дүгээр, шууд мэдээлэлтэй, бүрэн мэдээлэлтэй байгаа хүнтэй нь зарим тохиолдолд тулж уулзаж ингэж явах нь илүү үр дүнтэй байх юм болов уу гэж ойлгосон. Тэгэхээр зөвлөмжүүдийн маань хэрэгжилт, мэдээллийн мэдээллийн ил тод байдал, 2 талаасаа тэнцвэртэй байх

гэдэг зарчмыг үндэслээд хамтарсан хурал хийх нь үр дүнтэй байх юм болов уу гэж ингэж ойлгосон.

Хамтын шийдвэр гаргах ийм засаглалын хувьд ийм дутмаг ийм зүйл байгаа гэдгийг ОУВС-ийн тайлан дээр нэлээн дэлгэрэнгүй авч үзсэн байсан. Тэгээд бидэнд өгсөн мэдээллээр Монголбанкны Ерөнхийлөгч гарсан өөрчлөлтүүд, гол өөрчлөлтүүд 2018 оны хуулиар орсон Мөнгөний бодлогын хороо гэдэг бие даасан байгууллага дээр мөнгөний бодлогын шийдвэр гардаг болсон. Хяналт шалгалтын хороо гээд дахиад бие даасан ийм бүтэц байгаа. Тэрнээс өмнө шийдвэрийг гол шийдвэр магадгүй захирлын зөвлөл дээр гардаг байсан бол тэр хугацаа, тэрнээс хойших хугацаанд Захирлын зөвлөлийн хэлэлцдэг асуудлын тоо, хуралдах юу бол нэлээн багассан гэдэг иймэрхүү мэдээллийг бид нарт өгсөн. Тэгээд хэрэгжсэн 2 зүйл нь хамтын шийдвэр гаргах чиглэлд хэрэгжсэн 2 гол реформ нь энэ юм болов уу гэсэн ийм мэдээлэлтэй байгаа.

Хяналт тэнцлийн асуудал дээр учир дутагдалтай байгаа гэсэн ийм дүгнэлтийг ОУБ ч өгсөн байгаа. Бид энэ дээр иймэрхүү ижил саналтай байгаа. 2003 оныхоо бид журмыг өөрчлөх асуудлыг үйл ажиллагааныхаа төлөвлөгөөнд шууд тусгаагүй. Гэхдээ хамгийн сүүлийн хэсэг дээр нь бид Төв банкны засаглал, санхүүжилт, өнөөгийн нөхцөл байдал гээд 8 нэлээн ерөнхий ийм зүйл зүйлийг оруулчихсан. Тэгээд энэ чиглэлээр нэлээн судалгаа хийж байж тэгээд энэ журамд өөрчлөлт орох асуудлыг энэ хүрээнд авч үзэж байгаа. Тэгээд одоогоор бид журмынхаа төсөл дээр ажиллаад явж байгаа. Түрүүний Ганбаатар гишүүн, 2003 оны журам тийм. Тэгээд Ганбаатар гишүүний асуултад давхар хариулахад бид журмынхаа төсөл дээр ажиллаад явж байгаа. Тэгээд шаардлагатай 27<sup>1.1</sup> гэдэг заалтад тодорхой хэмжээний өөрчлөлт оруулах ийм саналыг боловсруулах чиглэлээр ажиллаад явж байгаа.

**Р.Сэддорж:** 4 номер нэмж хариулъя.

**Г.Энхтайван:** Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Тэр аудитын хараат бус аудитын хязгаарлалттай дүгнэлттэй холбоотой асуулт асуулаа. Энэхүү дүгнэлт нь юун дээрээс үндэслээд байгаа вэ гэхээр Монголбанкны эрдэнэсийн санд бүртгэлтэй байгаад байгаа тэр зоосны дахин үнэлгээтэй холбоотой байгаад байгаа. 1925 онд гаргаад, 1938 онд буцаагаад татан төвлөрүүлсэн мөнгөн зооснуудыг 2018 онд Төв банкны, Төв банк дахин үнэлгээ хийгээд өөрийн актив хөрөнгөдөө бүртгэж авсан байгаад байгаа. Тэгээд энэ үнэлгээ нь үнийн дүнгийн хувьд яг бодит үнэлгээжсэн, ямар аргачлалаар үнэлсэн, яаж үнэлсэн, энэ үнэлгээ нь хэрхэн бий болсон гэдгийг нотлох баримтаар баталгаажихгүй байна гэдгийг олон улсын аудитын компаниуд PWC Ernst Young-ийнхан бол сүүлийн жилүүдэд энэ дээр асуудал тавиад, Төв банкны аудит дүгнэлт нь хязгаарлалттайгаар гарсан байгаад байгаа. Энэ бол зөвхөн нөгөө зоосны 25 он.../минут дуусав/

**Р.Сэддорж:** Соронзонболд гишүүн нэмж тодруулъя.

**Л.Соронзонболд:** Гол нь нөгөө мөнгөн дүн нь хэдэн төгрөгийн асуудал вэ гээд асуугаад байгаа. Та нар ингээд дахин үнэлгээ хийчихсэн юм байна шүү дээ. Тэгээд хэдэн төгрөгийн асуудал вэ?

**Р.Сэддорж:** Хэдэн номер вэ? Энэ дугаар хэлэхэд өөрсдөө нэр, албан тушаалаа хэлээд байна шүү. 4 номер.

**Г.Энхтайван:** Олон улсын аудитын компани нь Төв банканд аудитад орохдоо үнэлгээг бодит бус байна гэсэн. Ер нь 960 орчим тэрбум төгрөгийн үнэлгээний зөрөө байгаа.

**Р.Сэддорж:** Тодруулах уу? Өөрсдийнхөө нэр, албан тушаал юмнуудыг хэлээд энэ протоколд энэ чинь хэвлэл мэдээллийн байгууллагууд бүгд харж байгаа шүү дээ. Баатаржавын Мөнхсоёл гишүүн.

**Б.Мөнхсоёл:** Бүгдийнх нь өглөөний амрыг айлтгая. Тэгэхээр Монголбанкны асуудал маш чухал ийм том үүрэг функцтэй хариуцлага хүлээсэн ийм байгууллага байгаа. Тэгээд саяхан энэ хяналтын зөвлөлийг байгуулсан. Мэргэжилтнүүд орсон, хүлээлт өндөр байгаа, иргэд ч гэсэн хүлээлт өндөр байгаа. Хамгийн их өндөр хүлээлт байдаг нэг асуудал бол мэдээж зээлийн хүү. Тэгээд зээлийн хүү буурах тухай стратегийг аль дээр үеэс гаргасан стратегиас дурдаад явчхаж байна, яаж хэрхэн биелсэн тухай мэдээлэл муу байна гэж үзэж байна. Яалт ч үгүй нөгөө тэлсэн төсвийн бодлоготой холбогдуулаад бодлогын хүү 2 хувиар өссөн. Энийг Их Хурал чуулган дээр ч гэсэн гишүүд асууж байна. Тэгэхээр энэтэй холбогдуулаад маш их өндөр ач холбогдолтой яригдаж байгаа, асуугдаж байгаа сэдвүүдээр хариуцлагатайгаар мэдээлэл бэлдээд орж ирвэл их зүгээр. Яагаад гэвэл асуугдах нь тодорхой сэдвүүд байна шүү дээ.

Тэгээд бодлогын хүү өсчихлөө, тэгээд яах вэ, энэ дээр иргэддээ тодорхой хэмжээний мэдээллийг Монголбанкныхан өгч байвал сайн. Яагаад вэ гэхээр иргэд мэдээлэлтэй байх хэрэгтэй, зээлийн хүү хэрхэн өсөх юм, яагаад өсчөв гээд тэр тал дээр мэдээлэл их хэрэгтэй байдаг. Тэгээд өмнөхөн нэг гишүүдэд зориулаад төсөв болон Сангийн яамныхан болон Монголбанкныхан сургалт гэхихсэн байна лээ. Уг нь мэдээллийн шинж чанартай бусад мэдлэг өгөх шинжтэй ч юм шиг тийм юм болсон гишүүдэд. Түүн дээр Монголбанкны Баярдаваа маань ч хэлсэн шүү дээ. Монголбанкны гол үүрэг нь макро эдийн эдийн засгийг тогтвортой байлгах гээд 1 дүгээрт. Тэгсэн мөртөө нөгөө талдаа инфляцыг барих юм шиг. Нөгөө талдаа ханшийг бид хянаж байх ёстой юм шиг ийм байдалд байдаг нь хэцүү байдаг гэдгийг ярьсан. Нөгөө мөнгөний бодлого дээр тусгагдчихсан 6 нэмэх, хасах гэдэг инфляцын түвшин чинь өөрчлөгдөх нь байна шүү дээ. Жишээлбэл хүлээлтэд хүрэхгүй. Тэгэхээр энэ талаарх та нарын дүгнэж байгаа дүгнэлт, үнэлгээ юу байна вэ? Ингээд сонирхъё.

3 дугаарт нь Ганбаатар гишүүн асуусан юм шиг байна. Валютын албан нөөцийн хэмжээ. Даалгавар өгчихсөн, энийг хэмжээг нь нэмэгдүүлье гээд. Сая Энхтайван хэллээ шүү дээ. Яг цэвэр бодит валютын албан нөөц маш бага байгаа гэдгийг. Тэгэхээр энэ өөрөө анхаарал хандуулах ёстой асуудал мөн. Нөгөө даалгаврын дагуу байдал юу болж байгаа юм бэ, энэ зөв үү? Ханшийг 3510 байхад нь хүчээр интервенц хийгээд 3480 руу ч юм уу орууллаа гэж байна. Гэтэл энэ интервенц чинь хэр удаан явж чадах юм бэ? Хэрхэн хийв? Баярдаваа эдийн засагч маань өөрөө хэлсэн. Фикст юм шиг яваад байна манай валютын ханш уг нь флотинг гэдгээрээ хэлбэлздэг баймаар байна гэдэг дээр өөрийнхөө бодлыг тэр үед хуваалцсан. Энэ 3 гол асуудлыг иргэд, ААН-үүд, бизнесийн секторынхон маш их анхааралтай хардаг. Бизнес нь эрсдэл тодорхойгүй байдал үүсэхээс хамгаалж мэдээлэл авахыг хүсдэг учраас би өмнөөс нь ийм асуултууд асуучихъя. Баярлалаа.

**Р.Сэддорж:** Хариулт хэдэн номер вэ? 4 номер.

**Г.Энхтайван:** Мөнхсоёл гишүүний асуултад хариулъя. Асуултыг нь сүүлийн асуултаудаас нь эхлээд хариулаад явчихъя. Гишүүн энэ гадаад валютын албан нөөцтэй холбоотой асуудлыг хөндөж байна. Яг өнөөдрийн байдлаар гадаад валютын албан нөөц 4 тэрбум 700 сая доллартой байгаад байгаа, цэвэр нөөц гэж бид бүхэн тооцож явдаг. Энэ бол ОУВС-ийн definition-р тооцдог. Энэ дээр урт хугацаат своп болон бусад demand-тай мөнгөнүүдийг хассанаар тооцож явдаг. Яг өнөөдрийн байдлаар цэвэр нөөц, урт хугацаат свопыг хассанаар 1 тэрбум 65 сая ам.доллартой байна. Ханш дээр мэдээж бид бүхэн түрүүн хэн ч хэлсэн, ханш гэдэг маань өөрөө төлбөрийн тэнцлийн, төлбөрийн тэнцэл гэдэг маань ханшийн урьдач нөхцөл байдаг. Төлбөрийн тэнцэл ашигтай гарвал ханш тогтвортой байна. Төлбөрийн тэнцэл алдагдалтай бол мэдээж ханш дээр дарамт ирдэг.

Тэгэхээр төлбөрийн тэнцэл өөрөө оны эхний 2 сарын байдлаар 717 сая долларын алдагдалтай гарч байгаа нь ханшийг тодорхой хэмжээнд сулрах тийм суурь нөхцөлийг бий болгож байгаа. Төв банкны зүгээс ханшийн огцом савлагааг бий болгохгүй байх үүднээс зах зээл дээр тохируулгуудыг хийгээд явж байгаа. Энэ хүрээнд ч гэсэн 3 дугаар сард хуралдсан Мөнгөний бодлогын хорооны хурлаар бодлогын хүүг 2 base, 200 base пойнтоор нэмж 12 хувьд хүргэсэн. Мэдээж зээлийн хүү дээр энэ нь мэдээж огцом нөлөөг үзүүлнэ. Ер нь Төв банкны бодлогын арга хэмжээнүүд бодлогын хүүгийн өөрчлөлт 3-аас 4 улирлын дараа зах зээл дээр шууд эффектээ үзүүлдэг. Тэгэхээр Төв банкны бодлогын хүү өөрчлөгдсөнөөр шууд маргааш нь зээлийн хүү дээр өөрчлөлт орох боломж харьцангуй бага байдаг. Ер нь одоо 2 сарын байдлаар бодлогын хүү өөрчлөгдөхөөс өмнө зээлийн жигнэсэн дундаж 17,1 хувьтай байсан. Энэ нь нийт хөтөлбөрийн болон ипотекийн зээлүүдийг хассанаар, ипотекийн зээлүүд, хөтөлбөрийн зээлүүдийг оруулснаар 16,7 орчим хувьтай зээлийн хүү байгаад байгаа. Тэгэхээр мэдээж энэ зээлийн жигнэсэн дундаж хүү энэ бодлогын хүүгийн өөрчлөлтөөс хамаараад тодорхой хэмжээнд өөрчлөгдөнө.

Төв банкны эдийн засагчдын хийсэн судалгаагаар зээлийн хүү бодлогын хүүгийн харьцаан дээр бодлогын хүү 1 орчим хувиар нэмэгдэхэд зээлийн хүү дээр 0,7 орчим хувийн нөлөө гарч байгаа гэсэн тийм судалгаа байдаг. Тэгэхдээ энэ нь тухайн эдийн засгийнхаа нөхцөл байдлаас, тухайн жилийнхээ нөхцөл байдлаас хамаараад харилцан адилгүй байдаг. Ер нь тухайн эдийн засгийн нөхцөл байдал маань Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал маань өөрөө гадаад импорт, экспортоос хамааралтай, гадаад зах зээлийн шок эдийн засагт үзүүлж байгаа нөлөө харьцангуй өндөр. Манай улс өөрөө импортоос бүрэн хамааралтай байгаа нөхцөл нөхцөлд бид бүхэн эдийн засгийг илүү тогтворжуулж, макро эдийн засгийн хувьд тийм огцом савлагаа гаргахгүй байх үүднээс эдийн засгийг бодлогын тохируулгуудыг хийгээд явж байгаа.

Төв банкны тухай хууль дээр Төв банк өөрөө инфляцыг Төв банкны зорилтот түвшинд барих гэдэг тийм агуулгаар жилийн төлөвлөгөөнүүдээ оруулж ирдэг. Энэ жилийн хувьд 6 дээр +, - 2 гэсэн band-н хүрээнд инфляцыг барина гэж оруулж ирж байгаа. Мэдээж энэ оны хүлээлтээр энэхүү Төв банкны зорилтот түвшнээс жилийн дундаж бол давахаар байгаад байгаа. Тэгэхдээ гишүүд маань нэг юмыг бодолцоход инфляцыг Төв банк дунд хугацаанд тогтворжуулах бодлогыг оруулж ирдэг буюу Төв банкны бодлого нь өөрөө дунд хугацааг онилж явдаг. Тухайн жилийн тухайн сарын band-г бол онилдоггүй. Тэгэхээр Төв банкны бодлого дунд хугацаандаа инфляцыг 6 хувь дээр тогтворжуулна гэсэн тийм бодлогын арга хэмжээг аваад явдаг.

Ханштай холбоотой асуудал дээр мэдээж түрүүн Баярдаваа захирлын хэлснийг ч гэсэн хэлж байна. Ер нь Төв банкны тухай хууль дээр Монгол төгрөгийн тогтвортой байдлыг хангах гэдэг үндсэн мандат байдаг. Монгол төгрөгийн тогтвортой байдал гэдэг маань нэг талдаа үнийн тогтвортой байдал буюу инфляц төгрөгийн худалдан авах чадвар. Гэхдээ энэ нь нөгөө талдаа валютын ханшны тогтвортой байдал гэдэг.../минут дуусав/

**Р.Сэддорж:** Мөнхсоёл гишүүн нэмж тодруулъя.

**Б.Мөнхсоёл:** Энхтайван эдийн засагчид баярлалаа. Мэдээж гэж ярих шаардлагагүй байх. Хүмүүст энэ чинь мэдээж биш иргэдэд, ААН-үүд, онол яриад байна. 2 дугаарт тэгээд даалгавар өгсөн валютын албан нөөц чинь 5 гаруй тэрбум ам.доллар байсан одоо 4,7 руу, тэрнээс ч доошоо орсон нэмэгдүүл гэсэн даалгавар өгсөн. Цэврээр тооцоход асар бага байна шүү дээ. Түүн дээр ямар үйл ажиллагаа явагдаж байгаа юм бол? Ядаж энийг нь тодорхой мэдээлэл авчихъя. Баярлалаа.

**Р.Сэддорж:** Хариулт 4 номер.

**Г.Энхтайван:** Ер нь эдийн засагт доллар 3 янзаар л орж ирж байгаа юм. Төлбөрийн тэнцлийг харахаар 1 дүгээрт нь, хамгийн 1 дүгээрт нь экспортын сувгаар орж ирж байгаа, 2-т нь гадаадын хөрөнгө оруулалт хэлбэрээр орж байгаа, 3-д нь гадаад зээл, тусламж хэлбэрээр оруулж ирж байгаа. Яг энэ хүрээнд экспортыг дэмжих, экспортын бодит орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр экспортын орлогыг нэмэгдүүлэх ажлын хэсэг гараад Жавхлан сайдаар ахлуулсан ажлын хэсэг гараад ажиллаж байгаа. Үүн дээр хил гааль дээр учирч байгаа холбогдох асуудлуудыг цэгцлэх, экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ аваад ажиллаж байгаа гэж ойлгож байгаа.

Төв банкны хувьд мэдээж энэ дээр өөрсдийн боломжийн хүрээнд гадаад зах зээл дээрээс арилжааны банкнуудыг бодит эх үүсвэр татах, тэдгээр эх үүсвэр татаад оруулж ирсэн долларыг нь зах зээл дээр нийлүүлэх чиглэлээр арилжааны банкнуудын үйл ажиллагааг дэмжээд ажиллаж байгаа. Мөн Хадгаламжийн даатгалын корпорацын болон Төрийн банкны эзэмшиж байсан Монгол Улсын гадаад.../минут дуусав/

**Р.Сэддорж:** Ганзоригийн Лувсанжамц гишүүн.

**Г.Лувсанжамц:** Өдрийн мэнд хүргэе. 6 жилээр та бүхэн томилогдоод ажиллаж байгаа болов уу гэж бодож байна. Ажлын өндөр амжилт хүсье. Өмнө нь томилгооны асуудал яригдаж байхад олон жилийн туршлагатай, өндөр боловсролтой ийм хүмүүс сонгогдож байгаад нь их олзуурхаж байсан. Тэгээд өнөөдөр ийм мэдээлэл хийгээд ажлын төлөвлөгөөгөө танилцуулж байгаад баярлалаа. Үндсэндээ 3 асуулт байна. Эхнийх нь болохоор та бүхэн маань 6 жил ажиллана. Гэхдээ энд зөвхөн нэг жилийн л ажлын төлөвлөгөө байгаад байна. Хяналтын зөвлөл хараат бусаар ажиллах дунд, урт хугацааны мөнгөний бодлогыг авч явах гэдэг дээр дорвитой ажил хийх боломжтой институт учраас 6 жилийн төлөвлөгөө хармаар байна. Энийг хэзээ танилцуулах боломжтой вэ?

Хоёрдугаарх нь энэ ажлын төлөвлөгөөтэй холбоотойгоор агуулга дээр нь жоохон ийм ажлын төлөвлөгөө боловсруулмааргүй санагдаад байна л даа. Үр дүнд суурилсан биш байна. Хяналт тавих, хяналт тавих, хяналт тавих гээд л эхний 5 бол

бүгдээрээ хяналт тавих гэсэн зорилготой байна. Хяналт тавих гэдэг бол та бүхний үндсэн ажил буюу үр дүн биш шүү дээ. Та бүхэн маань энэ ажлаа жилийн хугацаанд хийгээд 6 жилийн төлөвлөгөө өөрөө ямар үр дүнг авчрах боломжтой юм бэ гэсэн тийм үр дүнд суурилсан төлөвлөлт бид нарт хэрэгтэй. Тэгж байж бид ингээд дунд, урт хугацаандаа ажиллаад, үр дүнтэйгээр хэрэгжээд үр ашигтай байх болов уу гэж бодож байна. Тийм ажлын төлөвлөгөөг агуулгадаа тусгамаар байна. Түүнийг хэзээ гаргаж өгөх боломжтой вэ?

Төв банкны тухай хуулийн 4 дүгээр зүйл дээр хосолсон мандат гэж хэлж байна. Түүн дээрээ та бүхэн ханшны тогтвортой байдал, эдийн засгийн тэнцвэртэй хөгжил гэсэн 2 зүйл байгааг нь эргэж харах уу гэж тийм тайлан танилцуулж байна гэж ойлголоо зөв үү? Олон улс дээр харахлаар хосолсон мандаттай Төв банкнууд маш олон байдаг юм шүү дээ. Яагаад энийгээ нэг болгох гээд байгаа юм бол гэсэн тийм нэг үндсэн асуулт байна. Манайх уг нь ингээд ажлын байр нэмэгдүүлэх, орон сууцын бодлого гэдэг энэ 2 зүйл бол манай улсын хувьд Төв банкны бодлого дээр байж баймаар байгаа байхгүй юу. Та бүхэн маань сар бүрийн үл хөдлөх хөрөнгийн үнэ, түрээсийн үнэ гээд аутсорсинг хийгээд гаргаж байгаа шүү дээ. Түүн дээрээсээ үндэслээд орон сууцын бодлогын зөвлөмж, зөвлөгөө гэдэг зүйлүүд адилхан давхар гарч байвал зүгээр байгаад байгаа юм. Яалт ч үгүй манай улс чинь залуучууд бүгд орон сууцтай больё гэсэн тийм үндсэн зорилготой байгаад байгаа шүү дээ. Түүн дээр нь та бүхэн ажиллах хэрэгтэй болов уу гэж бодож байна.

Гуравдугаарх нь болохлоор ногоон санхүүжилттэй холбоотойгоор Уур амьсгалтын өөрчлөлтийн сангаас хөнгөлөлттэй эх үүсвэрээр, эх үүсвэр татаж ирэхэд нь энгийн эх үүсвэртэй бараг ойролцоогоор одоогоор 0,5 хувийн свопын хөнгөлөлт үзүүлж байгаа юм. Энийг уг нь ингээд бодлоготойгоо уялдуулаад нэгэнт бид Шинэ сэргэлтийн бодлогоор ногоон шилжилтийнхээ бодлогыг эрчимжүүлэх гэж байгаа бол Монголбанкны зүгээс ч гэсэн, хяналтын зөвлөлийн зүгээс ч гэсэн тийм зүйлүүдэд чиглэсэн ажлын төлөвлөгөө байх ёстой гэж бодож байна л даа. Ийм 3 асуултдаа хариулт авъя.

**Р.Сэддорж:** Хариулт 3 номер.

**Н.Ууганбаатар:** Хяналтын зөвлөлийн дарга Ууганбаатар. Лувсанжамц гишүүний асуултад хариулъя. 1 жилийн төлөвлөгөө гаргасан байна, дунд хугацааны төлөвлөгөөгөө хэзээ танилцуулах вэ гэсэн ийм асуулт. Дунд хугацааны төлөвлөгөө гаргаж амжаагүй байгаа, 1 жилийн төлөвлөгөө та бүхэнд танилцуулсан буюу Монголбанканд хүргүүлсэн төлөвлөгөө маань хураангуй хэлбэр нь, энэний илүү дэлгэрүүлсэн хэлбэр нь байгаа. Энийг бид өгч болно. Түүн дээр яг ямар үйл ажиллагаа энэ хүрээндээ хяналт тавина гэдгээ бид юу гэж ойлгох вэ гэдгийг нь илүү дэлгэрэнгүй тусгасан байгаа. Үр дүнд суурилж төлөвлөгөөгөө боловсруулаагүй, цаашид энэ дээр бид анхааръя.

Тэгээд дээрээс нь, гол нь хуулиа баримтлаад 27<sup>1</sup>-ийг баримтлаад тэгээд үндсэндээ 5 үндсэн чиглэл байгаа юм байна. Энэ 5 үндсэн чиглэлийг цааш нь яаж хэрэгжүүлэх вэ, эхний ажил тэр болсон, юу хийх вэ, яаж хийх вэ, энийг яах вэ гээд. Бид шинэ эхэлсэн учраас тодорхой хэмжээнд суралцах ийм үе бол зайлшгүй шаардлагатай байгаа шүү.

Тэр Төв банкны мандаттай холбоотой асуудал 1 дүгээрт өөрийн чинь хэлдэг зөв. Зарим Төв банкнууд тухайлбал federal reserve юм уу том, том банк 2 тухайлбал



хосолсон 2 мандаттай явдаг. Манайд ханш түрүүн Энхтайван ерөнхийлөгч маань хэллээ. Үнийн тогтвортой байдал, ханшийн тогтвортой байдал, дээрээс нь хөгжлийн бодлого гэсэн ийм 3 зүйлийг оруулсан. Зүгээр яах вэ зовлон төвөгтэй нөхцөл байдал нь хаашаа үүсдэг вэ гэхээр их олон мандат өгчихөөр бодлогын орон зай маань жоохон сулраад, ерөнхийдөө эдийн засагчийнхаа байр сууриас хэлэхэд бол түгжчих гээд байдаг, гар, хөлийг нь түгжчих гээд байдаг буюу хөдлөх орон зайг нь нэлээн хязгаарлаад эхэлдэг. Тэгээд энэтэй холбоотойгоор үүсдэг хүндрэлүүд байна.

Нөгөө талаас олон мандат өгөөд, дээрээс нь олон чиг үүрэг өгчихөөр Төв банк маань өөрөө үйл ажиллагааны хувьд их том нэлээн том бүтэцтэй болж ингэж хөгжиж байгаа ийм зүйл анзаарагддаг. 2 дахь магадгүй шалтгаан нь энэ. Тэрнээс нь эхнийх нь илүү чухал буюу энийг эдийн засгийн л... бол боломжгүй гурвалжин, боломжгүй нөхцөл байдал руу ер нь аваачих гэж ингэж үздэг. Их олон зүйлийг нэг дор тогтворжуулах, олон зүйлийг нэг дор хянах боломжгүй гэдэг ийм зүйл иймэрхүү онолын ойлголт байдаг. Тэгээд түрүүн Мөнхсоёл гишүүний Баярдаваа захирлын танилцуулсан тэр танилцуулга дээр энэний талаар нэлээн дэлгэрэнгүй яригдсан. Тэр ногоон санхүүжилттэй холбоотой хэсгийг Энхтайван ерөнхийлөгч маань хариулах болов уу.

**Р.Сэддорж:** 4 номер нэмж хариулъя.

**Г.Энхтайван:** Лувсанжамц гишүүний асуултад тодруулъя. Төв банкны зүгээс ногоон зээлийн ногоон бодлогыг дэмжээд явж байгаа. Ногоон зээлийн дундаж хүү одоогоор 14,5 хувьтай байгаа. Нийт зээлийн багц нь 1,3 их наяд төгрөг буюу нийт зээлийн 3,7 орчим хувь дээр байгаа. Бид бүхэн энэ ногоон зээлийн хэмжээг нийт зээлийн 3,7 хувь гэж байгааг 10 хувьд хүргэнэ гэсэн тийм зорилт дэвшүүлээд ажиллаж байгаа. Олон улсын бусад орны Төв банкнууд ч гэсэн энэ ногоон зээлийн хэмжээг ерөнхийдөө 10 хувь орчим хүргэнэ гэсэн тийм бодлогын зорилтыг тавиад ажиллаж байгаа. Манай энэ зорилт бусад бүс нутгийн ижил төстэй орнуудын Төв банкнуудын тавьж байгаа зорилттой нийцэж байгаа. Түрүүн хэлсэн хүү нь өөрөө 14,5 орчим хувь байна гэдэг маань манай зээлийн жигнэсэн дунджаас 2 орчим хувиар бага байгаа. Мэдээж.../минут дуусав/

**Р.Сэддорж:** Гүйцээж хариулъя.

**Г.Энхтайван:** Төв банкны зүгээс арилжааны банкнуудыг ногоон зээлийн эх үүсвэр оруулж ирэхэд нь дэмжлэг үзүүлж байгаа. Гол дэмжлэгийн хамгийн гол асуудал энэ своп хэлцэл байдаг. Оруулж ирсэн эх үүсвэрийг Төв банк өөрийн нөхцөлөөр аваад, үндэсний мөнгөн тэмдэгт өгөөд, буцаагаад хэсэг хугацааны дараа буцааж төлөх үүрэг хүлээдэг. Энэ хүрээнд арилжааны банкны өөрийн гадаад зах зээл дээрээс татсан нөхцөлийг ерөөсөө муутгахгүйгээр аль болохоор харилцан зээлийн нөхцөлийг муутгахгүй зах зээл дээр гарч байгаа зээлийн хүү дээр дарамт үзүүлэхгүй хэлбэрээр бид бүхэн олгоод явдаг. Тэгэхээр анх ямар нөхцөлөөр орж ирж байгаа гэдэг дээр нь бид бүхэн нөхцөлийг нь муутгахгүй хэлбэрээр свопыг хийдэг.

**Р.Сэддорж:** Хуралдаан даргалагч энэ хариултыг гүйцээх эрхтэй. Лувсанжамц гишүүн.

**Г.Лувсанжамц:** Ууганбаатар даргад баярлалаа. Үр дүнд суурилсан төлөвлөгөөг бодолцож үзье гээд сая хэлж байна шүү дээ. Үгүй ээ бодолцохгүй шүү

дээ. Угаасаа шууд ийшээ шилжих ёстой шүү дээ. Сая ингээд жилийн хөгжлийн төлөвлөгөө, 5 жилийн чиглэл, ЗГ-ын хөтөлбөрүүд дээр үр дүнд суурилсан байдлаар шилжье гээд бүх гишүүд дуугарсан шүү дээ. Та бүхэн маань ийшээ шилжих ёстой, бодолцох биш тийшээ шилжих ёстой гэж бодож байна л даа. Тэгэхлээр энэ 6 жилийнхээ төлөвлөгөөг үр дүнд суурилсан байдлаар нөгөө хяналт тавих гэдэг тийм агуулгаар биш ямар зорилтуудыг биелүүлэх юм бэ, шалгуур үзүүлэлт нь ямар байх юм бэ гэсэн байдлаар боловсруулж ирэхийг хүсэж байна.

Тэгээд ногоон зээл дээр болохлоор своп дээр үзүүлэх хөнгөлөлт дээр нь харин бидэнд бодлого хэрэгтэй байгаад байгаа. Тэр бодлогыг нь ажлын төлөвлөгөөнд тусах уу, үгүй юү, тэрийгээ тусгаж өгөөсэй гэсэн 2 дахь санал байна.

3 дахь нь болохлоор энэ хосолсон мандаттай болохлоор ажил нь их хэцүү байдаг гэсэн тийм зүйл ярьж байна. Уг нь боловсон хүчин сайтай шүү дээ Монголбанк. Нэгэнт дата нь байгаа юм чинь бодлого боловсруулах чадамж байгаа гэж бодож байна л даа.

**Р.Сэддорж:** Санал хэллээ. Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууна.

**О.Цогтгэрэл:** Гишүүдэд өглөөний мэнд хүргэе. Монголбанкнаас болоод Хяналтын зөвлөлөөс асуулт байна. Монголбанкнаас ер нь энэ бодит эдийн засаг банк санхүүгийн сектор 2-ын чинь харьцаа гэх юм уу, уялдаа гэх юм уу нөхцөл байдал ямар байна вэ? Ингээд бодит эдийн засгийн салбарыг харахаар улсын төсөв нь тасарсан, энэний цаана ААН-үүд нь ашиггүй ажилласан, бодит эдийн засгийн нөхцөл байдал таатай биш байгааг бүгдээрээ мэдэж байгаа. Нөгөө талд нь банк санхүүгийн салбарын 24 оны мэдээ, сүүлийн үеийн мэдээгээр бараг салбар салбараараа 2 их наядын ашигтай ажиллаж байгаа нэг ийм нөхцөл байдлууд байгаа. Энэ 2-ын цаана энэ 2 чинь уг нь нэг л зоосны 2 тал гэдэг шиг хоорондоо уялдаатай 2 зүйл л дээ. Тэгэхээр энэний цаана яагаад нэг ийм тэнцвэртэй бус байдал үүсээд байна вэ?

Монголбанк банкны салбарын зардал, хүүтэй холбоотой дээр нэг мэдээллүүд явж байсан. Энэнтэй холбоотой энэ банкны салбар чинь яг бодит үндсэн үйл ажиллагаа хүүгээсээ олж байгаа энэ ашгийн бүтэц нь өөрөө ямар болж энэ зохистой байгаа юу? Үндсэндээ хүүгийн бус, үндсэн үйл ажиллагааны бус ашиг нь бараг, ашигтай ажиллаж байгаа хэмжээ нь дөчөөд хувь гэсэн нэг тоо явж байсан. Тэгэхээр энэтэй холбоотой энэ зохистой байдалд байгаа юу? Яагаад гэхээр энэ өөрөө банкны салбар гэдэг чинь өөрөө төрөөс тусгай зөвшөөрлөөр үйл ажиллагаагаа явуулдаг салбар учраас тодорхой хэмжээнд энэ дээр анхаарал хандуулах ёстой байх гэсэн үүднээс асууж байгаа юм. Хяналтын зөвлөлөөс ер нь өнөөдөр Монгол Улсын валютын нөөц 4,7 гэдэг тоо яригдаж байгаа. Энэтэй холбоотой хяналтын зөвлөл дээр та нарт ер нь ямар тооцоо байгаа юм бэ? Цэвэр албан нөөц өнөөдөр ямар байдалтай байгаа юм бэ? Хятадын ардын банкнаас авч байгаа тэр своп хэлцэл, дахиад дээрээс нь бараг 1 тэрбум шахуу 800 сая долларын ч юм яригдана лээ. Энэ өөрөө зүй зохистой хэмжээнд явж байгаа юу? Энэ чинь дахиад л өөрөө Монгол Улсын өр зээлтэй, гадаад орчны нөхцөл байдалтай тэр тусмаа аюулгүй байдалтай ч олон, олон зүйлтэй холбогдох байх. Тэгэхээр цэвэр албан нөөцийн талаар хяналтын зөвлөл дээр ямар мэдээ материал байдаг вэ? Ямар дүгнэлттэй байдаг вэ? Энэ дээр нэг хариулт хэлээч.

**Р.Сэддорж:** Хариулт 2 номер.

**Д.Энхжаргал:** Хэлээд хэрэггүй байх. Хяналтын зөвлөл ажил үүргээ хүлээж аваад тэгээд энэ Хөрөнгө оруулалтын хуульд заасан хяналт шалгалтыг хийх ёстой гэсэн чиг үүргээр надад энэ ажлыг хариуцуулсан. Энэ талаар холбогдох газруудтай танилцсан. Эрсдэлийн удирдлага, зах зээлийн газар, дотоод хяналттай танилцсан. Дотоод хяналтын газар нь улирал болгон мэдээлэл, сар болгон тоон дээр үндэслэж хяналтаа тавьдаг гэсэн ийм мэдээлэл одоогоор өгсөн. Эцсийн үр дүнгийн талаарх мэдээлэл тайлангуудыг Хяналтын зөвлөлд одоогоор өгөөгүй учраас дүгнэлт хэлэх боломжгүй байна. 4,7 их наядын энэ нөөцийн хувьд статистик тоогоор батлагдаад гарчихсан учраас энэ дээр саналгүй байна. Зүгээр статистик үзүүлэлтийг хэрхэн гаргаж байгаа талаар энэ үзүүлэлтийг биелүүлэхийн тулд ямар арга замаар хүрч байгаа талаарх зарим нэгэн хяналт шалгалтын мэдээллүүдийг цуглуулж авсан. Энэ дээр шалгалт хийхийн тулд одоогийн хуульд заасан Хяналтын зөвлөлийн эрх хэмжээ хязгаарлагдмал учраас шалгах боломжгүй байгаад байгаа. Ийм учраас журам болон хуульд зарим нэгэн өөрчлөлтүүдийг оруулах саналыг гаргаж байгаа юм. Баярлалаа.

**Р.Сэддорж:** 4 номер.

**Г.Энхтайван:** Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Эдийн засгийн суурь үзүүлэлтүүд 2025 оны 2 дугаар сарын байдлаар хэлэхэд арилжааны банкны нийт актив 66 их наяд төгрөгт хүрсэн. Үүнээс арилжааны банкны эх үүсвэр 40 их наяд, 40,4 их наяд төгрөгтэй байгаад байгаа. Тэгэхээр энэ 40,4 их наяд төгрөг маань яг тухайн өмнөх жилийн мөн үеэс тооцох юм 10,6 хувиар буюу 3,9 их наяд төгрөгөөр нэмэгдсэн. Арилжааны банкны түрүүн нийт ашигт ажиллагааны тухай гишүүн хөндөж байна 2 их наяд орчим төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж байна гээд. Энэ дээр 66 их наяд төгрөгийн банкны активтай тооцоход активт эзлэх цэвэр ашгийн хэмжээ 3 орчим, 3 хувь хүрэхгүй байгаад байгаа. Энэ нь яг манайтай ижил төстэй үйл ажиллагаатай, ижил төстэй эдийн засагтай бүс нутгийн бусад орнуудтай харьцуулахад яг.../минут дуусав/

**Р.Сэддорж:** 3 номер нэмж хариулъя.

**Г.Энхтайван:** Надад нэмэх зүйл байхгүй даргаа.

**Р.Сэддорж:** Тодруулж асууя.

**О.Цогтгэрэл:** Тэр гадаад валютын албан цэвэр нөөц гэдэг ойлголт чинь своп хэлцэл болж орж байгаа. Гадаад пассивын дүнгүүд орж байгаа. Тэр ирээдүйн өв сан дээр байгаа мөнгөнүүд орж байгаа. Энэ бүгдийг цэвэрлээд харахад бид нарт жинхэнээсээ Монголбанканд тэр ААН-үүдийн харилцах хадгаламжууд бүгд орж байгаа. Тэгэхээр энэний цаана цэвэр албан нөөцийг сая Энхтайван Дэд ерөнхийлөгч тоог хэлж байна. Зүгээр энэ өөрөө бид нарын хувьд мэдээж олон нийтэд тэр болгон хэлэхгүй тоонууд ч энэний цаана байгаа байх. Тэгэхдээ энийг тэр хяналтын зөвлөл гэдэг байгууллага энэ дээр тодорхой яг дүгнэлттэй л байхгүй бол бид нарт ямар ч мэдээлэл байхгүй гэдэг энэ үнэхээр хангалтгүй ийм хариулт сонсогдож байна л даа.

**Р.Сэддорж:** Жуковын Алдаржавхлан гишүүн.

**Ж.Алдаржавхлан:** Манай Монголбанкныхан нэг ийм ЗГ-ын дүү шиг ажилладаг юм сүүлийн жилүүдэд. Манай Монгол Улс чинь нүүрсний эдийн засагтай улс. Нүүрсний экспортын үнийн дүнгээр орлого, зарлага нь дээш, доош хөдөлж байдаг. Ер нь энэ нүүрсний экспортын хямрал хэдий хугацаанд үргэлжлэх юм бол? Энэ дээр Монголбанкныхан прогноз энэ тэр хийж үзсэн үү, үзээгүй байна уу?

2 дугаарт ер нь энэ шинэ хяналтын зөвлөлийнхөн Монголбанкныхаа удирдлагууддаа ЗГ-т нэг тийм зөвлөгөө зөвлөмж өгч ажилладаг баймаар байгаа юм. ЗГ-ын хэлснийг хийх биш. Үнэхээрийн энэ экспортын асуудал чинь хүндэрч байгаа юм бол ЗГ-таа төсвийн тодотгол хийж, төсвийн зарлагаа бууруулах чиглэлийг өгөхгүй юм уу? Заавал тартагт нь тулсны дараа нэлээн хүнд байдалд орсны дараа төсвийн тодотголыг хийх юм уу? Энэ чиглэлээр манай Монголбанкныхан ЗГ-т тийм зөвлөмж өгч ажилламаар байна. Дандаа айсан байдалтай хамтарч ажилладаг. Энийг цаашдаа солимоор байна гэсэн нэгд ийм асуулт байна Монголбанкныхнаас.

2 дугаарт тэр хязгаарлалттай дүгнэлт авсан 2023 онд гэж байна шүү дээ. Төсвийн хязгаарлалттай хөндлөнгийн аудитаар хязгаарлалттай дүгнэлт авна гэдэг чинь төсвийн сахилга бат зөрчсөн байна гэсэн үг байгаа байхгүй юу. Төсвийн сахилга батыг зөрчсөн хүнд ямар хариуцлага ноогдуулсан байсан бэ тухайн үед? Одоо хүртэл ноогдуулаагүй толгойг нь илээд явж байна уу энийг хяналтын зөвлөлийнхөн хариулж өгөөч гэж.

Монголбанкны орон тоо энэ 620, 30 орчим хүн ажилладаг юм байна. Ер нь хяналтын зөвлөлийнхөн энэ орон тоо нь ер нь энэ ямар байдаг юм бэ? Их байна уу, бага байна уу? Энэ дээр судалгаа шинжилгээ хийж үзсэн үү? Энийг манай хяналтын зөвлөлийн дарга хариулж өгөөч. Тэгээд сая бид 1 сард хяналтын зөвлөлийнхнийг сонгоход чинь баахан багш нар сонгосон шүү дээ. Баахан их сургуулийн багш орж гайхуулна гээд л орсон. Та нарын бид нарт тараасан энэ танилцуулга энэ тэр чинь зүгээр юм биччихсэн, ямар ч тийм шинэчлэл алга. Багш нарын гараас гардаг бүтээгдэхүүн биш байна. Энэ дээр та хэд минь анхаарч ажиллаач. Би Монголбанкны хяналтын зөвлөлийн дарга маш их тийм эрчтэй, эрч нь дэндчихгүй бол эрчтэй хүн байна гэж би бодож байгаа. Тэгээд өөрөө энийгээ дараачийнхаа ажилд анхаараач гэж бодож байна. Ямар ч байсан эхлээд хариултаа авчихъя тэгээд тодруулна.

**Р.Сэддорж:** Хариулт 3 номер. Алдаржавхлан гишүүний асуултад хариулъя. Хяналтын зөвлөлийн дарга Ууганбаатар. Хамгийн сүүлд хэлсэн өөрийн чинь юуг ойлголоо. Энэ дээр бид анхаарч ажиллая. Хяналтын зөвлөл нь зөвлөмж өгч ажиллах Монголбанкнаас ЗГ-т зөвлөмж өгөх ийм боломж бололцоо байгаа эсэхийг би шууд хэлж мэдэхгүй байна. Эрх зүйн хэм хэмжээ маань болох билүү, үгүй билүү гэдэг дээр манай чиг үүрэгт ийм зүйл байхгүй. Бид нарын зүгээр хамаатуулж болох заалт юу байгаа вэ гэхээр Монголбанкны захирал Монголбанкны зөвлөлийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавина л гэсэн ийм л зүйл байгаа юм. Тэгээд энэ дээр бид юу яах ёстой байх энийг зөв зүйтэй ашиглаж чадвал эндээс тодорхой хэмжээний гаргалгаа гарах боломжтой байж магадгүй.

Хязгаарлалттай дүгнэлт авсан зөвхөн 23 он биш, энэ сүүлийн 7 жил хязгаарлалттай дүгнэлт авч байгаа. Тэгээд дандаа тэр нэг түрүүний яриад байсан гол асуудал тэр зоостой холбоотой зүйл. Тэр нь болохоор бүүр 25 онд гүйлгээнд гараад, буцаад 38 он эргээд татаад авчихсан. Одоо түүхийн дурсгал ховор үнэт зүйл мөн байх. Тухайн үедээ э...-р гарсан зүйл, тэгээд банк өөрийнхөө э...-р гаргасан юугаа мөнгөн тэмдэгтээ буцаагаад тэрийгээ актив дээрээ бүртгэх бол зөрчилтэй

байна гэдэг ийм зүйлийг л хэлээд байгаа юм. Хөндлөнгийн аудит энэ дээр үнэлгээгээ эргэж хараач, энийгээ актив дээрээ битгий бүртгээч гэдэг ийм зөвлөмжийг өгсөн. Энэ зөвлөмж бид нарын бид нарт байгаа мэдээллээр энэ өнөөдрийг хүртэл хэрэгжихгүй явж ирсэн. Манай өмнөх хяналтын зөвлөл маань энийг удаа дараа энийг хэрэгжүүлэх чиглэлд зөвлөмжөө хүргүүлсэн байдаг. Энэ зөвлөмжийг хэрэглүүлээч гэдэг ийм зөвлөмж.

Орон тоо, бүтэц орон тооны хувьд бид одоогоор нарийвчилсан шинжилгээ хийгээгүй байна. Энэ чиглэлд ажиллах ерөнхий төлөвлөгөө байгаа. Тэгэхдээ түрүүн хэлсэн. Бид манай Монголбанк гуравласан мандаттай 8 чиг үүрэг хуулиараа хүлээсэн, тэгээд дээрээс нь цаг үеийн нөхцөл байдлаас болж үүссэн байж болзошгүй дахиад миний ойлгосноор 3-аас 4 нэмэлт чиг үүрэг явж байгаа. Тухайлбал мөнгө угаах террористтой тэмцэх ч гэдэг юм уу, эсвэл банкны бүтцийн өөрчлөлт, банкны секторын реформуудыг ч гэдэг юм уу ингээд нэг чигийн үүрэг нэмэгдэнгүүт тэрийг дагаад нэг бүтэц, нэг газар, хэлтэс ингээд үүсээд ингээд явчихсан байгаа нэг асуудал харагдсан.

2 дахь асуудал нь магадгүй явцын дунд үүссэн шинэ чиг бүтцүүд маань хэсэг хугацааны дараа үүргээ гүйцэтгэсэн бол тэн дээр хумих ажлууд хийгдэх ёстой байх гэж бодсон. Тэр бол огт хийгдээгүй юм болов уу гэж харсан. Үүргээ гүйцэтгэсэн тухайн юунд газар, хэлтсийг буцаагаад эргүүлээд магадгүй татан буулгах, цомхотгох ийм шаардлагатай байгаа юм болов уу гэмээр ийм дүр зураг харагдсан. Дахиад чиг үүргийн нарийвчилсан шинжилгээ хийх нь зөв юм байна гэсэн ийм зөвлөмжийг бид хүргүүлэхээр ажиллаж байгаа.

**Р.Сэддорж:** Монголбанкны Дэд ерөнхийлөгч Энхтайван 4 номер. Би өөрөө хэлчихье.

**Г.Энхтайван:** Алдаржавхлан гишүүний асуултад хариулъя. Алдаржавхлан гишүүн энэ нүүрсний экспорттой холбоотой, төсвийн тодотголтой холбоотой асуудлыг хөндлөө. 2025 оны 2 дугаар сарын гүйцэтгэлээр экспорт 2 тэрбум орчим америк доллартой байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 174 сая доллароор буюу 8 хувийн бууралттай байгаад байгаа. Импортын хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 7 хувийн өсөлттэй байгаад байгаа. Яг энэ экспорт, импортын зөрөө нь өөрөө нөгөө талдаа үйлчилгээний дансаа оруулаад явахаар төлбөрийн тэнцлийн алдагдалд гараад байгаа. Уул уурхайн салбарын экспорт маань өөрөө нийт экспортын 94 хувийг дангаараа хангаж байгаа. Энэ 94 хувийн 65, 6 хувийг нь дангаараа нүүрсний экспорт хангаж байгаа. Тэгэхээр нүүрсний экспортоос дан ганц хамааралтай манай улсын эдийн засгийн хувьд энэ дээр зайлшгүй орлогын тасалдал үүсэх асуудал хөндөгдөж байгаа. Тэгэхээр.../минут дуусав/

**Р.Сэддорж:** Гүйцээж хариулъя 4 номер.

**Г.Энхтайван:** Төлбөрийн тэнцэл, орлогын дутагдлаас хамаарсан төлбөрийн тэнцлийн хямрал үүсэх эрсдэлтэй гэж үзэж байгаа. Энэ төлбөрийн тэнцлийн хямралыг дамжаахгүй, энийг илүү эрт байхад нь бодлогын зохистой арга хэмжээ авах үүднээс Төв банкны зүгээс Монголбанкны Ерөнхийлөгч ЗГ-ын хуралдаанд зөвлөх эрхтэйгээр оролцдог. Энэ хүрээндээ ЗГ-ын хуралдаан дээр ЗГ-аас хэрэгжүүлж байгаа аливаа төсөл, хөтөлбөрийг эрэмбэлэх, шаардлагагүй төсөл хөтөлбөрийг хойшлуулах, төлбөрийн тэнцэлд дарамт учруулахгүй хэлбэрээр цаг хугацааг тохируулах, шаардлагатай эх үүсвэрүүдийг гадаад санхүүжилтээр бий

болгох, дотоод төсвийн шинж чанартай хэлбэрээр төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхгүй байх гэсэн тийм зөвлөмжүүдийг ЗГ-т өгсөн байгаа.

**Р.Сэддорж:** Алдаржавхлан гишүүн тодруулж асууя.

**Ж.Алдаржавхлан:** Тийм Энхтайван Ерөнхийлөгчөө юу яагаарай, та хэд чинь макро эдийн засгаа хамгаалах ёстой том байгууллага шүү дээ. Тэгэхлээр бидний санаа зовж байгаа хамгийн том зүйл гэвэл эдийн засгийн асуудал маань ингээд хүндэрч, орлого, экспорт, импортын зөрөө маш их болоод нөгөө ханшийн ийм том алдагдал үүсчихээр чинь зээлийн хүү буурна гэж хэзээ ч байхгүй. Тийм учраас та бүгд маань энэ зоригтойгоор ЗГ-таа энэ төсвийн тодотголоор төсвийн зарлагаа бууруулах чиглэлээр ажиллах тийм зөвлөмжийг өгвөл яасан юм бэ гэсэн би зүгээр тийм санал байна. Яагаад гэхээр өнгөрсөн жил 2023-аас 2024, 2025 онд төсвийн ялгаа гэхэд 7 их наядаар төсвийн зарлага нэмэгдсэн байгаа байхгүй юу. 2 тэрбум доллароор нэмэгдэж байгаа юм төсвийн зарлага. Тэгэхээр энэ чиглэлээрээ бүсээ чангалах асуудалд орохгүй бол ер нь байдал хүндрэх юм биш биз дээ? Тэгээд Монголбанкныхаа Ерөнхийлөгчтэй та хэд ярилцаад албан ёсоор ЗГ-таа тэр зөвлөмж эд нар өгвөл яасан юм бэ гэсэн би та бүгдэд санал тавьж байна.

**Р.Сэддорж:** Номинчимэг гишүүнийг нэмээрэй асуулт. Саяын Алдаржавхлан гишүүний яриад байгаа зүйл маш үнэн зүйтэй зүйлүүд шүү дээ. Яагаад гэхээр энэ чинь яг сандардаг үеүд байгаа шүү дээ 12 сарын. Тэгээд энэ үеүүддээ ингээд анхаарахгүйгээр жишээ нь цагаан сарын дараа 4 сард бүх инфляц өсдөг, 9 сард өсдөг. Тэгээд энэ үеүд дээрээ Монголбанк анхаарахгүй байна. ЗГ-таа зөвлөгөө өгөхгүй байна, тэгээд дуудахаар нь л очдог ийм байдалтай байна. Та бүхэн чинь яг макро эдийн засгаа хянадаг, зөвлөгөө өгдөг байгууллага. Тэгээд 12 сарын 31-ний үед л яг тэр чигээрээ байх юм шиг ойлгоод л тэгээд цагаан сарын дараа ингээд нүүрсний экспорт энэ яг цагаан сарын үеэр унадаг. Энэ ойлгомжтой. Тэгээд энэ үе дээрээ ингээд угтуулсан арга хэмжээнүүдийг цаашдаа авах нь зүйтэй байх. Саяхан Ерөнхий сайд үгэндээ хэлж байна лээ. Ринчиндоржийн Батболд гишүүн.

**Р.Батболд:** Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Тэгээд яалт ч үгүй нэг цалин ороод ирсэн болохоор нэг асуучихъя. Урьд нь хэдэн төгрөг авдаг байж байгаад одоо яах вэ ингээд нэмэгдүүлэхээр орж ирж байгаа юм байна. Та нар чинь нөгөө хурлын урамшуулал энэ тэр гэж юм авч байгаа юу, авахгүй байгаа юу гэдэг энийг.

2 дугаарт нь манайх чинь цэвэр мөнгө нь өөрөө 1,3-хан тэрбум доллар болчихлоо. Инфляц маань өөрөө Монголбанк чинь 6 дээр барина гэж байсан. Сүүлийн мэдээгээр 9 гээд байдаг. Миний бодож байгаагаар энэ 10 даваад явчихсан байгаад байх шиг байгаад байна. Тэгээд ер нь энэ мөнгөний бодлого сая бодлогын хүүгээ нэмчихлээ. Энэ дээр Хяналтын зөвлөл маань ямархуу үүрэг оролцоотой оролцож явдаг юм бэ? Тэгээд энэ инфляц явах гээд байдаг. Энэ дээр хяналтын зөвлөл бодлого гаргаж, цааш нь Монголбанкны удирдлагатай ярьдаг юм уу, ярьдаггүй юу? Энэ дээр Хяналтын зөвлөлийн үүрэг гэж байгаа юу гэдэг нэг асуулт байна. Энийг юутай холбогдуулаад байна гэхээр тэр та хэдийн гаргасан тэр тайлан дээр ОУВС-ийн 2022 оны хараат бус байдлын үнэлгээ дээр тэр эрх зүйн хувьд хангалттай бус, тэгээд Монголбанкны удирдлагатай нэгэн адил эрх зүйн хариуцлага хүлээхгүй байна гээд хяналтын зөвлөлийг хэлчихсэн байна л даа. Тэгэхээр энэ дээр ямар оролцоотой явж байгаа юм бэ гэдэг нэг асуудал байна.

3 дугаарт нь тэр Монголбанкны өөрийнх нь алдагдал гэж нэг замбараагүй юм байгаа шүү дээ. Тэгээд хамаагүй яриад байж болдог ч юм уу, үгүй ч юм уу. Энэ дээр хэзээ та хэд нэг дүгнэлт гаргаад, энэ Эдийн засгийн байнгын хороон дээр хаалттай ч хамаагүй нэг мэдээлэл өгөх юм бэ? Энэ алдагдал ер нь яаж бууруулах юм гэдэг тал дээр ямар төлөвлөгөө байна вэ? 3 асуулт байна.

**Р.Сэддорж:** Хариулт 3 номер.

**Н.Ууганбаатар:** Хяналтын зөвлөлийн дарга Ууганбаатар. Батболд гишүүний 2 асуултад хариулъя. Мөнгөний бодлого дээр хяналтын зөвлөл оролцохгүй байх ийм хууль зүйн заалттай. Тэр нь болохоор 27<sup>1</sup>.2 санагдаж байна 2 дугаар заалтад. Цаад талынх нь үндсэн санаа нь мөнгөний бодлогоо боловсруулахдаа хэрэгжүүлэхдээ Монголбанк хараат бусаар ажиллах ёстой гэдэг Монголбанкны хараат бус байдлыг давхар баталгаажуулж өгсөн. Тэгээд хяналтын зөвлөл мөнгөний бодлого дээр оролцохгүй шүү гэдэг ийм байдлаар зохицуулалтыг хийж өгсөн. Энэ зөвхөн манайд ч биш бусад ийм хяналтын зөвлөлтэй Төв банкнууд дээр нэг иймэрхүү зохицуулалтууд байдаг. Энэ бол зөв зүйтэй болов уу гэж бид ингэж бодсон.

Хуримтлагдсан алдагдалтай холбоотой асуудал эмзэг сэдэв мөн. Түрүүн би тодорхой хэмжээнд хөндсөн 38<sup>1</sup> дүгээр заалт гэж байгаа. Тэгээд жоохон Төв банкны тухай хуулиа нарийвчлаад харвал Төв банкны ашгийн тухай нэлээн нарийн тусгасан байгаа тэр хууль дээр 35, 36 дугаар заалтууд дээр. Ашиг гэж яг юуг хэлэх вэ гэдэг дээр. Алдагдал дээр бол ганцхан ийм өгүүлбэрээр алдагдал гэдэг нь актив, пассив 2-ын хоорондын зөрөөг алдагдал гэнэ. Тэгээд энийг төсвөөр шилжүүлэх байдлаар шийдвэрлэнэ гэсэн иймэрхүү заалт орчихсон. Тэгээд би хувьдаа энэ заалтыг эргэж харах нь зөв юм болов уу гэж бодсон юм. Энэ дээр илүү нарийвчилж магадгүй тэр алдагдал яг ямар төрлийн алдагдлыг энэ төсөв рүү шилжүүлэх ёстой юм, ямар төрлийн алдагдлыг нь бид системтэйгээр бууруулах боломжтой юм гээд эндээ нарийн задаргаанууд хийх ёстой юм болов уу гэж харсан. Алдагдлыг бууруулах чиглэлээр стратеги төлөвлөгөө ОУВС сангийн хөтөлбөр хэрэгжээд Төв банкин дээр иймэрхүү төлөвлөгөө боловсруулагдаад явж байгаа гэсэн ийм мэдээлэл байгаа. Эцэслээгүй байгаа учраас бид тэрэнтэй нь одоогоор танилцаагүй байна.

**Р.Сэддорж:** 4 номер.

**Г.Энхтайван:** Батболд гишүүний энэ асуултад хариулъя. Энэ хяналтын зөвлөлийн гишүүдийн цалинтай холбоотой. 2014 оны 8 дугаар сарын 1-ний өдрийн Монголбанкны Ерөнхийлөгч Золжаргалын тушаалаар хяналтын зөвлөлийн дарга, гишүүдийн цалинг тогтоосон байсан. Тухайн үедээ энийг Хяналтын зөвлөлийн дарга нь 1167000 төгрөг, гишүүд нь 751500 төгрөгийн цалин авахаар урьд нь тогтоож өгөөд энэхүү тушаал нь 10 жилийн хугацаанд хүчинтэй явж байгаад одоо шинэчлэгдээд явж байгаа.

**Р.Сэддорж:** Батболд гишүүн тодруулж асууя.

**Р.Батболд:** Төв банкны ашиг, алдагдлын талаар янз бүрийн тооцоолох аргууд байдаг байх л даа. Тэгэхдээ одоо хийгдэж байгаа ажил биш, урьд онуудын алдагдлууд энэ талаар яриад байгаа юм. Тэгэхээр энийг нэг хөөж үзээч гэж хэлэх гээд байгаа байхгүй юу Хяналтын зөвлөл. Яг юунаас болоод алдагдал гарчихсан юм, ямархуу юмнууд байгаа юм. Энийгээ нэг тайлан бэлдэж гаргаж ирээч. Энэ

замбараагүй их мөнгө байгаа шүү дээ. Замбараагүй их байгаа шүү. Тэгэхээр энийг нэг оруулж ирээч гэдэг юу гэдэг юм санал танай Хяналтын зөвлөлд хүргүүлж байна.

**Р.Сэддорж:** Энэ саяын Батболд гишүүний хүсэлтийг бичгээр танилцуулах нь байна Батболд гишүүнд. Отгоншарын Батнайрамдал гишүүн.

**О.Батнайрамдал:** Баярлалаа. Надад нэг тодорхой л асуулт байна. Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны тойм дээр байна л даа. Сүүлийн 14 жилийн хугацаанд 4-өөс 5 жилийн хугацаатай мундаг гоё, гоё нэртэй зээлийн хүүг бууруулах хөтөлбөр, стратеги бодлогын баримт бичиг хангалттай хийсэн юм байна тийм ээ? Хангалттай бодлогын бичиг баримт, дахиад бараг шаардлагагүй ч юм шиг байна. Гэхдээ зээлийн хүү буурсан уу гээд үзвэл зээлийн хүү буураагүй харин ч өссөн. Уул нь ойлгомжтой. Зээлийн хүү ердөө хоёрхон зүйл байгаа шүү дээ. Эх үүсвэрийн зардал, банкны нэмэгдэл буюу маржин. Монголбанкнаас гаргасан 2025 оны 2 дугаар сарын энэ илтгэл дээр байна л даа. Банкны нэмэгдэл буюу маржин нь маань зээлийн хүүгийн дундаж хүү хадгаламжийн хүүгийн зөрөө 5,2-оос 5,8 хувь юм байна. Тэгэхээр энэ 2 дээр л бууруулж байж нэг ёсондоо зээлийн хүү буурна гэсэн үг байхгүй юу. Тэгэхээр банкны маржинг яаж бууруулах вэ өрсөлдөөн сайжрах ёстой. Эх үүсвэрийн зардал яаж бууруулах вэ явж, явж энэ дээр даацтай реформ хийе гэвэл ерөөсөө л гаднаас эх үүсвэр татах ёстой. Гаднын банк оруулж ирэх зохицуулалт. Олон жил яригдсан. Гэхдээ хүртэл ерөөсөө биелж өгдөггүй, яг хаанаа очоод гацчихдаг юм.

Банкны салбарын тогтвортой байдлын хүрээнд гадаадын банкны бие даасан салбар нэгжийг оруулж ирнэ гээд. Энэ Монголбанкны хамгийн гол 3, 4 хийх ёстой асуудлуудын нэг байгаад байдаг. Энийг хэрвээ бид хийж чадахгүй бол эх үүсвэрийн зардал бууруулах чинь өөрөө асуудалтай байхгүй юу. Хоёрхон зүйл байгаа шүү дээ. Эх үүсвэрийн зардал, тэгээд банкны маржин. Энэ нь орж, гаднын банкны салбар орж ирснээрээ өрсөлдөөн сайжирч маржин нь буурна, эх үүсвэрийн зардал нь өөрөө буурах. Ерөөсөө дорвитой зээлийн хүүг бууруулъя гэвэл ерөөсөө ганц л алхам байгаа нь энэ шүү. Тэгээд банк гаднын банк орж ирэх 2 тохиолдол байгаа. Нэг нь Монголд орж ирээд лиценз аваад цоо шинээр эхлэх. Гэхдээ энэ нь өөрөө олон улсын жишгийг авбал ер нь үгүй л дээ. Олон улсын жишиг юу гэхээрээ л merging д... буюу банкны хоорондын нэгдэл байхгүй юу. Монголд орж ирээд нэг ёсондоо банк худалдаж авна гэсэн үг. Тэгэхээр энэ дээр бүүр шийдвэр, шийдэл гаргаад явж болохгүй юу? Энэ өөрөө макро эдийн засгийн түвшин ч гэсэн Монгол Улсын урт, дунд хугацаандаа явж, явж зээлийн хүү бууруулах ганц боломж нь л энэ шүү дээ. Энийгээ хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Энэ дээрээ тэгээд улс төрийн байна уу, бүх төрлийн талаас нь оролцож байгаад томоохон шийдвэрээ гаргаад явж болдоггүй юм уу? Тэгээд энэ асуултыг асууж байгаад тодруулъя.

**Р.Сэддорж:** Хариулт 4 номер.

**Г.Энхтайван:** Батнайрамдал гишүүний асуултад хариулъя. Гишүүн тэр гадаадын банк оруулж ирэх нь гадаадын банк нь өөрөө эх үүсвэрийн зардлыг тодорхой хэмжээнд бууруулаад, арилжааны банкнуудын өрсөлдөөнийг тэтгэж, энэ нь өөрөө зээлийн хүүг бууруулах, инфляцыг нам доор түвшинд барих, макро эдийн засгийн тогтвортой байдалд эерэг нөлөөтэй гэж гишүүн хэллээ. Ер нь тантай 100 хувь санал нэг байна. Төв банкны хувьд гадаадын банкныг оруулж ирэх шат дараатай арга хэмжээнүүдийг удаа дараа авч байгаа. Яг одоогийн байдлаар Монголбанканд хүсэлтээ өгчихсөн гадаадын банк алга байна.



Төв банкны зүгээс Төв банкны удирдлагууд удаа дараа холбогдох улсуудад очиж Монгол Улсын банк, санхүүгийн салбар, түүний зохицуулалт, Монголд банкны үйл ажиллагаа санхүүгийн салбарт эрхэлснээр хэрхэн боломжтой байх талаар дэлгэрэнгүй танилцуулгуудыг удаа дараа хийгээд явж байгаа. Ер нь гадаадын банкиг шууд оруулж ирэхэд харьцангуй амаргүй байна. Урьд нь Монгол Улсад эдийн засгийн суурь нөхцөл байдлаасаа хамаараад 6-аас 7 орны арилжааны банкны төлөөлөгчийн газрууд ажиллаж байсан бол яг одоогийн байдлаар төлөөлөгчийн газраа ажиллуулж байгаа 2 л банк байна. БНХАУ-ын Bank of China мөн Industrial commercial bank of chine гэсэн 2 банк л байна.

Тэгэхээр Төв банкны зүгээс гадаадын банкиг оруулахад хэд хэдэн бодлогын арга хэмжээнүүдийг авч байгаа. Та түрүүн хэллээ merge in a...-ээр дамжиж орж ирдэг гэдэг. Яг энэ хүрээнд банкны салбарын шинэтгэлийн хүрээнд арилжааны банкнууд, системийн нөлөө бүхий банкнууд нээлттэй, арилжааны бусад банкнууд хаалттай хүрээнд хувьцаат компани болоод арилжааны банкны хувьцаа эзэмшигчийн дээд хэмжээг 20 хувь дээр буюу тогтоосон байгаад байгаа. Яг энэ хүрээнд арилжааны банкнууд өөрсдийн актив эзэмшлийн хувийг илүү гадаад улсын банк санхүүгийн байгууллагад санал болгож, энэ дээр гадаадын хөрөнгө оруулалтыг татах чиглэлээр үйл ажиллагаа эрхлээд явж байгаа гэж ойлгож байгаа. Хэд хэдэн банкны зүгээс Лондон, Нью-Йоркийн хөрөнгийн бирж дээр гарч, тухайн улсуудын Хөрөнгийн биржээр дамжиж гадаадын хөрөнгө оруулалтыг оруулах, гаднын банканд өөрийн хувь эзэмшлээ худалдах замаар гаднын банк оруулах чиглэлээр ажиллаж байгаа гэдгээ Төв банканд мэдэгдсэн байгаад байгаа.

Төв банкны зүгээс арилжааны банканд гадаадын банк санхүүгийн байгууллага хувь эзэмшээд явах бодлогыг нээлттэй дэмжиж байгаа. Гэхдээ энэ нь өөрөө нэг талаасаа тухайн арилжааны банкны хувьцаа эзэмшигчийн өөрийн эд хөрөнгийг хэрхэн үнэлж, ямар хэлбэрээр шилжүүлэх вэ гэдэг сонголтын асуудал байгаад байгаа. Төв банкны зүгээс энэ дээр зүгээр бодлогын хувьд дэмжлэг үзүүлээд, манай хууль, эрх зүйн орчин ийм нээлттэй байгаад байгаа, гадаадын банк ажиллахад ийм боломж байгаа гэдэг талаар илүү тийм зөвлөх чиг үүрэгтэй ажиллаж байгаа. Хэрвээ үнэхээр манай одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, эрх зүйн орчны хүрээ маань өөрөө гадаадын банкиг үйл ажиллагаа эрхлэхэд тааламжгүй эрх зүйн орчин гэж үзвэл энэ дээр бид бүхэн өөрчлөлтүүд хийгээд явна.

Гэхдээ олон улсын судалгааны байгууллагууд Монгол Улсын нэгдэн орсон олон улсын ийм банк санхүүгийн байгууллагууд манай санхүүгийн салбарын хууль, эрх зүйн орчинд хийсэн үнэлгээгээр манай эрх зүйн орчин гадаадын хөрөнгө оруулалтыг татахад харьцангуй эерэг таатай уур амьсгалтай орнуудын жагсаалтад орж байгаа. Гэхдээ эдийн засгийн маань суурь нөхцөл байдал маань өөрөө гадаадын банкнууд Монгол Улсад орж ирээд үйл ажиллагаа явуулах боломжийг олгохгүй байгаад байгаа. Гадаадын банкнууд ямар нөхцөлд орж ирдэг вэ гэдэг дээр судалгаа гарсан байгаа. Хамгийн үндсэн 1 дүгээр шалгуур бол гадаадын банкнууд төсөл хөтөлбөрөө дагаж орж ирдэг буюу тухайн санхүүжүүлэх төсөл хөтөлбөр нь бэлэн байвал орж ирдэг гэсэн тийм үндсэн.../минут дуусав/

**Р.Сэддорж:** Батнайрамдал гишүүн нэмж тодруулъя.

**О.Батнайрамдал:** Баярлалаа. Тэгэхээр Энхтайван Ерөнхийлөгчөө яг л адилхан тайлбар л яваад байна л даа. Ер нь зээлийн хүү буурах шаардлага байна

гээд байна уу гээд олон нийтээс асуувал ард иргэд дийлэнх нь, дийлэнх нь ч жичдээ бараг 100 хувь үнэхээр болохгүй байна гэдгийг бүгд мэдээд байгаа байхгүй юу. Яагаад энэ дээр улс төрийн зоригтой шийдвэр яг гарч болдоггүй юм бэ? Жишээлбэл төрд Төрийн банк гээд байж байгаа шүү дээ. Бусад банктай харьцуулахад төрд ямар давуу тал олгож байгааг хэлж мэдэхгүй байна одоо хүртэл хэлж мэдэхгүй байна. Төрд Монголбанкнаас өөр төрийн банк шаардлагатай юм уу? Жишээлбэл ингээд зах зээл дээр зарах боломжтой банкнууд байгаа байхгүй юу. Тэгэхээр иймэрхүү томоохон реформын шинж чанартай зүйл хийхгүйгээр зээлийн хүү буурна гэдэг чинь зүгээр 200 хуудас цаас болоод л 10 хэдэн жил болоод байна шүү дээ. Тэгэхээр энэ дээр нэг даацтай шийдэл гаргаж байж эдийн засгийн томоохон реформ буцаад эдийн засгийн хүндрэлтэй бид тэмцэнэ шүү.

**Р.Сэддорж:** Их Хурлын түүхэнд 7 жил энэ гадаадын банк оруулах талаар хуулийн төсөл явсан байна. Тэгээд сая энэ Батнайрамдал гишүүний хэлж байгаа энэ зүйлүүдийг шинэ Хяналтын зөвлөл, шинэ Монголбанкны сая томилогдсон Байнгын хороо, Улсын Их Хурлаас томилогдсон энэ шинэ албан тушаалтнууд энэ дээр бодлого гаргах хэрэгтэй. Түрүүнд Соронзонболд гишүүн санал гаргасан. Зээлийн хүү бууруулах тухай ажлын хэсгийг, бууруулах тухай асуудлуудыг судлах ажлын хэсэг гаргавал яасан юм бэ гэсэн. Зээлийн хүүг бууруулах тухай стратеги батлах тухай Улсын Их Хурлын тогтоол 20 оны тогтоол байгаа юм байна. Тэгээд энийг 4 удаа, 4 дэх удаа гарсан юм байна. Энийг шалгах ийм ажлын хэсэг гаргах, энийг хэрхэн хэрэгжиж байгаа тухай ажлын хэсэг гаргах боломжтой юм байна. Тэгэхээр Соронзонболд гишүүний гаргасан санал, тэгээд энэ гишүүдээс ажлын хэсэг гаргаасай гэсэн гишүүд нэлээн байдаг. Тийм учраас ажлын хэсэг гаргаж, ялангуяа шинэ сонгогдсон гишүүдээр дийлэнхийг нь бүрдүүлж ажиллах нь зүйтэй гэж үзэж байна. Ингээд Мөнхчулууны Энхцэцэг гишүүн үг хэлж, асуулт асууна.

**М.Энхцэцэг:** Сайн байцгаана уу, та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Өнөөдөр Монголбанкны хяналтын зөвлөлд цалин хөлс олгох асуудал, түүний үндэслэлийг Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцэж байна гэж ойлгож байна. Үүнтэй холбоотойгоор дараах 5 асуултыг асууя. Та бүхэн асуултад тодорхой хариулаад өгөөрэй. 1 дүгээрт яг энэ хяналтын зөвлөл маань байнгын үйл ажиллагаатай юм уу, долоо хоногт яг хэдэн цагийг Монголбанкны төлөө ажилладаг ийм хүмүүс вэ? Эсвэл ажлынхаа хажуугаар давхар хийдэг ажил уу гэсэн 1 дүгээр асуулт байна.

2 дугаар асуулт болохоор Монголбанкны хяналтын зөвлөл Монголбанкны үйл ажиллагаанд хийж байгаа хяналт шалгалтын үр дүнд хэрвээ үнэлгээ өгье гэвэл яг хэдэн хувьтай гэж үнэлэх вэ? Өнгөрсөн хугацаанд Хяналтын зөвлөл ажилласан үйл ажиллагаанд үнэлгээ өгье гэвэл хэдэн хувьтай гэж үнэлж байгаа вэ?

3 дугаар асуулт Монголбанкны үйл ажиллагаанд, үйл ажиллагааны яг хэдэн зорилтууд байдаг юм бэ? Тэдгээр зорилтуудын биелэлт та бүхэн яг хэдэн хувьтай гэж үзэж байгаа вэ? Энэ бүгдийг зорилт нэг бүрээр нь нэг хэлж өгөөч.

4 дүгээр асуулт Монголбанкны үйл ажиллагааны бие даасан байдал хэрхэн хангагдаж байгаа вэ?

5 дугаарт нь дөнгөж саяхан Монголбанкны Ерөнхийлөгч бодлогын хүүгээ нэмэгдүүлэх мэдэгдэл хийхдээ бодлогын хүүг нэмэгдүүлж байгаа гол үндсэн шалтгаан бол дулааны үнийн нэмэгдэл гэсэн ийм мэдэгдлийг хийсэн. Тэгэхээр энэ

дээр та бүхэн ямар үндэслэлтэй ямар тооцоо, өөрөөр хэлбэл дулааны үнийн өсөлт маань инфляцын түвшинд хэдэн хувиар нөлөөлнө гэсэн тооцооллыг та бүхэн хийсэн бэ гэсэн ийм 5 асуулт байна.

**Р.Сэддорж:** 5 асуулт, эхлээд 3 номер.

**Н.Ууганбаатар:** Хяналтын зөвлөлийн дарга Ууганбаатар. Энхцэцэг гишүүний асуултад хариулъя. 1 дүгээрт нь бид орон тооны бусаар үйл ажиллагаа явуулдаг. Хуулийн заалт дээр орон тооны бус гээд тодотгоод ингээд заачихсан байгаа. Тогтмол явуулах үйл ажиллагаа бол журам дээр улиралд нэг удаа хуралдана гэсэн ийм заалттай. Одоогийн байдлаар бид эхнийхээ улиралд 7 удаа хуралдчихаад явж байгаа. Тэгээд ажлынхаа төлөвлөгөөг бол харуулсан. Хавар бид ойролцоогоор хаврынхаа энэ 6 сар хүртэл 14 хоногт нэг удаа хуралдах иймэрхүү төлөвлөгөө гарсан. Зундаа арай бага шиг хуралдах байх, намар буцаад эргээд сард 1 юм уу, 14 хоногт нэг гэдэг ийм юу руугаа орох байх төлөв рүүгээ орох байх. Бид хурлын нэг өрөөтэй, хажууд нь хяналтын зөвлөлийн даргын нэг өрөөтэй. Би тэнд байнга сууж байгаа. Миний үндсэн ажил тэрний адилхан байранд байдаг учраас нэг байран дотроо наашаа, цаашаа яваад байх ийм боломжтой учраас тэнд бүтэн цагаар сууж байгаа юм.

Өнгөрсөн хугацаанд Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны үр дүн дээр өгсөн хяналтын зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийн биелэлтийг нь бид авч үзсэн. Тэр биелэлтийн хувь харьцангуй өндөр байсан. 90 орчим хувьтай ийм дүнг манай энэ дотоод аудит, хяналт маань бид нарт танилцуулсан. Зүгээр хуучин өмнөх юуныхаа хяналтын зөвлөлийнхөө хурлын протокол болон бусад мэдээлэл, Улсын Их Хуралд тайлангаа хүргүүлсэн байгаа Эдийн засгийн байнгын хороонд. Тэд нарыг ингээд харвал тодорхой зарим нэгэн асуудлуудыг байнга хөндөж ирсэн. Түүн дотроо тухайлбал журмын өөрчлөлтийг бид хийхгүйгээр энэ хяналтыг бүрэн хэрэгжүүлэх ямар ч боломжгүй байна гэдэг зүйлийг удаа дараа хөндөж тавьсан байсан.

Төв банкны зорилт нь юу вэ, хэдэн хувьтай биелдэг вэ гэдэг асуудал бол Төв банк маань үндсэндээ мандат бол ойлгомжтой 4-ийн Төв банкны тухай хуулийн 4.1 болон 4.2 дээр заасан мандатууд байгаа. Дээрээс нь 1993 оноос хойш жил болгон Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн бодлогын чиглэлийг 10 сарын 1-ний дотор өргөн барьж Улсын Их Хурлаар батлуулдаг. Тэгээд энэнийхээ, энэ дээр ямархуу цаашаа ямар арга хэмжээ авах вэ гэдгээ тодорхойлдог. Тэгээд энэ дээр магадгүй зүгээр харах ёстой үзүүлэлт нь инфляцаа тухайлбал зорилтот хэмжээндээ барьж чадаж байна уу, үгүй байна уу гэдгийг хамгийн эхэнд харах ёстой болов уу гэж ингэж бодож байна. Бусдаар үндсэн зорилт нь түрүүн нэлээн олон гишүүд хөндсөн макро эдийн засгийг тогтвортой байлгах, тэгээд тэр мандат дээр байгаа тэр Төв банкны тухай хуулийн 4.1 болон 4.2.

Бие даасан хараат бус байдлын хувьд олон улсын байгууллагууд болон судлаачдын гаргасан үнэлгээнүүд байдаг. Хамгийн сүүлийн үнэлгээгээр нэг миний санаж байгаагаар 60 орчим гэсэн 0-1 хооронд авах ёстой индекс хараат бус байдлын индексээр 65 гэсэн оноотой байсан гэж харсан. Энэ бол 18 онд энэ юу арай жоохон сайжирсан, тэрнээс өмнө нөхцөл байдал жоохон 50-иас арай жоохон бага байсан юм болов уу гэж харсан. Индекс нь нэг хараат бус байдлын индекс 65 орчим хувьтай байгаа байх. Тэгэхдээ энэ дээр яг тогтсон нэг индекс байхгүй. Дахиад хараат бус байдлыг нь үнэлдэг хэд хэдэн аргачлалууд байдаг. Тэгээд түүнийг

сайжруулсан үндэслэл нь 18 оны хуульд орсон өөрчлөлтүүд л байгаа. Дулааны үнэтэй холбоотой асуулт Энхтайван Ерөнхийлөгч хариулах байх.

**Р.Сэддорж:** 4 номер нэмж хариулъя.

**Г.Энхтайван:** Энхцэцэг гишүүний асуултад хариулъя. 2025 оны 3 дугаар сарын 6, 7-ны өдөр Төв банкны Мөнгөний бодлогын хороо хуралдаад бодлогын хүүг 2 нэгж хувиар нэмэгдүүлээд 12 хувьд хүргэсэн байгаа. Энэ дээр хэд хэдэн бид хэд бодлогын зохицуулалтуудыг оруулсан. Инфляц нийт 1, 2 дугаар сард 9,6, 9,7 хувьтай гарсан. Тэгээд энэ нь болохоор цахилгааны үнийн өсөлт, түүний дам нөлөө, эдийн засгийн идэвхжил, цалингийн өсөлтийг дагасан үйлчилгээ, түрээс, импортын барааны үнийн өсөлтөөс өндөр байсан гэж Төв банк үзсэн байгаад байгаа. Тэгээд эрэлтийн болон зардлын шалтгаантай үнийн дарамт нь хүлээлтээс давсан. Нийтийн тээвэр бусад төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээний үнэ өссөн гэж байгаа. Энэ бол дан ганц дулааны үнэ гэж бид бүхэн шийдвэрийг ерөөсөө гаргаагүй. Төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээний үнэ тодорхой хэмжээнд өссөн гэж байгаа. Энэ дээр дулаан, цахилгаан, нийтийн тээвэр бүгдээрээ.../минут дуусав/

**Р.Сэддорж:** Гүйцээж хариулъя, 1 минут 4 номер.

**Г.Энхтайван:** Яг дулааны үнийн өсөлтийг энэ жилийн 5 дугаар сараас нэмэгдэнэ гэсэн хүлээлтийг Төв банкны зүгээс мөнгөний бодлогын төсөөллийг хийхдээ аваад явж байсан. ЗГ-ын зүгээс сая сүүлд авсан мэдээллээр дулааны үнийн өсөлтийг энэ оны 12 дугаар сарын сүүл хүртэл хойшлуулж байгаа юм байна гэсэн ойлголттой байгаа. Цахилгааны үнэтэй холбоотой инфляц дээр үзүүлж байсан нөлөө 1,9 base поинтоор нөлөөлж байсан. Дулааны үнэ хэрвээ үүний өмнө Эрчим хүчний зохицуулах хорооноос гаргасан яг тэр хэмжээгээр нь нөлөөлсөн бол багцаагаар дахиад 1,2 base поинтын нөлөөтэй байсан. Тэгэхдээ энэ дулааны үнийн өсөлтийг хойшлуулсан гэж ойлгосон.

**Р.Сэддорж:** Энхцэцэг гишүүн тодруулж асууна.

**М.Энхцэцэг:** Баярлалаа тодорхой хариулт өгсөнд. 1 дүгээрт ямар ч байсан энэ хяналтын зөвлөл бол байнгын орон тоотой хүмүүс биш юм байна гэж ойлголоо. Байнгын үйл ажиллагаатай биш гэж ойлголоо. Тэгээд хуулиараа улиралд нэг удаа, сүүлийн үед сард нэг удаа хуралдах гэж байгаа юм байна. Тэгэхээр яах вэ энэ зөвхөн энэ хурлын төлөө ингээд цалин хөлс олгох тухай асуудал яригдаж байгаа юм байна гэж ойлгож байна. Тэгээд энийг бодох хэрэгтэй байх.

Дараагийн нэг тодруулах асуулт болохоор Монголбанкны үйл ажиллагааны яг хэдэн зорилтууд юм бэ? Бүүр нэг номерын зорилт энэ. Тэгэхээр хяналтын зөвлөлийн зүгээс энэ зорилтын биелэлт ер нь тэдэн хувьтай явж байгаа даа гэдэг нэг ядаж нэг ийм 5 зорилтуудыг хэлээд, Хяналтын зөвлөлийнхөө зүгээс зорилтуудын биелэлт ер нь тэдэн хувьтай гэдэг нэг юм хэлээч. Энэ дээр нэг аягүй жоохон бүрхэг хариулт өгчихлөө гэж ойлгож байна.

**Р.Сэддорж:** Хариулт 2 номер.

**Д.Энхжаргал:** Хяналтын зөвлөлийн гишүүн Энхжаргал байна. Хяналтын зөвлөлийн чиг үүрэгт мөнгөний бодлогод оролцохгүй байх хуулийн заалттай байгаа. Монголбанкны үндсэн зорилт дээр инфляц төгрөгийн тогтвортой байдал. Ийм

учраас энэ дүгнэлтийг Хяналтын зөвлөл одоогийн хуулийн хүрээнд гаргах боломжгүй. Харин энийг бол Улсын Их Хурлаар жилд нэг удаа хэлэлцдэг учраас тэнд дүгнэлт гаргах нь зүйтэй болов уу гэсэн мэргэжилтний хувьд ийм саналтай байна.

Үйл ажиллагаа байнгын уу, байнгын бус гэдэг дээр хурал нэгдсэн байдлаар олонхоороо хэлэлцэж санал, дүгнэлт, зөвлөмж гарч байгаа. Асуудал хариуцсан хүн болгон тухайн ажлыг хянаж, шалгаж, дүгнэлт, зөвлөмж хуралд танилцуулахын тулд байнга ажиллаж байгаа. Ийм учраас бид 1 сарын сүүлээр томилогдсон өнөөдөр 4 сарын 1 гэхэд 2 удаагийн.../минут дуусав/

**Р.Сэддорж:** Нэмж хариульъя, 2 номер гүйцээж хариульъя.

**Д.Энхжаргал:** Тэгэхлээр жишээлбэл хөрөнгө оруулалтын асуудал буюу түрүүн гадаад валютын нөөцтэй холбогдолтой хяналт шалгалт хийсэн үү гэж асууж байна. Тэгэхлээр Монголбанкнаас мэдээлэл шаардаад өнөөдөр авч чадаагүй байгаа. Одоогийн хууль буюу одоогийн журам дээр энэ мэдээллийг хэрхэн авах тухай нь зохицуулагдаагүй байгаа учраас шаардлага тавьж болохгүй байгаад байгаа. Бидэнд тийм эрх мэдэл нь байхгүй байгаа. Тэгэхлээр хуульд тодорхой өөрчлөлтүүдийг оруульъя гэсэн ийм саналтай байгаа.

Өмнөх 20 жилийн хяналтын зөвлөлийн хийсэн ажлыг харахад энэ валют, хөрөнгө оруулалт дээр яаж шалгалт хийх аргачлал нь батлагдаагүй. Энэ эрхийг нь хяналтын зөвлөлд өгөөгүй байгаа. Тэгэхлээр энийг хийх шаардлагатай байгаа. Нэлээдгүй их ажил хийж байж хяналтын зөвлөл үр өгөөжтэй, үр дүнтэй, өгсөн зөвлөмж нь биелэгддэг байхуйцаар хууль, эрх зүйн орчинд өөрчлөлт хийх зайлшгүй шаардлага өнөөдөр тулгамдсан асуудал болсон байна.

**Р.Сэддорж:** Ажлынхаа эхэн дээр дараа нь энийг ярьж болохгүй шүү дээ, унасан бөхөд шалтаг мундахгүй гэж. Ажил үр дүнгүй боллоо гээд дараа нь хэдэн жилийн дараа ингэх байсан ийм эрх мэдэл дутаад байсан, яг ингэж ажиллах гэж байсан ийм юм дутаад байсан гэдэг юман дээр очих вий. Та бүгдийн нэр л үлдэнэ шүү дээ. Тийм ямар их 126 гишүүн та бүгдийг итгэл хүлээлгэж шинээр томилсон, тэгээд амжилт гаргаарай. Ганзоригийн Тэмүүлэн гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**Г.Тэмүүлэн:** Би Монголбанктай холбоотой нэг хэд хэдэн асуултуудыг асууя гэж бодож байна. Эдийн засгийн байнгын хороон дээр зорьж орж ирж энэ асуудлыг хөндөж гаргаж тавьж байгаа. 1 дүгээрт эдийн засгийн нөхцөл байдал өөрөө сайнгүй байна, инфляц өөрөө өсөж байна, төсвийн орлого өөрөө тасалдах, орлого бүрдэхгүй байх нөхцөл байдал үүссэн. Залгуулаад Монголбанкны валютын нөөц өөрөө буурч байна. Уг нь ийм хүндрэлтэй нөхцөл байдалд Монголбанк макро эдийн засгийн зохистой бодлогыг өөрөө зохицуулалтыг өөрөө хийх ёстой, зохицуулагчийн үүргийг гүйцэтгэх ёстой. Би яг энэ үндсэн үүргээ Монголбанк хангалттай үүргээ биелүүлж чадахгүй байна гэж харж байгаа юм. Чадахгүй байна гэж харж байгаа юм.

Учир юу вэ гэхээр би энэ үндсэндээ Монголбанкны бие даасан, хараат бус байдалтай холбоотой асуудал. Бие даасан, хараат бус байдлаар үйл ажиллагаагаа явуулж чадахгүй байна. Би үндсэндээ магадгүй Монголбанкны чинь Ерөнхийлөгчийг танай банкны Ерөнхийлөгчийг энэ Сангийн сайд Жавхлан хийгээд байна гэж хараад байгаа юм. Сангийн яам та бүхний үүргийг гүйцэтгээд байна гэж хараад байгаа юм. Ийм байж болдог юм уу? ЗГ-ын бүтцийн нэг байгууллагад Улсын Их Хурлаас

томилогддог, Улсын Их Хуралд үйл ажиллагаа танилцуулдаг байгууллагын удирдлага тэр Сангийн яамны кассын машин шиг ажиллаж болдог юм уу? Өнгөрсөн долоо хоногт Сангийн сайд мэдэгдэл хийсэн. Монголбанканд бараг чиг үүрэг өгч байх шиг байгаа юм. Хятадын своп зээл буюу Хятадын ардын банкнаас авах зээлийг 500 сая ам.доллороор нэмэгдүүл, дээрээс нь алтаа барьцаалаад 300 саяын урьдчилгаа зээл ав гэдэг асуудлыг тавьж байна. Бараг 1 тэрбум долларын асуудлыг ярьж байна.

Уг нь Монголбанкны Төв банкны чинь хууль дээр ЗГ-аас ямар нэг байдлаар үүрэг даалгавар, чиглэл өгөхийг хориглодог. Үүрэг даалгавар, чиглэл өгөхийг хориглодог. Дээрээс нь Монгол банк ЗГ-аас хараат бус байна гэсэн бүүр онцгой заалттай шүү. Тэгээд энэ үүрэг даалгавар, чиглэлийнх нь дагуу Монголбанк энэ үүргүүдийг нь биелүүлж байгаа юм уу? Өмнөөс нь эрсдэлийг нь үүрэг өгсөн чиглэлийнх нь дагуу эрсдэлийг нь үүрээд ингээд үндсэндээ мөнгөнийхөө бодлогын хараат бус байдлыг алдагдуулж байгаа юм уу? Би энэ асуудлаар чинь Монголбанканд албан бичиг явуулсан, хариуг нь хугацаандаа ирүүлээгүй байна. Уг нь өнөөдөр Монголбанкны Ерөнхийлөгчөөс энэ асуудлыг асууя гэсэн. Осолгүй магадгүй Монголбанкны энэ принтер нь ажиллахгүй, цаас нь арай дуусчхаагүй байлгүй дээ. Хугацаандаа бичиг цаасны хариу өгөх зайлшгүй шаардлага байна.

Монголбанкны тухай хуулиар энэ ямар нэг ийм хууль бус хэлцэл гүйлгээ хийхийг, ЗГ-ын зээл болон энэ дээр баталгаа гаргахыг, дээрээс нь гадаадаас авах зээлийг дэмжих зорилгоор алтны нөөцийг барьцаалж ямар нэг хөрөнгө мөнгө босгохыг хориглодог. Энэ асуудлууд дээр та бүхэн ямар хариулт өгөх юм бэ? Яагаад албан бичгийн хариуг өгөхгүй байгаад байгаа юм бэ? Би нэг талдаа энэ бол, эхлээд энэ дээр хариулт авъя.

**Р.Сэддорж:** Хариулт 4 номер.

**Г.Энхтайван:** Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя. Тэмүүлэн гишүүнээс Монголбанкны Ерөнхийлөгчийн нэр дээр ирсэн албан бичгийн хариуг маш ойрын хугацаанд энэ долоо хоногтоо багтаан гишүүнд хүргүүлбэ. Энэ дээр манай холбогдох газар, нэгжүүд энэ төлөвлөгөөг боловсруулж байгаа болов уу гэж бодож байна. Тэр ЗГ-аас Төв банканд хугацаатай үүрэг даалгавар өгөөд гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэх талаар гишүүн хөндлөө. Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар экспортын орлогыг нэмэгдүүлэх чиглэлтэй ажлын хэсэг гарсан гэж ойлгосон. Энэхүү ажлын хэсэгт Төв банкны Ерөнхийлөгч зөвшилцөх байдлаар оролцож байгаа. Төв банк ЗГ 2 хоорондоо хэрхэн харилцах талаар хуулийн нарийн зохицуулалттай. Төв банкны Ерөнхийлөгч ЗГ-ын хуралдаанд буюу ЗГ-т зөвлөх эрхтэйгээр оролцдог. Энэ хүрээнд энэ эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулаад экспортын орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр энэ ажлын хэсэгт зөвлөх чиг үүрэгтэйгээр оролцож байгаа гэж ойлгож байгаа.

Өнгөрсөн долоо хоногт тэр гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэхтэй холбоотой Сангийн сайдын гаргасан мэдээллийн өмнө Төв банк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Хадгаламжийн даатгалын корпорацийн удирдлагуудаас бүрддэг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл хуралдаад, тухайн зөвлөлөөр гаргасан зөвлөмжийн дагуу гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэх хүрээнд зөвлөлийн гишүүн байгууллагуудад Хадгаламжийн даатгалын корпорацийн эзэмшиж байсан гадаад ЗГ-ын бондыг арилжаалаад, америк долларыг Монголд оруулж ирэх, мөн энэ нь Төрийн банкны эзэмшиж байсан долларыг арилжаалаад

буцааж оруулж ирэх чиглэлээр зөвлөмж гарсан гэж ойлгосон. Зөвлөмжийн хүрээнд Хадгаламжийн даатгалын корпорац өөрийн үйл ажиллагаандаа өөрчлөлт оруулаад энэхүү доллароо буцаж оруулж ирж байгаа гэж ойлгосон.

Мэдээж Төв банкны үйл ажиллагаанд хөндлөнгөөс зөвлөмж өгөх тийм асуудал хуулиар хориотой. Гэхдээ Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн хүрээнд зөвлөлийн гишүүн байгууллагуудын хүрээнд ажлаа ярилцаад, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах хүрээндээ энэ асуудлыг шийдэж явдаг гэж ойлгож байгаа. Ер нь Монголбанкны хараат бус байдалтай холбоотой Тэмүүлэн гишүүний хөндөж байгаа асуудлыг бүрэн дүүрэн хүлээж авч байна.

**Р.Сэддорж:** Тодруулж асууя Тэмүүлэн гишүүн.

**Г.Тэмүүлэн:** Нөгөө бурхангүй газрын бумба галзуурна гэдэг шиг уг нь байр байрандаа, хууль дүрэм журмынхаа дагуу баймаар байх юм. Тэгээд та бүхний энэ хууль бус үйлдэл чинь эргээд юу гэдэг юм эс үйлдлүүд чинь эргээд энэ эдийн засагт өөрөө хор уршигтай. Эдийн засгаа магадгүй элгээр нь хэвтүүлчхээд бид бүхэн улсаараа энэ ОУВС-ийн хөтөлбөрт орохоос өөр гарцгүй болж магадгүй байгаад байгаа юм. Гэтэл та нар уг нь энэ дээр зохицуулалтууд хийх ёстой байтал ЗГ-ынх нь хүсэлтээр эрсдэлийг нь үрээд байдаг, шидэт дохиур нь болоод байдаг, мөнгөний кассынх нь машин нь болоод байдаг. Би үхэхээр чи үх гэхээр нь өмнүүр нь орж яваад байдаг, эрсдэлийг нь үүрдэг энэ чинь өөрөө үндсэндээ та нар эдийн засгаа хорлож байна. Ийм зүйл байж болохгүй. Албан бичигт хариугаа өг. Улсын Их Хурлаас томилогдсон удирдлагууд байгаа юм бол тэрнийхээ дагуу үүрэг даалгаврын дагуу ажилла. Эдийн засгийн байнгын хорооноос гарч байгаа би саналыг дэмжиж байна. Энэ ажлын хэсэг гарга. Энэ дээр бид ер нь ямар.../минут дуусав/

**Р.Сэддорж:** Тэмүүлэн гишүүн 1 минут.

**Г.Тэмүүлэн:** Монголбанкны энэ хараат бус байдалтай холбогдуулж Монголбанкнаас сүүлийн үед явуулж байгаа үйл ажиллагаатай холбогдуулж ер нь бид Улсын Их Хурлаас ажлын хэсэг гаргаж, энэ асуудлууд дээр нь үйл ажиллагаа дээр нь хяналт шалгалт зайлшгүй хийх ёстой. Бид асуудлыг уг нь бага дээр нь хүндрүүлэхгүйгээр аваад гарах уг нь боломж бололцоо байгаа. Энэ хүнд нөхцөл байдал хүнд байна. Дотроо бодолтой, доороо суурьтай, уг нь болгоомжтой хандах, эдийн засагт нэг савлагаанаас хамгаалах ийм зохицуулалтыг л хийх цаг мөч байгаад байгаа юм.

Гэтэл Сангийн яам нь энэ дээр тодотголоо хий гээд байдаг, эрсдэлээ хамгаал гээд байтал эсрэгээрээ гүрийгээд байдаг, 6 сар гаргадаг. Магадгүй ингээд хамаг тендерүүд нь зарлагдсан хойно ямар нэг төсвийн хэмнэлт хийх боломж бололцоогүй хойно тодотгол эд нарыг хийгээд байх ямар ч шаардлага байхгүй. Гэтэл эсрэгээрээ та бүхэн тэр Монголбанк Сангийн яаманд амь тариа хийж өгөөд аргацаагаад байж болохгүй байхгүй юу. Энэ чинь эдийн засгаа элгээр нь хэвтүүлэх гэж байгаагийн чинь бодит илэрхийлэл болж байна гэж хараад байгаа юм. Тэгэхээр энэ дээр Улсын Их Хурал нухацтай хандах ёстой шүү. Эдийн засгийн байнгын хорооны даргаа энэ асуудлуудыг авч үзээрэй.

**Р.Сэддорж:** Сая Тэмүүлэн гишүүний энэ гаргасан саналуудыг Монголбанк Хяналтын зөвлөлийнхөн ажил хэрэг болгоорой. 3 хоногийн дотор хариуг нь өгөөрэй,

5 дахь өдөр 3 хоног. Мөн түрүүнд хэн гишүүн билээ Р.Батболд гишүүн ны асуултад бичгээр өгөх ажлыг 3 хоногийн дотор шүү. Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийг мэдээлэл хий гэж Эдийн засгийн байнгын хорооноос албан бичиг явуулсан байгаа. Энд Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгч бүгд орсон энэ зөвлөлийн мэдээлэл тун удахгүй Байнгын хороон дээр орно. Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн.

**Д.Энхтүвшин:** Би 2 асуулт асууя. Нэгдүгээрх эхнийх нь болохоор хяналтын зөвлөлөөс яг энэ Монголбанкны бие даасан байдалтай холбоотой ер нь ЗГ жишээлбэл албан ёсоор ингээд татвар тавьж, ард иргэдээс татвар хурааж байгаа. Дээр нь нөгөө талд нь Монголбанкны хамгийн гол төгрөгийн тогтвортой байдал, өөрөөр хэлбэл иргэдийг энэ инфляцаас хамгаалах, инфляц буюу энэ нь бол чимээгүй татвар байгаа. Тэгэхээр өөрөөр хэлбэл нэг талын ийм татвар байгаа. Тэгэхээр энэ дээр жишээлбэл бид маш том үүрэг хариуцлагатай энэ бүтэц маань бие даасан байдлаа хадгалж чадахгүй байна уу гэж үйл явдал өнгөрсөн тоонуудаас харагдаж байна. Жишээлбэл мөнгөний бодлогын хүүг 2 хувиар жишээлбэл огцом нэмэх шаардлагагүй байсан. Жишээлбэл сонгуулийн үед яг энэ үед ЗГ-таа илүү ая тал зассан иймэрхүү байдалтай шийдвэрүүд гаргаж байсан.

Эдийн засгийн идэвхжилийн хувьд Монголбанкны хувьд бид хамгийн Монгол Улсад хамгийн сайн судалгаа хийх бололцоотой ийм чадвартай газар гэж бие даасан тэгээд ийм чадвартай хүмүүс байдаг газар гэж боддог. Тэгэхэд ерөнхийдөө манай эдийн засаг Хятадаас хамааралтай гэдэг нь ойлгомжтой. Нүүрсний, Хятадын үл хөдлөх хөрөнгийн зах зээл удааширчихсан. Үл хөдлөх хөрөнгүүд нь борлогдохгүй үнэ нь унаж байгаа. Тэгэхээр коксжих нүүрсэнд ирэх ачаалал нь ойлгомжтой байсан. Аж ахуй эрхлэлтийн хувьд ч гэсэн өнгөрсөн оны хагас жилийн тоогоос харахад ч гэсэн оны эцсийн сүүлийн байдлаар 4,6 их наядын татварын өр буюу 50 хувиар өнгөрсөн оны мөн үе 2023 оны эцсээс жилийн дараа 50 хувиар татварын өр нэмэгдчихсэн байгаа. ААН-үүд дээр ачаалал эдийн засгийн идэвхжил буурчихсан гэдэг мэдээллүүд байсаар байхад жишээлбэл мөнгөний бодлогын хүүгээ ингэж хожуу хуримтлуулж байгаад огцом ингэж авч байгаа нь бие даасан байдал хангалттай биш байна гэж харагдаж байна. Тэгэхээр энэ дээр ямар арга хэмжээнүүд авбал жишээлбэл илүү сайжрах бололцоо байна гэж Хяналтын зөвлөл харж байна вэ?

2 дугаарт нь Монголбанкнаас асуулт байна. 38<sup>1</sup> дээр пассив нь активын хөрөнгөөс хэтэрсэн тохиолдолд ЗГ үнэт цаас гаргах замаар энэ зөрөөг нөхнө гэсэн ийм заалт энийг Улсын Их Хуралд оруулж ирж танилцуулах ёстой. 2023 оны дүнгээр болохоор нийт актив 19 их наяд, тэгээд пассив 26 гэхээр 7,3 их наядын жишээлбэл ийм зөрөө байна. Өөрөөр хэлбэл энэ ЗГ-ын үнэт цаас гаргаж өөрөөр хэлбэл ЗГ-ын өр жишээлбэл энэ асуудлуудыг шийдэх ёстой байсан юм уу гэж харагдаад байгаа энэ заалтаар. Тэгэхээр энэ нь өөрөө ЗГ-ын өр төлбөрийг бодитой бусаар илэрхийлж байна гэсэн байдал харагдаж байгаа. Тэгэхээр энэ дээр ер нь энэ заалтыг Монголбанкны зүгээс түрүүн Хяналтын зөвлөл энийг өөрчлөх хэрэгтэй гэж хэлж байсан. Монголбанкны зүгээс энэ талаар жишээлбэл ямаршуу бодолтой байдаг юм бэ? Энэ заалтыг хэрэгжүүлэх нь, гол нь энэ тодорхой бодлого, зорилготойгоор энэ заалтыг оруулж байсан. Өөрөөр хэлбэл ЗГ-ыг илүү хариуцлагатай болгох. Тэгэхээр энэ заалтын талаар Монголбанкнаас асууя. Ийм 2 асуулт байна.

**Р.Сэддорж:** Хариулт 3 номер.



**Н.Ууганбаатар:** Хяналтын зөвлөлийн дарга Ууганбаатар. Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Бие даасан хараат бус байдал дээр гишүүд түрүүнээс хойш нэлээд олон өнцгөөс нь хөндөж байх шиг байна. Ерөнхийдөө Монголбанк, Улсын Их Хурал, Засгийн газар гэсэн энэ гуравласан харилцааг анхаарч үзэх шаардлагатай. Ер нь юу хийвэл, яавал болох вэ гэдэг дээр үндсэндээ хуулиа эргэж харах нь зөв болов уу гэж бодож байна. Засаглалыг нь дахиад эргэж харах нь зөв болов уу гэж бодож байна. Дахиад түрүүний миний хөндсөн нөгөө олон чиг үүргийг өгнө гэдэг нь Монголбанк чадахгүй гэдэг утгаар нь биш, тэр олон чиг үүргийг нэг байгууллага нэгэн зэрэг тогтворжуулах нь өөрөө онолын хувьд боломжгүй байгаад байдаг шүү гэдгийг гэсэн ийм мессежийг түрүүн би өгөх гэж үзсэн. Тэгээд тэр өнцгөөс нь харах хэрэгтэй. Үндсэн гол чиг үүргийг нь өгөөд, тэгээд хараат бусаар үйл ажиллагаа явуулах эрхийг нь өгөөд, хариуцлагыг нь үүрүүлээд сонгодог тогтолцоо нь ерөнхийдөө тийм. Тэгээд тэр сонгодог жишиг рүү нь нэлээн ойртох нь зөв болов уу гэж ингэж бодож байна.

Нөгөө нэг давхар зүйл мэдээж хяналтыг сайжруулах ёстой. Хяналт өөрөө давхар дундаа явж байх ёстой. Тухайлбал энэ хуримтлагдсан алдагдлыг их олон удаа хэлэлцээд, нарийн ширийн бүх юмыг нь Эдийн засгийн байнгын хороо маань өөрөө маш нарийн мэдээлэлтэй болчихсон энэ тэр юм байх ёстой. Тэгээд өнөөдөр ийм зүйл харагдахгүй байна. Энийг дахиад бид өөрөө хяналтын зөвлөлийнхөө хурал дээр тодорхой эхний мэдээллийг авсан. Зүгээр олон улсын онолын хувьд Төв банкны балансыг consolidated budget буюу төсвийн нэг тусгал гэж ингэж үздэг ийм зүйл бий. Цаад талын тэр 38<sup>1</sup> дүгээр заалт нэгэнт ЗГ-тай үйл ажиллагаа нь тодорхой хэмжээнд уялдаатай явж байгаа тохиолдолд энэ алдагдлыг нь ЗГ-т нь хариуцуулах нь зүйтэй гэсэн иймэрхүү логик давхар явж байгаа. Тэгээд энэ давхар хяналтыг баталгаажуулсан нэг заалт мөн юм. Тэгээд энийг хэрэгжүүлэх тал дээр, яагаад хэрэгжээгүй гэдгийг илүү нарийн харах нь зөв байх. Дахиад түрүүн Байнгын хорооны дарга маань хэлж байх шиг байна. Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн мэдээллийг ер нь сонсох нь зөв болов уу гэж бодож байна.

**Р.Сэддорж:** 4 номер.

**Г.Энхтайван:** Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Төв банкны тухай хуулийн 38 дугаар зүйл дээр Монголбанкны алдагдлыг нөхөх тухай зохицуулалтыг оруулсан байдаг. Монголбанкны пассив нь актив хөрөнгөөс хэтэрсэн тохиолдолд ЗГ үнэт цаас гаргах замаар зөрөөг нөхөх асуудлыг Улсын Их Хурал шийдвэрлэнэ гэсэн байдаг. Яг одоогийн байдлаар Төв банкны актив, пассивын зөрөө 7,4 их наяд төгрөгтэй байна. Энэхүү хуулийн зорилго нь мэдээж Монгол Улсын хувьд нэгдсэн нэг баланстай байх үүднээс Төв банкны алдагдал нь өөрөө Монгол төрийн алдагдал юм гэдгийг энэ хууль дээр зохицуулалтаар оруулж өгсөн байдаг.

Төв банкны зүгээс энэ Монголбанкны энэ актив пассивын зөрөө нэмэгдээд байгаатай холбогдуулан энэ дээр Улсын Их Хуралд холбогдох хүсэлтээ ер нь гаргана. Актив хөрөнгөөс нэмсэн пассивыг бол ЗГ-ын үнэт цаасаар барагдуулах боломж нь тэгэхдээ манай эдийн засгийн хувьд.../минут дуусав/

**Р.Сэддорж:** Энхтүвшин гишүүн тодруулж асууна.

**Д.Энхтүвшин:** Тийм. Саяын яг энэ checks in balance гэдэг шиг яг энэ эдийн засаг чинь өөрөө ингээд хоорондоо тохиргоонуудтай байгаа. Тэгэхээр энд энэ нэг заалтыг нь хэрэгжүүлэхгүй болохоор нөгөө талдаа бид буруу төсөөлөлтэй эдийн

засгийн хувьд. ЗГ-ын өр жишээлбэл энэ ЗГ-ын үйл ажиллагаа явуулах хязгаарыг буруу төсөөлөл мэдээллүүд өгөөд байгаа учраас энэ нь өөрөө буцаад энэ ачааллыг чинь гол нь иргэд, ААН-үүд инфляцаар, татвараар ингээд аваад байгаа. Тэгэхээр энэ заалтыг өмнө нь ингээд хэрэгжүүлээгүй. Би яах вэ энэ заалтыг хэрэгжүүлэх нь зөв юм байна гэж юу Монголбанкны зүгээс бодож байгаа юм байна. Энэ асуудлыг удахгүй оруулж ирэх юм байна ойлголоо зөв үү?

**Р.Сэддорж:** 4 номер хариулъя.

**Г.Энхтайван:** Хууль дээр Төв банкны тухай хуулийн 38.1 дээр энэ маш дэлгэрэнгүй нарийн тодорхой заагаад явчихсан. Төв банк өөрийн бодлого, үйл ажиллагаагаа Төв банкны хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна. Тэгэхээр хуулийн заалтыг биелүүлэх чиглэлээр үйл ажиллагаа оруулна. ЗГ-т энэ Төв банкны актив пассивын зөрөөг Монголбанкны Ерөнхийлөгчийн зүгээс Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл дээр жил болгон танилцуулдаг. Тэгэхээр энэ дээр ЗГ-ыг төлөөлөөд Сангийн сайд Тогтвортой байдлын зөвлөлд ордог. Тэгэхээр энэ чиглэлээр илүү дэлгэрэнгүй мэдээлэлтэй байгаа гэж үзэж байгаа ЗГ-ыг.

**Р.Сэддорж:** Хариулт хангалтгүй гэж үзэж байна. Энхтүвшин гишүүн.

**Д.Энхтүвшин:** Хариулт гэхээсээ илүү зүгээр нэг санал Байнгын хороонд хэлэх гэсэн юм. Яг энэ заалтын хувьд болохоор Улсын Их Хурал өөрөө санаачилдаг байхгүй бол Монголбанкны зүгээс, ЗГ-ын зүгээс яг энэ заалтыг хэрэгжүүлэхгүй байх хандлага өнгөрсөн хугацаанд харагдаж байсан учраас Эдийн засгийн байнгын хорооны энэ асуудлуудыг анхааралдаа авах, цаашдаа авах ёстой юм байна гэсэн саналыг Байнгын хороондоо хэлмээр санагдлаа.

**Р.Сэддорж:** Одсүрэнгийн Номинчимэг гишүүн.

**О.Номинчимэг:** Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Өнөөдөр ингээд Хяналтын зөвлөл байгуулагдсанаас хойш үйл ажиллагааны тоймоо оруулаад төлөвлөгөөгөө Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцүүлж байгаа юм байна. Тэгэхээр яах вэ энэ дээр тодорхой нэг асуулт асууя гэж бодсон юм. Та бүхэн хяналтын зөвлөлийн хувьд зээлийн хүүг бууруулах чиглэлээр 2011-ээс 23 онд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар ерөнхийдөө дүгнэлт тойм хийсэн байна. Энэ чиглэлээр ажиллана гэж орсон байна. Бид банкны хүүг буулгана гэхээр ер нь тэгээд л олон хүчин шалтгаан байна. Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэл, Дампуурлын хууль чинь болохгүй байна. Credit score систем Монголд хөгжөөгүй байна. Монголбанкны улс төрийн нөлөөллийг багасгах хэрэгтэй байна. Санхүүгийн бүтээгдэхүүнүүдээ илүү олон төрөл болгож байж зээлийн хүүгээ бууруулна гээд макро, микро аль ч түвшиндээ олон юм хийхээр ярьдаг. Тэгээд та бүхний яг энэ тайлан тойм тайланд чинь нэг ийм formula base тэгшитгэлийг гаргасан байна л даа. Зээлийн хүү гэдэг бол эх үүсвэрийн зардал, банкны нэмэгдэл буюу маржаас ингээд болж байгаа юм гээд.

Тэгээд өдий хүртэл хийсэн ажлуудыг асуудлуудаа ингээд хараад ирэхээр миний харж байгаагаар мэдээж шийдэх ёстой, бид нарын хийх ёстой юмнууд байгаа. Гэхдээ нөгөө талаараа энэ дээр арилжааны банкнууд зээлийн хүүгээ бууруулах тал дээр ямар нэгэн хүчин чармайлт ерөөсөө гаргадаггүй. Яагаад гэвэл та бүхний яг энэ гаргаж ирж байгаа тэгшитгэлийн дагуу арилжааны банк маржинаа л нэмчихнэ. Бүх эрсдэл тооцоо тэр юунууд байгаа эх үүсвэрийн зардлуудаа гаргаад тэр эрсдэл нь өндөр гээд гаргаад ирье. Энэ дээр автоматаар л арилжааны банк

маржинаа нэмчхэж байгаа шүү дээ. Тэгэхээр ямар ч тохиолдолд арилжааны банк өөрийн маржинаа аваад ингээд ажиллах нөхцөл нь байгаа учраас арилжааны банкнууд маань өөрсдөө энэ зээлийн хүү бууруулах тал дээр, санхүүгийн бүтээгдэхүүнүүдээ илүү оновчтой болгох ч байдаг юм уу, credit score системээ илүү нарийвчилж оновчтой болгох гэдэг дээр ерөөсөө санал санаачилга гарахгүй байна.

Тэгэхээр та бүхэн ингээд энэ formula тэгшитгэлээ бид харах ёстой, эргэж харах ёстой байна, яагаад үр дүнг өгөхгүй байна гэдэг дээр гээд дүгнэлтээ бичсэн байна л даа. Тэгэхээр яг миний асуух гэж байгаа асуулт бол та бүхний хувьд Хяналтын зөвлөлийн хувьд мэргэжлийн хүмүүс байгаа, Монголбанкинд ажиллаж байсан хүмүүс байгаа. Яг энэ арилжааны банкнуудаас тэгвэл ямар хүчин чармайлт хэрэгтэй гэж үзэж байгаа юм зээлийн хүүг бууруулахад? Мэдээж бид энэ бодлогын хүрээний юмнуудаа хийнэ. Макро эдийн засгийн юмнуудаа хийнэ. Гэхдээ арилжааны банкнуудаас энд нь хүчин чармайлтыг нь бид авахын тулд ямар хөшүүрэг хэрэгтэй гэж үзэж байна вэ? Ер нь энэ тэнцэл дээрээ бид юу юуг анхаарах ёстой гэж харж байна гэдэг дээр та бүхэн өөрсдийнхөө энэ дүгнэлтэд үндэслэсэн хариултаа өгөөч гэж хэлмээр байна.

**Р.Сэддорж:** Хариулт 3 номер.

**Н.Ууганбаатар:** Хяналтын зөвлөлийн дарга Ууганбаатар. Номинчимэг гишүүний асуултад хариулъя. 1 дүгээрт банкнууд үнэхээрийн чармайлт гаргахгүй байна уу, үгүй байна уу гэдгийг бид дахиад шалгаж үзэх ёстой байх. Яах вэ өмнөх стратеги төлөвлөгөөнүүд дээр их олон арга хэмжээнүүд санал болгосон. Зүгээр яах вэ шууд банкны хүүд нөлөөлнө гэхээсээ илүү голцуу дам нөлөөлөх иймэрхүү зүйлүүдийг хэрэгжүүлсэн юм болов уу гэж ингэж ойлгосон өөрчлөлтүүдийг. Нэлээн хэсэг хугацааны дараа нэлээн явж байгаад бүтцийг нь өөрчлөөд, юу гэдэг юм чанаргүй зээлүүдийг нь бууруулаад ингээд, ингээд, зээлийн мэдээллийн сангаа байгуулаад гэх мэтийн иймэрхүү байдлаар.

Банкны бүтцийн өөрчлөлттэй холбоотой банкин дээр хийгдсэн өнгөрсөн хугацаанд хийгдсэн томоохон реформуудыг та бүхэн сайн мэдэж байгаа байх. Тэрнийхээ тэр чиглэлийнхээ дагуу тодорхой арга хэмжээнүүд авсан. Гэхдээ зээлийн хүү тодорхой хэмжээнд жоохон орхигдсон юм болов уу гэсэн иймэрхүү дүр зураг харагдсан. Энэ дээр би өөртэй чинь санал нэг байгаа. Зүгээр банкнуудыг илүү 1 дүгээрт чармайлт гаргахгүй байгаа юу, үгүй юү, 2 дугаарт эсвэл хангалттай чармайлт гаргаад болохгүй байна уу. 2 дугаарт яах вэ гэхээр энэ дээр Монголбанк маань өөрөө яг ямар, ямар арга хэмжээ авч хэрэгжүүлсэн бэ энэ тэр гээд дахиад нарийвчлаад харах ёстой болов уу гэж бодож байна. Тэгээд та харсан бол эхний 3 зээлийн хүү бууруулах стратеги дандаа Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл дээр батлагдсан байгаа. Тэгээд энийг дахиад нөгөө тогтвортой байдлын зөвлөл Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн мэдээллийг сонсохдоо та бүхэн маань энэ асуудлаа давхар хөндөж асуувал илүү зөв болов уу гэж бодож байна. Бидэнд арилжааны банкнуудтай шууд холбогдох ийм суваг одоогоор байхгүй. Банкнуудын холбоотой албан уулзалтыг зохион байгуулъя гэсэн ийм төлөвлөгөө хийчхээд явж байгаа.

**Р.Сэддорж:** Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Монголбанкны хяналтын зөвлөлийн ажиллах журам батлах тухай Улсын Их Хурлын 2023 он, 2003 оны 39 дүгээр тогтоолын хавсралтын 6.1 дэх заалтад Хяналтын зөвлөлийн дарга, гишүүдэд түүний Хяналтын зөвлөлийн ажилд оролцсон байдлыг харгалзан ажлын хөлс олгох

бөгөөд түүний хэмжээ, ажлын хөлс олгох журмыг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороотой зөвшилцөн Монголбанкны Ерөнхийлөгч батална гэж заасны дагуу Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүдэд цалин хөлс олгох тухай Монголбанкны Ерөнхийлөгчийн ирүүлсэн саналыг хэлэлцэж дууслаа.

Монголбанкны Ерөнхийлөгч хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд энэ асуудлаа шийдвэрлэх хэрэгтэй. Монголбанкны хяналтын зөвлөлийн ажиллах журмыг шинэчлэх тухай саналаа ойрын хугацаанд ирүүлэхийг хүсье. 2003 оноос хойш 22 жилийн хугацаанд нийгэм, эдийн засгийн байдал өөрчлөгдсөн. Монголбанкны Хяналтын зөвлөл ч энэ хугацаанд хэд хэдэн удаа шинэчлэгдсэн байгаа. Тиймээс одоо ажиллах журам арга барилаа шинэчилж өөрчлөх нь зүйтэй гэдгийг дахин хэлье. Тэгээд тодорхой хугацааны дараа та бүхэн дүнгээ тавиулна. Тэр үеийн Их Хуралд нүүр бардам тайлангаа тавих ажлаа эхнээс нь ямар зүйл шаардлагатай байгаа, дүрэм журмын өөрчлөлтүүдээ эхнээс нь тавиарай гэдгийг хэлье. Монголбанкны хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны талаарх мэдээлэлтэй танилцаж дууслаа. Дараагийн асуудалдаа оръё.

13.19 цаг

**Хоёр.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.03.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Хэлэлцэх асуудал 2. Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулъя. Хуулийн төслийн талаарх хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга Ням-Осорын Учрал танилцуулна. Сайдын микрофоныг нээе.

**Н.Учрал:** Эдийн засгийн байнгын хорооны дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хувийн хэвшил, бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна гэж, 11 дүгээр зүйлийн нэг дэх хэсэгт Үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн гэж тус тус заасан. Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 11.4 дэх заалтад зааснаар төлбөр, таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд тусгай зөвшөөрлийг хууль зүйн асуудал эрхэлсэн ЗГ-ын гишүүн олгохоор тусгасан хэдий ч эдгээр үйл ажиллагаа болон тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрхлэх үйл ажиллагаатай холбоотой эрх, үүрэг шаардлагыг нарийвчлан зохицуулсан зохицуулалт одоогоор байхгүй байна.

Харин Монгол Улсад казино байгуулах, ажиллуулахыг хориглох тухай 1999 оны нэг зүйлтэй хууль хүчин төгөлдөр үйлчилж байгаа бөгөөд Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар мөрийтэй тоглоом тоглох, зохион байгуулахыг хориглож, хүлээлгэх хариуцлагыг тогтоосон. ҮСХ-ноос хийсэн судалгаагаар 2023 оны байдлаар эдийн засгийн гэмт хэрэг 200 бүртгэгдэж, 2024 онд эдийн засгийн гэмт хэргийн улмаас нийт 417,2 тэрбум төгрөгийн хохирол учирч эдийн засгийн гэмт хэргийн хохирогчийн 9,2 хувийг 18-аас 29 насны бүлэг, 47,7 хувийг 30-аас 39 насны бүлэг, 24,6 хувийг 40-өөс 49 насны бүлэг эзэлж байна.

Монгол Улсын нутаг дэвсгэрт мөрийтэй болон бооцоот тоглоомын үйл ажиллагаа эрхлэх замаар мөнгө угаах, бусдыг залилах, татвар төлөхөөс зайлсхийх зэрэг эдийн засгийн гэмт хэргүүд ихээр үйлдэгдэж, сүүлийн 3 жилийн хугацаанд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20.17 дугаар зүйлд заасан мөрийтэй тоглоом зохион байгуулах зүйл ангиар 669 хэрэгт мөрдөн шалгах үйл ажиллагаа явагдаж, 200 хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай явуулж, 104 хэргийг шүүхээр эцэслэн шийдвэрлэсэн байна. Монгол Улсад давхардсан тоогоор сүүлийн 3 жилийн хугацаанд хууль бус мөрийтэй тоглоомын 350-аас 450 орчим сайт үйл ажиллагаагаа идэвхтэй явуулж байна.

ХЗДХЯ-наас Зөвшөөрлийн тухай хуульд заасан төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Темп партнерс, Эн Зэт Жи Эм, Мон Экс Бэй Ти Билэг компанид олгож, олон улсад бооцоот тоглоомын чиг чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 1XBET сайт нь одоогоор огт тусгай зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа явуулж байна. Цагдаагийн байгууллагаас ирүүлсэн мэдээллээр Монгол Улсын нутаг дэвсгэрт тусгай зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа эрхэлж байгаа спортын бооцоот тоглоомын 1XBET сайтаар дамжуулан гэмт хэргийн замаар олсон хууль бус хөрөнгийг гуйвуулах, нуун далдлах, оффшор эргэлтэд оруулах, мөнгө угаах гол хэрэгсэл болж, залилах, мөрийтэй тоглоом тоглох, кибер гэмт хэрэг, авлига албан тушаалын гэмт хэргийн замаар олсон мөнгийг угааж байгаа нөхцөл байдал тогтоогдсон байна.

Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны явцад Арабын нэгдсэн Эмират, Хонконг зэрэг улсуудад бүртгэлтэй хуулийн этгээдээр дамжуулан Монгол Улсад бүртгэлтэй нэр бүхий ААН-тэй 6 мянгаас 77 мянган доллар хүртэл гэрээ байгуулж, 1XBET сайтаас манай улс руу зар сурталчилгааны зорилгоор 3,3 гаруй тэрбум төгрөг буюу 976 орчим сая доллар шилжиж ирсэн хэдий ч 2024 оны байдлаар манай улсад нэг, манай улсаас 1,7 их наяд төгрөг буюу 500 сая ам.доллар, 2025 оны эхний 2 сарын байдлаар 87 сая ам.доллар гадаад улс руу шилжсэн байна. Энэ мөнгөн шилжүүлгийг 1XBET сайттай гэрээ байгуулан мөнгөн шилжүүлгийн 2-оос 5 хувийг шимтгэлд авч бооцоот болон мөрийтэй тоглоом зохион байгуулахад өөрийн төлбөр тооцооны данс, гар утасны дугаар, цахим хаяг зэргийг ашиглан зуучлалын үйл ажиллагаа явуулдаг 110 гаруй агентаар дамжиж гарсан тоон мэдээ байна.

Хууль бус мөрийтэй болон бооцоот тоглоомын үйл ажиллагаа эрхлэхтэй тэмцэх чиглэлээр цагдаагийн байгууллага, Монголбанк, Харилцаа холбооны зохицуулах хорооноос 6036 домэйн хаягийг Монгол Улсаас хандах хандалтыг хязгаарлаж, Монополын эсрэг газраас Монгол Улсын нутаг дэвсгэрт төлбөрт таавар бооцоот тоглоомын зар сурталчилгааг бүтээж түгээж байгаа этгээдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж нэр бүхий 2 ААН, 7 контент бүтээгчийн зөрчлийн шинжтэй үйлдэлд 13 сая 500 мянган төгрөгийн торгууль ноогдуулж ажилласан.

Гадаад улс орнуудын цахим мөрийтэй болон бооцоот тоглоомыг хүлээн зөвшөөрч байгаа эсэх талаар 2024 оны 9 дүгээр сард гаргасан жагсаалтад манай улстай нийгмийн үнэлэмж, соёл уламжлалын хувьд ижил төсөөтэй Ази Номхон далай бүс нутгийн улс орнуудыг судалж үзэхэд нийт 46 улс орны 21 улс нь цахим мөрийтэй болон бооцоот тоглоомыг хууль бус гэж гэж тооцож, 7 улс хуулиар хүлээн зөвшөөрч, 6 улс хэсэгчилсэн байдлаар зохицуулж, 13 улс одоогоор огт зохицуулалт хийгээгүй байна. Цахим хэлбэрийг хууль бус гэж тооцсон улс орны тоонд Япон, БНСУ, БНХАУ, Тайланд, Вьетнам, Индонез, Мальдив, Непал, Лаос, Бангладеш

зэрэг улс орнуудыг дурдаж болно. Мөн мөрийтэй тоглоомын газар ажиллуулахыг хууль бус гэж тооцсон 18, хүлээн зөвшөөрсөн 15, хэсэгчилсэн 8, зохицуулалтгүй 4, зөвхөн ЗГ нь зохицуулдаг 1 улс байна.

Мөрийтэй болон бооцоот тоглоом тоглосноос эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг тодруулахад олон улсын сэтгэцийн эмгэгийн жагсаалтад F63 0 онош буюу мөрийцөх донг хамааруулж АНУ-ын Addictology-н хүрээлэнгийн судалгаагаар тоглоомын дон буюу мөрийцөх донгийн үед хүний уураг тархинд сэтгэцэд нөлөөлөх бодист донтох эмгэгтэй хүнтэй ижил өөрчлөлт бий болдог болохыг тогтоосон байна. Мөн тоглоомын донтой хүмүүсийн дунд амиа хорлох явдал түгээмэл байдаг ба Австралийн эрдэмтдийн хийсэн судалгаагаар амиа хорлосон хүмүүсийн 17 хувь нь тоглоомын донтой хүн байсан. Тоглоомын донтой 5 хүн тутмын 1 нь амиа хорлох оролдлого хийж байсан нь тогтоогдсон. СЭМҮТ-д хандаж мөрийцөх дон оноштойгоор эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан хүний тоо жил бүр нэмэгдэж байна. 2020 онд 3 хүн амбулаториор үзүүлж, 11 хүн хэвтэн эмчлүүлсэн. 2021 онд 8 хүн амбулаториор үзүүлж, 10 хүн хэвтэн эмчлүүлсэн. 2022 онд 75 хүн амбулаториор үзүүлж, 37 хүн хэвтэн эмчлүүлсэн. Харин 2023 онд онд 101 хүн амбулаториор үзүүлж, 45 хүн хэвтэн эмчлүүлсэн.

Иймд манай улсын нийгэм, эдийн засаг, иргэдийн эрүүл мэндэд ихээхэн хэмжээний хохирол учруулж, эдийн засгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж байгаа үйлдлийг таслан зохих зорилгоор Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д заасны дагуу боловсруулж, хуулийн төсөлд төлбөрт таавар, бооцоот тоглоом, цахим мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа эрхлэхийг бүхэлд нь хориглож, төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагаанаас хасахаар тусгаж байна. Мөн хуулийг дагалдуулан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Зар сурталчилгааны хууль, Банкны хуулиудад тус тус өөрчлөлт оруулахаар Их Хуралд өргөн мэдүүлж, та бүхэнд танилцуулж байна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэхийг шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

**Р.Сэддорж:** Учрал сайдад баярлалаа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Монгол Улсын сайд ЗГХЭГ-ын дарга Учрал, Монголбанкны Дэд ерөнхийлөгч Энхтайван, ЗГХЭГ-ын дэд дарга Батцэцэг, ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын дарга Жамъянхүү, ЦЕГ-ын Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газрын дарга Тайван, ЦЕГ-ын Хуулийн хэлтсийн дарга Батзориг, Монополын эсрэг газрын дарга Билгүүн, Харилцаа холбооны зохицуулах хорооны Ажлын албаны дарга Лувсан-Очир, ХХЗХ-ны Зохицуулалтын газрын дарга Батболд, Дотоод хэргийн их сургуулийн элсэлтийн ерөнхий энэ юу гэсэн үг юм бэ? Доктор, дэд профессор, цагдаагийн хурандаа Гантулга, ЗГХЭГ-ын Хууль, эрх зүйн газрын ЗГ-ын ахлах референт Сүрэнхорол, ЗГХЭГ-ын Салбарын бодлого, зохицуулалтын газрын референт Золбоо. Хуулийн төслийн талаар хууль санаачлагчаас асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Жаргалан гишүүнээр тасалъя. Соронзонболд гишүүн асуулт асууна.

**Л.Соронзонболд:** Ерөнхийдөө энэ хуулийн төслийг дэмжиж байна. Яг энэ асуудлаар хөдөө орон нутагт залуучууд ажил эрхэлж байгаа залуучууд, малчид хүртэл маш ихээр тоглож хохирч байгаа асуудал гомдол яригддаг. Дээр нь энэ харин тусгагдаагүй асуудал байгаа юм шиг санагдаад байх юм. Энэ телевизээр ингээд маш их сугалаа явж байгаа. Бас л нэг донтуулах хэлбэр. Ингээд сугалаанд маш олноор хохироод, сугалаанд оролцоод маш их зээл аваад, өрөнд орчихсон хүмүүс байж байгаа. Тэгэнгүүт энэ сугалаатай холбоотой асуудал дээр ямар нэгэн судалгаа хийгдсэн үү? Энэ тал дээр мэдээлэл өгөөч 1 дүгээрт.

2 дугаарт Банкны тухай хууль дээр оруулж байгаа өөрчлөлт дээр энэ юу яасан байна л даа. Энэ залилах гэмт хэрэгт хуульд заасны дагуу мөрдөн шалгах байгууллагаас шаардсан бол мэдээллийг гаргаж өгөх тухай дурдсан байна. Гэтэл ер нь яах вэ банкнууд сэжигтэй гүйлгээний дүрэм гээд гүйлгээ болгон дээр тодорхой хэмжээнд ингээд тухайн хүний олж байгаа орлого, орж дамжиж байгаа гүйлгээ дээр ингээд дүрмээр ажиллаж байгаа. Тэрийгээ санхүүгийн мэдээллийн албанд хүргэдэг. Тэгээд явж байхад би зүгээр яг юу хэлэх гээд байна вэ гэхээр энэ ингээд тодорхой мэдээллүүдийг ингээд шалгаж байгаа. Энэ чинь онлайнаар явж байгаа учраас маш хурдтай явж байгаа шүү дээ. Тэгэнгүүт дандаа араас нь ажилладаг байхгүй юу. Тэгэхээр яаж урьдчилан сэргийлэх юм бэ? Ийм үйлдэл хийгээд олон дахин удаа хийгээд байгаа хүнд банк үйлчлэхгүй байж болно гэх мэтчилэнгээр тэр боломжуудыг нь олгох тал дээр бодож байгаа зүйлс байгаа вэ гэж асуумаар байна.

**Р.Сэддорж:** Хариулт 3 номер Учрал сайд.

**Н.Учрал:** Зөвшөөрлийн тухай хууль дээр төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хууль зүйн асуудал эрхэлсэн ЗГ-ын гишүүн олгодог. Эд мөнгөний хонжворт сугалаа эрхлэх үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрлийг Сангийн сайд олгодог. Энэ хуулийг боловсруулахдаа бид Эрүүгийн хууль дээр санкцыг нэмэгдүүлэх ийм бодлого барьсан. Эрүүгийн хууль дээр ер нь ямар тохиолдолд санкц нэмэгдүүлдэг вэ гэхээр нийгэм, эдийн засгийн хор аюулын хэмжээг л үнэлж байгаа. Тэгээд нийгэм, эдийн засгийн хор аюулын хэмжээ нь, хохирлын хэмжээ нь өнөөдөр төлбөрт таавар бооцоот тоглоомын үйл ажиллагаа эрхлэх дээр үнэхээр их өндөр болсон. Нэг ёсондоо нэг талаасаа гадагшаа валют урсгаж байгаа. Нөгөө талаасаа эдийн засгийн хохирлын хэмжээ 417 тэрбум төгрөгт хүрсэн. Гадагшаа урсаж байгаа валютын урсгал 500 сая долларт 1 жилд хүрсэн. Бид энэ хуулийг өргөн барих гээд нөгөө Хууль тогтоомжийн хуулийн дагуу боловсруулах ажил эхлэх цаг үеэс хойш Их Хурал дээр бид өнөөдөр яг хэлэлцэж эхлэх цаг үед 50 сая доллар гадагшаа урсчхаад байна. Нэг ёсондоо 1, 2 дугаар сард 87 сая ам.доллар зөвхөн энэ цахим мөрийтэй тоглоом, бооцоот тоглоомоор гадагшаа явчихсан.

Нөгөө эд мөнгөний хонжворт сугалаа гадагшаа урсгаад байгаа зүйл байхгүй. Нөгөө дотооддоо л энэ хонжворт сугалаанууд явагдаад байдаг юм байна гэдэг утгаар нь Зөвшөөрлийн хуулийг өргөн барихдаа нийгэм, эдийн засгийн хор хохирлын хэмжээг нь харж байгаад эхний түвшинд төлбөрт таавар, бооцоот тоглоом, цахим мөрийтэй тоглоомыг хориглох ийм шийдвэр гаргая гэж шийдсэн. Гэхдээ Их Хурал дээр ажлын хэсэг байгуулаад энэ хонжворт сугалааг хориглоё гэдэг шийдлийг Их Хурлын гишүүд хэрвээ гаргавал ЗГ энэ дээр татгалзах зүйл байхгүй. Бүхэлд нь хориглоё гэвэл Зөвшөөрлийн хуулиас хонжворт сугалааг ч гэсэн аваад бүхэлд нь хориглоод явчхаж болохгүй зүйл байхгүй. Энийг мэдээж Их Хурлын

бүрэн эрхийн асуудал. Их Хурлын ажлын хэсэг шийдвэрээ гаргаад явах байх гэж бодож байна.

ЗГ бол гүйцэтгэх засаглал мэдээж бид ажил явуулахад шаардлагатай эрх зүйн орчин хэрэгтэй байна гэдэг утгаараа энэ хуулийг боловсруулсан. 99 оны Казиногийн хууль батлагдсаны дараа Эрүүгийн хуулийн 22.17 дээр, 20.17 дээр нөгөө санкцыг нь тавьсан байдаг мөрийтэй тоглоомыг. Тухайн үед цаг үе их өөр байсан. 99 оны үед энэ сошиал медиа гэж байсангүй. Энэ бол янз бүрийн аппликэйшн байсангүй. Тухайн үед мөрийтэй тоглоом болон олон нийтийн газар мөрийтэй тоглоом зохион байгуулах болон мэдээллийн технологи ашиглан мөрийтэй тоглоомын хэлбэрийн үйл ажиллагаа зохион байгуулахыг Эрүүгийн хууль дээр нөгөө санкцыг нь тавьж өгсөн байсан. Одоо бол цаг үе их өөрчлөгдсөн. Тийм учраас бид цахим мөрийтэй тоглоом буюу ашиг олох зорилгоор цахим мөрийтэй тоглоомын үйл ажиллагааг цахим сүлжээ ашиглаж зохион байгуулах үйл ажиллагаа эрхлэх гэдэг нэг үйлдлийг, дээрээс нь дэмжлэг үзүүлэх гэдэг нэг үйлдлийг, дээрээс нь энэ 1ХВЕТ-н ард байгаа 110 агент буюу зуучлалын үйл ажиллагаа эрхлэх гэдэг нэг үйлдлийг, дээрээс нь үүнийг олон нийтэд сурталчлаад байгаа бүх төрлийн сурталчилгааны хэрэгслийг ашиглаад байгаа үйлдлийг бүхэлд нь хуулиар хориглох арга хэмжээг авбал үүн дээр Харилцаа холбооны зохицуулах хороо ч тэр, Монголбанк ч тэр, хууль хяналтын байгууллага ч тэр хамтарч ажиллаад энэ үйл ажиллагаатай тэмцвэл бид 65 хувиар үүнийг эхний түвшинд бууруулна гэдэг ийм судалгааг гаргасан. Тэгээд үүний төлөө ажиллаж байгаа. Тэгээд хэрвээ Их Хурлын гишүүд ажлын хэсэг дээрээ хонжворт сугалааг хориглоё гэдэг шийдвэрийг гаргавал ЗГ-ын зүгээс дэмжихэд бэлэн гэдгээ илэрхийлье.

**Р.Сэддорж:** 2 дугаар асуултад 4 номер, 4 номер.

**Г.Энхтайван:** Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар дагахаар орж ирж байгаа. Энэ дээр одоо хүчин төгөлдөр мөрдөж байгаа Банкны тухай хуулийн 7.2 дээр банк, түүний харилцагч, гуравдагч этгээдийн нууц гэж үзсэн аливаа мэдээллийг доор дурдсанаас бусад тохиолдолд бусдад гаргаж өгөхийг хориглодог байгаад байгаа. Тэгээд энэхүү хуулийн 7.2.12 дээр орж ирснээр энэ мөрдөх, мөрдөн шалгах байгууллагаас шаардсан тохиолдолд энэхүү банкны буюу харилцагчийн мэдээллийг шууд гаргаж өгөхөөр зохицуулалтууд орж ирж байгаа. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа энэ хууль нь зөвхөн прокурорын зөвшөөрлөөр мөрдөх байгууллага мэдээллийг авдаг байсан бол яаралтай горимоор, тухайн энэ төлбөрт таавар, бооцоот тоглоом, цахим мөрийтэй тоглоомын үйл ажиллагааг, үйл ажиллагаа энэний онцлогоос нь хамаараад цаг алдахгүйн үүднээс мөрдөх байгууллага хурдан хугацаанд тухайн дансыг царцаах, дансыг битүүмжлэх арга хэмжээ авах ийм боломжтой болж байгаа. Гишүүн түрүүн дурдлаа.../минут дуусав/

**Р.Сэддорж:** 4 номер 1 минут.

**Г.Энхтайван:** Тухайн хэрэглэгчийг таньж мэдэх асуудал хамгийн чухал. Арилжааны банкны зүгээс харилцагчийг таньж мэдэх өөрийн гэсэн үүрэг функцтэй байдаг. Бид бүхэн энийг key... гэж нэрлэдэг. Хэрэглэгчийг таньж мэдсэнээр тухайн хэрэглэгч эрсдэлтэй болон энэхүү цахим мөрийтэй тоглоомтой холбоотой үйл ажиллагаа эрхэлж байгаа гэсэн тийм сэжиг арилжааны банкны зүгээс гарсан бол тухайн банк энэ дээр тухайн харилцагчдад үйлчилгээ үзүүлэхгүй байх, тухайн харилцагчийн үйл ажиллагааг өөрсдөө хориглох тийм бүрэн эрхтэй байгаа.



**Р.Сэддорж:** 1 номер.

**Т.Сүхболд:** Соронзонболд гишүүний 2 дугаар асуулт дээр нэмэлтээр тодруулга мэдээлэл өгье. Үндсэндээ Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 7.2.12 гээд яг тухайн энэ өргөн барьж байгаа хуультай холбоотой Зөвшөөрлийн хуультай холбоотой, дагах хуультай холбоотойгоор төлбөрт таавар, бооцоот тоглоом, цахим мөрийтэй тоглоомын үйл ажиллагаатай холбоотой гэмт хэргийн шинжтэй сэжигтэй цахим гүйлгээ ирсэн тохиолдолд хоногт дунджаар ийм тохиолдлын гомдол, мэдээлэл, дуудлага, мэдээлэл ирсэн тохиолдолд яг сая түрүүн манай Энхтайван дарга хэллээ, прокурорын зөвшөөрөл асуудаг. Гэтэл энэ цаг минутыг нь амжаад данснаас дансны орлого шилжээд, шилжээд алга болчихдог учраас яг энэ төрлийн хэрэг дээр мөрдөн шалгах байгууллагаас тухайн нөхцөл байдалд шуурхай ажиллагааны хүрээнд асуудалд хандсан тохиолдолд Монголбанк болон арилжааны банк, хууль хяналтын байгууллага.../минут дуусав/

**Р.Сэддорж:** Болчихсон уу? Одсүрэнгийн Номинчимэг гишүүн.

**О.Номинчимэг:** Хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцсан. Ер нь өмнө нь энэ асуудлыг хөндөөд ХЗДХЯ-наас асуулга тавиад, хариулт авч байхад их өөр үзэл баримтлалтай хариулт өгсөн боловч 3 сайд нь гарын үсэг зураад орж ирж байгаа хуулийн төслийг ЗГ-ын үндсэн гол байр суурь гэж ойлгож байгаа. Тэгэхээр энэ хуулиараа ерөнхийдөө энэ цахим бооцоот тоглоом мөрийтэй тоглоомыг бүрэн хориглоё гэсэн ийм шийдэлтэй орж ирж байгаа гэж харж байгаа. Тэгээд ер нь бид нийгэмд яг юу болж байгаа гэдгээ харвал энэ нөгөө урьдчилан сэргийлэх арга хэмжээг аваагүй, соён гэгээрүүлэх ажил хийгдээгүй байхад ийм донтолын шинж чанарыг өгдөг ийм асуудлуудаа задгай тавих ямар аюултай вэ гэдгийг харж байгаа. Тэгээд энэ зөвхөн цахим бооцоот энэ тоглоом гэдгээс гадна бид зохицуулалтгүй явж ирсэн электрон тамхи юу байна, тамхи юу байна гээд харахаар яг л энэ асуудлууд байгаад байгаа юм. Хэрвээ зохицуулаад үнэхээр шийдэх гэж байгаа бол энэнээсээ өмнө иргэдийнхээ санхүүгийн боловсролыг, соён гэгээрүүлэх ажлыг, дээр нь энэ донтолтоос урьдчилан сэргийлэх энэ ажил хэргүүдээ авч байж энийгээ хийхгүй бол болохгүй гэсэн юман дээр санал нэг байгаа. Яах вэ гол нь бид энэ шийдэл бол бүгдийг нь хориглоё гээд орж ирж байгаа юм байна. Энэ бол хамгийн амархан шийдэл. Амархан шийдэл гэхдээ хэрэгжилт нь яах вэ гэдэг асуудал, хэрэгжихгүй бол энэ хамгийн залхуу шийдэл болно. Тэгэхээр би яах вэ энэ хориглоод хэрэгжилтийг нь яах вэ гэдэг дээр манай ажлын хэсгийнхэн ЗГ-ын түвшинд хэр ярилцсан болоо гэдгийг асуумаар байгаа юм.

Ер нь олон улсад бүгдийг нь хорьчихвол, хорьчихсон улсууд байгаа Солонгос, Хятадаас авхуулаад. Энэ дээр гардаг хамгийн том эрсдэл бол 2 эрсдэл байгаа. 1 дүгээрт далд хэлбэр лүү шилжих, хар зах зээл рүү шилжихдээ улам бид энийгээ илрүүлэхэд хэцүү болдог асуудал байна. 2 дугаарт энэ хууль тогтоомжоо хэрэгжүүлэх хэрэгжилтийг нь хангах дээр маш хэцүү болдог гэсэн ийм асуудал байгаад байгаа. Тэгэхээр энэ дээр манай ЗГ хэрвээ энэ хууль батлагдвал хэрэгжилтийг нь хэрхэн хангаж ажиллах юм бэ? Хэн хариуцах юм бэ? Дахиад салбар дундын хоорондын энэ минийх, энэ чинийх гээд хаячих вий дээ. Харилцаа холбооны зохицуулах хороо энэ дээр ямар үүрэгтэй орох юм бэ? Хэрэгжилтийн асуудал дээр харвал сая энэ Соронзонболд гишүүний асуултад хариулт өгч байна л даа. Сугалааны асуудал. Тэгээд сугалааны асуудал зөвшөөрөлтэй Сангийн сайд

өгдөг гэж байна. Гэхдээ яг үнэндээ одоо нийгэм дээр ямар ч зөвшөөрөлгүй сугалааны асуудал фэйсбүүкээр дүүрэн явж байгаа шүү дээ. Дурын нэг influencer нь гарч ирээд машин өгнө нэг хүний 50 мянга гээд 500 хүнээс мөнгө аваад л тэр машинаа хэдээр ч юм яачихдаг ийм сугалааны асуудал. Энэ яг зохицуулалттай манай улсад хууль дүрэм нь яг хэрэгжиж байгаа юм уу? Тусгай зөвшөөрөл авахгүйгээр л ийм ажлыг цахим орчинд сошиал орчинд хийгээд байгаа шүү дээ. Энэ дээр тэгвэл яаж хэрэгжүүлэх механизм байгаа юм уу? Энийгээ хийж чадахгүй бол бид энэ цахим орчин дахь бооцоот энэ аппликэйшны хурдан хөгжиж байгаа ийм юмнуудыг бид хэр хааж боож энийгээ хэрэгжүүлж чадах вэ гэдэг дээр та бүхэн нэг.../минут дуусав/

**Р.Сэддорж:** 1 минут Номинчимэг гишүүн.

**О.Номинчимэг:** Хэрэгжилтийн асуудал. 2 дугаар асуудал бол сая Соронзонболд гишүүн хөндлөө. Энэ банкны гүйлгээтэй холбоотой асуудал байна. Энэ асуудлыг ингээд хөндөж тавихын өмнө нэлээн олон залуучуудтай уулзсан, асуусан, судалсан. Үнэхээр их олон сая доллар Монголбанкны юугаар гараад крипто валютад 577 сая доллар энэ жил 2024 онд гарсан байгаа. Гэхдээ бүгдээрээ энэ бооцоот уу, үгүй юү гэдэг бол Монголбанк ялгах боломжгүй гэж надад хариу өгсөн. Энэ мөнгөн гүйлгээнүүд яг юугаар хийгдэж байна гэдэг дээр та хэд дүн шинжилгээ хийв үү? Надад ирсэн энэ мэдээллээр коммуникацын асуудлыг ready гэдэг аппликэйшн, энэ мөнгөн гүйлгээний хэтэвч эд нараа ингээд нөгөө агентууд эд нар charge-лах юм болохоор энэ mobi cash пос гэнэ үү ийм аппликэйшнуудаар дамжаад байна. Яг банкны данснуудаар хэр яаж гүйж байгаа гэдэг нь тодорхойлоход хэцүү байна гэдэг юм хэлж байгаа. Тэгэхээр Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо ер нь энэ асуудал дээрээ мөнгөн.../минут дуусав/

**Р.Сэддорж:** Хариулт 3 номер Учрал сайд.

**Н.Учрал:** Номинчимэг гишүүн энэ цахим мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа дээр онцгой анхаарал тавьж, манлайлж ажиллаж байсанд талархаж байгаа. Тэгээд үнэхээр хариу арга хэмжээ авахгүй байсаар байгаад сар болгон энэ их хэмжээний валют гадагшаа урсгаад байна гэдэг бол энэ нэг хэдэн тоглож байгаа хүний асуудал биш юм байна лээ. Зарим хүмүүс хэлж байгаа л даа. Энэ өөрийнхөө буруугаас болоод өөрөө очиж тоглоод, өөрөө мөнгөө алдаад байна шүү дээ гээд. Гэтэл ЗГ өнөөдөр валютын нөөцөө нэмэгдүүлэх гэж онцгой хичээж ажиллаж байгаа. Гэтэл нэг гараараа хичээгээд байдаг, нөгөө гараар нь ингээд урсаад байдаг. Тэгээд доллар шатаагаад байдаг. 1,7 их наяд 500 сая доллар жилд гаргаад явуулчихна гэхээр яг энэ үнэндээ бүх ард түмний асуудал, бүх иргэдийн асуудал болчихоод байна л даа. Жишээ нь энэ чинь инфляцад нөлөөлж л байгаа, бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлтөд нөлөөлж л байгаа. Энэ чинь 500 сая доллар гарчихна гэдэг бол. Тэгээд энэ 500 сая доллар гарчихсан жилийн энэ урсгал юу вэ гэхээр яг нөгөө арилжааны банкнуудаар дамжаад гарчихсан Монголбанкин дээр тооцогдож бүртгэгдээд байгаа тооцоо болохоос биш криптогоос крипто руу шилжсэн мөнгийг бид тоолж чадахгүй шүү дээ. Энийг дэлхийн санхүүгийн зах зээл хянаж чадахгүй байна шүү дээ.

Тэгэхээр нөгөө койноор шууд хоорондоо шилжүүлж байгааг бол бид хянаж чадаагүй. Койн нь банкаар дамжаад гарч байгаа бодитой валютыг л энэ 500 сая доллар гэж Монголбанк гаргачхаад байгаа байхгүй юу. Тэр койн, койн хоорондоо буюу криптогоос крипто руу яаж шилжсэнийг бид мэдэхгүй. Үүнийг хөхиүлэн

дэмжээд байгаа нөхөд хэн юм бэ гэхээр агентууд. Тэр 1ХВЕТ-н ард зуучлалын үйл ажиллагаа явуулдаг 110 агент гээд нөхөд 2-оос 5 хувийн дундаасаа шимтгэл аваад, банкныхаа дансыг ашиглуулаад, цахим хаягаа ашиглуулаад, гар утасны нөгөө нэг харилцаа холбооны сүлжээний дугаар ашиглуулаад энийг зуучилдаг. Тэгэхээр зуучлалын үйл ажиллагаа өнөөдөр хуулиар хориотой биш. Тэр зуучлалын үйл ажиллагаа дээр хориг тавих уу ёстой юу ёстой. Сурталчилгааг нь хорих ёстой юу ёстой. Зохион байгуулах буюу нэг удаагийн үйлдлээр зохион байгуулагдаад байвал хориглох ёстой юу ёстой. Дээрээс нь дансаа ашиглуулж байвал, харилцаа холбооны сүлжээний дугаар ашиглуулж байвал бүхэлд нь хорих ёстой.

Тэгээд үйлдэл болгоныг нь хориглосон цагт Монголбанк ч тэр, цагдаагийн байгууллага ч тэр, ХХЗХ ч тэр хамтарч ажиллах бололцоо бүрдвэл багадаа 65 хувь бууруулна гэж байгаа юм. Энэ бол эдийн засгийн асуудал, нөгөө талаасаа энэ хүн амын эрүүл мэндийн асуудал. Өнөөдөр энэ СЭМҮТ-ийн энэ тоогоор чинь энэ 2023 онд 101 иргэн амбулаториор үзүүлээд, 45 иргэн хэвтэн эмчлүүлж байна гэдэг бол энэ ноцтой тоо байхгүй юу. Тэгвэл бид далд эдийн засаг бий болно гэж магадгүй хамгаалж тайлбарлаж болно. Гэтэл өнөөдөр тусгай зөвшөөрөл олгоод 3 байгууллага өнөөдөр ААН-д олгочихсон байхад Онцгой албан татварын хуулиар 36 сая, энэ чинь 36 сая сар тутам онцгой албан татвар ноогдуулахаар зохицуулалттай. Гэтэл энэ 3 ААН өнөөдөр татвар төлөөгүй байна шүү дээ. 3 тэрбум төгрөг улсын төсөвт төлөх ёстой байсан энэ 3 байгууллага төлөөгүй. Тэгээд энэ сэдвийг аваад энэ хуулийг оруулъя гээд ингээд явахаар энэ чинь их том сэдэв юм байна. Янз бүрийн хүмүүс ярьдаг, үлдээчхээч, энийг хориглох ёсгүй. Энэ бол эдийн засгийн эрх чөлөө гээд. Энэ чинь ингээд зүгээр харж суугаад гүйцэтгэх засаглал ингээд хараад сууна гэдэг бол энэ байж боломгүй үйлдэл. Тийм учраас энэ сэдэв нэг их тийм яригддаггүй. Үүний цаана асар олон агентууд, асар олон компани, ААН-үүд, үүний цаана олон хүмүүс байгаа. Би Монголбанкны энэ мэдээлэл дотор та бидний мэдэх маш олон хүн байна. Тэгэхдээ энийг ярих цагтаа ярья. Тэгээд шаардлагатай бол чуулган дээр хэлье. Энэ аягүй олон таньдаг бидний хүн байгаа шүү. Энэ нэр ус Монголбанкны энэ дээр.../минут дуусав/

**Р.Сэддорж:** Нэмж хариулъя хэрэгжилтийг нь 4 номер.

**Г.Энхтайван:** Номинчимэг гишүүний асуултад нэмэлт тодруулъя. 2021-ээс 24 оны банкнуудын гадаад гүйлгээний тайлан мэдээллээс Монгол Улсын эдийн засгийн харьяат болон харьяат улсын хооронд хийгдсэн крипто валютын гүйлгээ гарсан байгаад байгаа. Энэ дээр 2024 онд 578 сая доллар. Энийг ингээд арилжааны банкнуудаар нь хуваавал Төрийн банк 51 хувийг нь, Тээвэр хөгжлийн банк 20 хувийг нь, Голомт банк 16 хувийг нь гэх мэтчилэн явж байгаа. Тэгээд яг энэ нөгөө арилжааны банкнуудын эзэлж байгаа хувийг нь ингээд харахаар энэ харилцан адилгүй жил болгон өөрчлөгдөөд байгаа. Жишээлбэл 2021 онд Төрийн банк 1 ч ийм гүйлгээ хийж байгаагүй байсан бол 24 онд 268 сая долларын гүйлгээ хийчихсэн байгаад байгаа. Худалдаа хөгжлийн банк жишээлбэл 24 онд 1 ч гүйлгээ хийгээгүй, өмнө нь 2021 онд гэхэд 77 сая долларын гүйлгээ хийж хийсэн гэх мэтчилэн. Тэгэхээр энэ л юуг илэрхийлж байгаа вэ гэхээр тухайн агент гэж нэрлэгдээд байгаа хүмүүс нь тухайн аль нэгэн арилжааны банкиг сонгож яг гүйлгээ нь хийгдэж байгаад яг тухайн үедээ.../минут дуусав/

**Р.Сэддорж:** 4 номер 1 минут.

**Г.Энхтайван:** Тухайн банк нь энэ тухайн иргэн болон ААН-ийн данс дээр шалгалт оруулаад эсвэл Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албанаас сэжигтэй мөнгөн гүйлгээний хувьд ингээд данснууд дээр шалгалт хийгээд явангуут банкаа солиод, дансаа солиод өөр банк руу шилжээд явчихдаг. Тэгээд яг энэ бол нийтдээ түрүүн Учрал сайд хэллээ. Хэдий хэмжээний агентууд байгаа гэдгийг ингээд харахаар тэгээд ер нь ингээд шилжиж байгаа улсуудыг нь харахаар харьцангуй өөр, өөр байгаад байгаа. Сүүлийн 3 жилийн хугацаанд нийтдээ 1,3 тэрбум долларын гүйлгээ хийгээд, үүний 764 саяыг нь зөвхөн pay ward limited гэдэг компани руу шилжсэн байгаад байгаа. Энэ нь крипто валютын хэлбэрээр гүйлгээг хүлээн авдаг байгаа жишээлбэл. Тэгээд мөн progress digital, trust limited, promo pay гэх мэтчилэн АНУ болон бусад бид бүхний ярьдаг оффшор гэдэг улсуудад бүртгэлтэй компаниуд байгаад байгаа. Мөн энэ улсуудыг нь ингээд харьцангуй ингээд улсаар нь аваад үзэхэд.../минут дуусав/

**Р.Сэддорж:** 4 номер гүйцээж хариулъя.

**Т.Батболд:** Сайн байна уу. Харилцаа холбооны зохицуулах хороо Т.Батболд. Эрхэм гишүүн Номинчимэг гишүүний асуултад хариулъя. ХХЗХ нь тухайн агуулга дээр холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэр дүгнэлтийн дагуу технологийн арга хэмжээ, үүрэн холбооны болон интернэтийн үйлчилгээ эрхлэгчидтэй арга хэмжээ авч хамтран хэрэгжүүлдэг. Цахим мөрийтэй тоглоом өнгөрсөн хугацаанд 3 цахим орчинд 3 хэлбэрээр явж байгаа. 1 дүгээрт сошиал медиа ашиглаад янз бүрийн пэйж болон группүүд үүсэх хэлбэрээр явна, 2 дугаарт веб сайт буюу домэйн нэрээр gambling сайтууд ажилладаг, 3 дугаарт аппликэйшн ашиглаж ийм 3 арга хэмжээ байгаа. Хэрэгжүүлэлт дээр сошиал орчинд бид хэд өнгөрсөн хугацаанд жишээлбэл Фэйсбүүк компанитай хамтраад.../үг тасрав/

**Р.Сэддорж:** 1 минут нэмээрэй.

**Т.Батболд:** Нийт 3192 хууль бус контент ирүүлсэн линкийг устгуулах хүсэлт бид хүргүүлснээс 84 хувийн устгалтай буюу 2671 нь пэйж групп холбогдох хууль бус контентыг устгасан байна. Веб сайтын хувьд бид хэд 6030 домэйн нэрийг хязгаарлалтад оруулсан. Эндээс 40 орчим нь 1XBET-тэй холбоотой домэйн нэрс байгаа.

3 дугаар асуудал аппликэйшн байгаа. Аппликэйшн дотроо 3 үйлдэл байгаа. 1 дүгээрт аппликэйшныг татаж авах, 2 дугаарт бүртгүүлэх, цэнэглэхэд танин баталгаажуулалт хийгддэг, 3 дугаарт ашиглах тухайн аппликэйшн гэж байгаа юм. Тэгэхээр бид хэд өнгөрсөн хугацаанд Нийслэлийн прокурорын албан ёсны зөвшөөрлөөр 1XBET аппликэйшныг татах нийт 11 домэйннийг black list-д оруулж хязгаарласан. Мөн AS-н Appstore-той холбоо тогтоогоод Евро-Ази, Турк, Африк хариуцсан төрийн бодлого болон бодлого хариуцсан газартай нь.../минут дуусав/

**Р.Сэддорж:** 3 номер хариулъя.

**Н.Учрал:** Энэ ХХЗХ-г 1XBET гэдэг шиг яагаад ийм цахим мөрийтэй тоглоомын казиногийн үйл ажиллагаа явуулж байгаа аппликэйшнүүдийг ингээд татуулаад байгаа юм бэ гэхээр энэ чинь хуулиар хориглогдоогүй шүү дээ гэдэг. Тэр app store ч бай, play store ч бай, тэгээд google store ч бай бүгд рүү нь хариу өгөхөөр Монгол Улсын дотоодын хууль тогтоомжийг дагаж мөрдөнө гэдэг. Хэрвээ бид энэ хуулийг гаргачихвал манай location дээр play store, app store-оос 1XBET шиг

аппликэйшнүүд татагдахгүй болно. Бид албан хүсэлтээ тавина гэсэн үг шүү дээ Зохицуулах хороо. Манайх хуулиар хориглогдчихсон юм гэхээр манай дотоодын хууль тогтоомжийг хүндэтгэнэ. Магадгүй тэр VPN ашигладаг, өөр орны банкны карт ашигладаг үйлдлүүд мэдээж далд хэлбэртэйгээр явагдах байх. Гэхдээ энэ хуулиар хориглогдчихсон үйлдэл байхгүй юу. Тэгээд үнэхээр энэ дээр хууль хяналтын байгууллага ажиллавал хуулийн хариуцлага хүлээнэ. Зүгээр яг шууд татагдах ийм хэлбэрүүд хуулиар хориглогдчихвол хүсэлтүүд тавьсны дараа арга хэмжээ авагдана л гэж ойлго.../минут дуусав/

**Р.Сэддорж:** 1 номер нэг.

**Т.Сүхболд:** Сая үндсэндээ ажлын хэсгийн ахлагч тодорхой хэлчихлээ. Нэмээд тодруулаад хэлэхэд үндсэндээ энэ хориглолтыг хийснээр хэрэгжилтийг хэн хариуцах вэ гээд гишүүний эхний асуултын хүрээнд нэмж хариулахад байгууллага хоорондын хамтын ажиллагаа илүү тодорхой болно. Бид хариуцах чиг үүрэг, хүлээх үүрэг, шуурхай байдал, мөн хуульд заасан үндэслэлээр хязгаарлалт хийх, хүний хохирсон хохирлыг шуурхай барагдуулах, гэмт хэргийн шинжтэй хөрөнгө орлого мөнгийг шуурхай царцаах боломжууд илүү нээгдэж өгөх юм байгаа юм.

Урьдчилан сэргийлэхтэй холбоотой асуулга яригдсан. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль байгаа. ХЗДХЯ-ны дэргэд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл байгаа. Энэ хүрээнд байгууллага хоорондын хариуцсан чиг үүргийн хүрээнд энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, зар сурталчилгаа бусад байдлаар.../минут дуусав/

**Р.Сэддорж:** Номинчимэг гишүүн хариулт дээр 1 минут дахиж өгье.

**О.Номинчимэг:** Бид хэрвээ энэ хуулийг хэрвээ гаргах бол хэрэгжилтээр нь маш нарийн процессыг нь байгууллагууд яаж уялдаа холбоотой ажиллаж, түргэн шуурхай арга хэмжээ авах вэ гэдэг дээр онцгойлон анхаарах ёстой гэж бодож байгаа. Тэгээд түрүүн хэлсэн шүү дээ энэ фэйсбүүкээр ийм зүгээр хувь иргэд influencer-ууд хонжворт сугалаа угаасаа зохион байгуулаад бүүр гаарчихсан. Тэгтэл хонжворт сугалаа чинь өөрөө тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа. Энэ дээр фэйсбүүк дээр явагдаж байгаа юман дээр жишээ нь ХХЗХ яаж орох нь мэдэгдэхгүй, цагдаа энэ дээр яаж орж байгаа юм эсвэл түүн дээрээ ерөөсөө хаячихсан юм уу гээд ингээд нэг эзэнгүй дунд нь, дараа нь нэг хэдэн удаа сайтууд хаагаад дуусаад, дараа нь нөгөө VPN байдаг юм уу, бүх юмаараа ороод боломж нь нээгдээд хар зах зээл рүү орчих вий дээ л гэсэн ийм л болгоомжлол байгаа юм. Бид хэчнээн гоё хууль гаргахаа ярьж болно. Гол нь нөгөө хэрэгжилтийн үр дүнгээ ямар байх юм гэдгийг бодитоор тооцоолоод, тэрнийхээ л процессжуулах ажил дээрээ анхаарах ёстой гэж харж байгаа болохоор энэ дээр хэрэгжилтийг хангах байгууллагуудын уялдаа холбоо.../минут дуусав/

**Р.Сэддорж:** 3 номер Учрал сайд.

**Н.Учрал:** Салбарын хуулиуд дээр чиг үүргүүд байгаа. Харилцаа холбооны хууль дээр ч байгаа, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хууль дээр ч байгаа. Монополын эсрэг газрын чиг үүрэг ч гэсэн хууль дээрээ байгаа. Гэхдээ энд нөгөө хуулийн хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ нь тодорхойгүй байгаа учраас зохих арга хэмжээ авахад их бэрхшээлтэй. ЗГ холбогдох байгууллагуудаа дуудаад арга

хэмжээ аваач гэхээр үгүй ээ энэ чинь хуулиараа ингээд нээлттэй үйл ажиллагаа болгон дээр нь хариуцлага байхгүй. Бид тэр олон улсын байгууллагуудтай яаж харилцах юм бэ гэдэг ийм тайлбарыг тавиад байдаг. Тэгээд Номинчимэг гишүүн энэ асуудлыг гишүүн болсноосоо хойш ярьсан. Тэгээд ер нь энэ хүмүүс их анхаарахгүй, нэг их төдийлөн тоохгүй байсан нь аргагүй юм байна лээ. Энэ чинь аягүй олон хүний эрх ашиг байгаа юм байна. Тийм учраас ингээд энэ удаа ЗГ салбар дундын асуудал учраас Хэрэг эрхлэх дээрээ зохион байгуулаад ингээд орж ирж байгаа учраас Их Хурал, ЗГ-ын хамтын ажиллагаа доор хэрэгжилт дээр нь хамтдаа ажиллацгаая л гэдгийг хэлье.

**Р.Сэддорж:** Батшугар гишүүнийг хасъя, хариултаа авчихсан гэж өөрөө хэллээ. Гончигдоржийн Уянгахишиг гишүүн.

**Г.Уянгахишиг:** Зөвшөөрлийн тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт болон дагалдах хуулиудыг харахаар яг нөгөө нэг хууль зүйн техник талаасаа болон яг боловсруулалт талаасаа нэлээн дутуу харагдаад байна. Түүнтэй холбоотойгоор ямар ч байсан асуултуудаа асуугаадахъя. Тэгэхээр 1 дүгээрт Эрүүгийн хуулийн 20.17-д өөрчлөлт орохгүйгээр орж ирж байна. Мөн түүнчлэн Зөрчлийн тухай хуулийн 5.7 дээр мөн өөрчлөлт орохгүйгээр орж ирж байна. Тэгэхээр юу гэхээр энэ нөгөө нэг Зөрчлийн тухай хуулиар чинь болохоор мөрийтэй тоглоом тоглохыг хориглож байгаа. Тэгээд тоглосон тохиолдолд зөрчил гэж тооцохоор байгаа тийм үү? Тэгэхдээ энэ дээр цахим мөрийтэй тоглоомын тухай юу ч алга байгаад байгаа юм. Тэгэхээр энийгээ өөрчлөлт оруулахгүй байсан юм уу? Мөн Эрүүгийн хуулийн хэрвээ 20.17 дээр тэр цахим мөрийтэй тоглоом гэдгийг тодорхойлж оруулаагүй юм бол тэрийгээ тэр байх ёстой газар нь оруулах ёстой байсан юм биш үү гэдэг 2 асуулт байгаад байна.

Мөн түүнчлэн ер нь зарчмын хувьд Зар сурталчилгааны хууль байлаа гэхэд жишээлбэл хууль бус үйл ажиллагааг сурталчлахыг угаасаа хориглодог. Нөгөө талаас жишээлбэл Банкны тухай хууль дээр орж байгаа өөрчлөлт чинь зүгээр прокурорын зөвшөөрөлгүйгээр тухайн хэрэг маргаан болгоныг нь оруулаад тоочоод тэрийг нь дансны мэдээллийг нь аваад яваад байдаг хувь хүний нууцад халдаад байдаг болчих юм энэ чинь энэ жагсаалт чинь хэдий урт үргэлжлэх юм бэ? Тэгэхээр зарчим бол зарчим байх ёстой. Өөрөөр хэлбэл мөрдөн шалгах ажиллагаа явагдаж байгаа бол түүн дээр прокурор зөвшөөрөл өгсөн тохиолдолд банкнаас мэдээллээ гаргаж өгдөг. Тэгэхээр энэ мэтчилэн яг энэ нөгөө хэлэлцэх эсэхийг одоо бид ярилцаж байгаа шүү дээ. Тэгээд нэгэнт хэлэлцээд эхэлчихээр буцаагаад яг тэр хөндөөгүй заалтуудыг бид хөндөж чадахгүй болчихно. Нөгөө талаасаа хамтдаа засах ёстой, залруулах ёстой хуулиудыг бид хөндөж чадахгүй болчихно. Тийм учраас энэ, энэ талаасаа харж байгаад буцааж аваад, дахин сайжруулалт хийж орж ирээсэй гэж харж байгаа юм.

Нөгөө талаас нэг асуулт. Яг энэ танилцуулга дээр дурдсанаар Төлбөрт таавартай холбоотой ямар асуудал гарсан юм бэ гэдэг ерөөсөө алга байна. Бусад улс орнуудын хувьд ч гэсэн төлбөр таавар өөрөө зөвшөөрөгдөөд явдаг, цахимыг бид хянаж чадахгүй байгаа. Цахим бишийг нь яах юм бэ? Тэгэнгүүт энэ дээр төлбөрт таавар, бооцоот тоглоом, цахим мөрийтэй тоглоом гээд ороод ирж байгаа байхгүй юу. Тэгэхээр нөгөө бооцоот тоглоом, төлбөрт таавар чинь цахим гэдэг нь хамаарахгүй болчхож байгаа юм уу гэх мэтчилэн энэ өөрөө нөгөө буцаагаад нэлээн олон үл ойлгогдох зохицуулалтуудыг бий болгохоор байгаад байгаа учраас эд нарыг буцаж засаж сайжруулах шаардлагатай харагдаад байна л даа.

**Р.Сэддорж:** Хариулт 3 номер Учрал сайд.

**Н.Учрал:** 99 оны Казиногийн хууль батлагдсаны дараа Эрүүгийн хуульд өөрчлөлт орсон. Тэр бол 20.17, 20.16. Дээрээс нь Зөрчлийн хуулийн 5.6, 7. Тэгэхээр энэ юу юм бэ гэхээр нөгөө казино буюу мөрийтэй тоглоомыг олон нийтийн газар зохион байгуулах эсвэл мэдээллийн технологи ашиглан зохион байгуулахыг бие даасан хуулиар хориглосон. Тийм учраас санкцыг нь Эрүүгийн хууль дээр тавьж байсан. Зөрчлийн хууль дээр болохоор нөгөө тоглох үйлдлийг нь Зөрчлийн хуулиар шийдсэн. Тэгэхээр Зөрчлийн хууль өөрөө ямар зорилготой байсан бэ гэхээр гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх эцсийн зорилго нь нөгөө тоглож байгаа хүнийг шийтгээд байх нь биш, торгоод байх нь биш. Түүнийг зохион байгуулсан, зуучилсан, дэмжлэг үзүүлсэн, сурталчилсан нь өөрөө тусдаа үйлдлүүд.

Гэтэл тухайн үед 99 онд мэдээж цаг үе нөхцөл байдал өөр байсан учраас тухайн үед чинь тийм агент ажиллаад л нэг их тийм олон спонсорууд гарч ирээд л, тэгээд л нэг зохион байгуулалттай шинжтэй тэнд нэг шимтгэл авдаг, дэмжлэг үзүүлдэг зохион байгуулалттай ААН төрөн гарах тийм үйлдэл байгаагүй. Тэгэхээр бид энэ мөрийтэй тоглоом зохион байгуулах үйлдэл дээр нь дахиж зохицуулалт хийгээд оруулж ирэхээсээ илүү шинэ нөхцөл байдал тогтоогдсон учраас 99 оноос хойш энэ цаг хугацаанд энэ хэвлэл мэдээлэл, техник технологи өндөр хөгжсөн цаг үед цахим мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа гэдэг тусдаа ойлголт бий болжээ. Үүн дээр дэмжлэг үзүүлдэг, зуучлалын үйл ажиллагаа үзүүлдэг, зохион байгуулдаг ийм үйлдлүүд тогтоогдож байгаа учраас бид Зөвшөөрлийн хууль дээр нэгэнт олгочихсон төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаа гэдэг энэ зөвшөөрлөө Зөвшөөрлийн хуулиас хасаад, үүн дээр хориглох заалтаа нэмээд, үүнийгээ тухайлан Эрүүгийн хууль дээр санкцыг нь тавья л гэж зорьсон.

Яагаад гэхээр ийм юм байна лээ Уянгахишиг гишүүнээ. Бооцоот тоглоомыг үлдээчихье гэхээр үлдээж болохгүй. Гэхдээ бооцоот тоглоомыг үлдээчихье гэхээр ингэдэг юм байна. Бооцоот тоглоом гэдэг нэрийн дор цахим мөрийтэй тоглоомын хэлбэр шинжийг агуулсан үйлдлүүдийг зохион байгуулдаг юм байна. Дээрээс нь төлбөрт тааврыг үлдээчихье гэхээр төлбөрт таавар шүү дээ энэ чинь гэж хэлээд хохирлыг урьдчилан тооцох боломжгүй үйлдэлд хүнийг уриалан дууддаг ийм үйлдлүүдийг хийдэг юм байна. Тэгэхээр цаашдаа соён гэгээрлийн үйл ажиллагаа хийх ёстой, санхүүгийн ойлголтуудыг сайн бэхжүүлэх ёстой, олон нийтийн ажлуудыг сайн хийх ёстой. Тэр үед тусдаа хууль гаргаад стандарт шаардлагыг нь тавиад ингээд зохицуулалт хийх цаг үе манай улсад нэг өдөр ирэх байх. Гэхдээ өнөөдөр биш юм байна. Тийм учраас Зөвшөөрлийн хуулиараа нэгэнт олгочихсон байгаа зөвшөөрлөө авч хаяад, үүнийгээ Эрүүгийн хуулийг дагалдуулаад өөрчлөхдөө санкцуудыг нь үйлдэл болгон дээр тавья л гэж хичээсэн. Агент буюу зуучлалын үйл ажиллагаа дээр. Дэмжлэг үзүүлэх буюу яаж дэмжлэг үзүүлэх вэ гэхээр харилцаа холбооны сүлжээний дугаар ашиглуулсан, цахим сүлжээгээ ашиглуулсан, цахим хаягаа ашиглуулсан, банкныхаа дансыг ашиглуулсан, дэмжлэг үзүүлсэн. Зохион байгуулсан буюу байнгын биш нэг удаагийн хэв шинжтэй үйлдлийг зохион байгуулсан нь тусдаа нэг үйлдэл. Нөгөө үйл ажиллагаа эрхлэх гэдэг байнгын хэв шинжтэй үйл ажиллагаа гэдгээрээ тусдаа.

Дээрээс нь Эрүүгийн хуульд ер нь ямар тохиолдолд өөрчлөлт ордог вэ гэвэл та мэдэж байгаа. Нийгмийн хор хохирол нь өндөр хэмжээнд хүрсэн тохиолдолд гэдэг нь хангалттай бүрдсэн. 417 тэрбум төгрөгийн хохирол эдийн засгийн гэмт

хэрэг дээр тооцогдсон. Дээрээс нь 500 сая доллар жилд гарчихсан, 2-хон сарын дотор 87 сая доллар гарчихсан байхад бид энэ дээр Эрүүгийн хууль дээр санкцыг нэмэгдүүлэхээс өөр арга зам байсангүй. Ингээд зар сурталчилгааны хуулиар ч тэр энэ олон байгууллагууд цаашаа гүйцэтгэх засаглалын түвшинд ажлаа хийх нөхцөлийг бүрдүүлээд, хяналт шалгалтаа сайжруулаад явъя. Ингэж л.../минут дуусав/

**Р.Сэддорж:** Уянгахишиг гишүүн тодруулъя.

**Г.Уянгахишиг:** Сая яг хэлж байна шүү дээ. Эрүүгийн хууль дээр мөрийтэй тоглоом зохион байгуулахыг хориглох заалт бол яг нөгөө 99 оныхоо хуулийг дагаад орж ирж байгаа. Гэтэл бид өнөөдөр Зөвшөөрлийн хууль дээр тодорхой үйл ажиллагаа явуулахыг хориглох тухай заалт оруулах нь өөрөө буруу. Өөрөөр хэлбэл хуулиар хориглодог. Тэгэхээр бид тусгайлан үнэхээр цахим төлбөрт таавар, бооцоот тоглоом, тэгээд мөрийтэй тоглоомыг уг нь тэр мөрийтэй тоглоом чинь тусдаа хууль дээрээ л байх ёстой тэр цахим байна уу, тухайн биечлэн байна уу тэр чинь мөрийтэй тоглоом байхгүй юу. Бооцоот тоглоом төлбөрт тааврын хувьд цахимыг нь зөвхөн хориглох юм уу, бүхэлд нь хориглох юм уу? Түүн дотор зуучлахыг нь оруулах юм уу, эрхлэх нь гэдгийг нь юу гэж хэлэх юм, зохион байгуулах нь юу юм, тоглосон тохиолдолд яах ёстой юм гээд энэ бүхэн чинь өөрөө хуулиар зохицуулагдаж байж тусгайлсан хуулиар зохицуулагдаж байж Эрүүгийн хууль руугаа орж ирэх ёстой гэдэг дээр санал нэг байгаад байна гэж ойлгоод байна шүү дээ тийм үү?

**Р.Сэддорж:** 3 номер Учрал сайд.

**Н.Учрал:** Тийм, өнгөрсөн хугацаанд энэ бие даасан хууль гаргаад зохицуулалтыг хийх л байсан. Зүгээр харж сууж байгаад 500 сая доллар жилд алдаад, бүүр Эрдэнэс Тавантолгойн 1072-ын ноогдол ашгийг тараадаг 3 өдөрт 25 сая доллар шилжсэн байгаа шүү дээ гадагшаа. Энэ бол айл болгон цахим мөрийтэй тоглоомчинтой болсон байна гэсэн үг л дээ ер нь. Тэгэхээр Зөвшөөрлийн хууль гэдэг энэ хууль дээр нэгэнт төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаа эрхлэх гээд зөвшөөрлийг олгочихсон энэ хууль дээрээ хориглохоо тавиад л энэ зөвшөөрлийг энэ хуулиас хасаад л нөгөө холбогдох татварын хуулиудынх нь өөрчлөлтийг хасаад л зар сурталчилгааны хуулиасаа хасаад явах ийм эрх зүйн зохицуулалт хийх ийм л боломж байсан. Нэгэнт 99 оны Казиногийн хуулиар хориглочихсон учраас. Тэрнээс биш ер нь бие даасан хууль гаргаад зохицуулалт хийх бололцоо байсан уу гэвэл байсан. Маш их цаг хугацаа алдсан. Тэгээд энэнээс өөр боломж бид нарт байсангүй л гэж.../минут дуусав/

**Р.Сэддорж:** Уянгахишиг гишүүн хариултыг нэмье гэсэн саналаар 1 минут.

**Г.Уянгахишиг:** Яах вэ одоо яг энэ нөгөө нэг танилцуулга дээр чинь байгаа шүү дээ. Яг гэмт хэргээр тооцчихсон, энэ дээрээ ерөөсөө хяналт тавьж чадахгүй байна, буцаагаад энийг хааж чадахгүй байна. Тэрнээс биш яг илэрснийг нь зүйлчлэхэд асуудал алга байна. Гэмт хэрэг гээд тооцчихсон байна, гүйлгээг нь саатуулж чадаж байна. Тэгэхээр яг хэрвээ бид үнэхээр энэнтэйгээ асуудалтайгаа тулмаар байгаа бол яг бие даасан хууль гаргахад жишээлбэл казино хориглох тухай 1 л заалттай л, 2, 3 заалттай л хууль байгаа шүү дээ. Тэгэхээр яагаад яг бие даасан хууль гаргахад яг юунд тийм ийм айхтар садаатай байгаа юм бол. Нөгөө талаасаа жишээлбэл Зөвшөөрлийн хууль дээр огт зохицуулагддаггүй асуудлыг аваачиж



шигтгэх нь зүгээр бие даасан хууль батлуулахаас яагаад асуудалтай байгаад байгаа юм бэ? Нэгмөсөн асуудлаа шийдье гэж байгаа юм бол нэг мөр шийдэх боломж байдаггүй юм уу? Тэгэхгүй ингээд нэг хууль болгоныг сэглэсэн юм орж ирээд байна шүү дээ.

**Р.Сэддорж:** Хариулт 3 номер.

**Н.Учрал:** ЗГ-аас өргөн мэдүүлж байгаа энэ хуулийн концепц төлбөрт таавар, бооцоот тоглоом, цахим мөрийтэй тоглоомын үйлдэл бүрийг бүрэн хориглох ийм концепц. Тэгэхээр хууль санаачлагчийн хувьд Зөвшөөрлийн хууль дээр зөвшөөрөл эзэмшигч дараах үүрэг хүлээнэ гээд 2.3 дээр хуулиар хориглосон эсвэл хязгаарласан тохиолдолд зөвшөөрөлд зааснаас бусад үйл ажиллагаа эрхлэхгүй байх гэдэг энэ үндсэн концепцоо бариад л Зөвшөөрлийн хууль дээр заасан энэ зөвшөөрлөө аваад, хориглох заалтаа энд биччихээр бие даасан хууль заавал дахиж гаргах шаардлагагүй болчхож байгаа юм. Тэгэхээр зөвшөөрлийн энэ заасан хориглох заалтаа эшлээд бид Эрүүгийн хууль дээр хориглосон зохицуулалтуудыг нь бичээд тэгээд нэгэнт хориглогдсон учраас татвар ч бай, зар сурталчилгаа ч бай бүхэлдээ нэмэлт, өөрчлөлтөөр хасагдаад явна л гэсэн үг. Тэгэхээр эндээс ямар нэгэн хийдэл үүсэхгүй. Харин Их Хурал дээр сугалааны асуудлыг шийдье гэвэл Их Хурлын бүрэн эрхийн асуудал.

**Р.Сэддорж:** Батбаярын Жаргалан гишүүн асуулт асууна.

**Б.Жаргалан:** Хэдүүлээ эхний ээлжид суурь шалтгаанаа маш зөв оношлох хэрэгтэй байх гэж хараад байгаа юм. Залуучууд мөрийтэй тоглоом тоглож байна, эмнэлэгт хүргэгдээд байна, маш их хэмжээний мөнгө алдаад байна, валют урсаад байна гэж байгаа боловч яагаад тэр хүмүүс мөрийтэй тоглоом тоглож байгаа юм бэ угаасаа л орлого байхгүй байна, ажлын байр байхгүй байна, амьдралд нь цалин нь хүрэлцэхгүй байна, хялбар аргаар мөнгө олъё гэсэн тийм сэдлээр л тоглож байгаа шүү дээ. Тэгэхээр тэр суурь шалтгаанаа 1 дүгээрт нэг зүгээр хэлэх нь зүйтэй байх. Тэгэхээр цаашдаа энэ ЗГ-ын бодлого, Улсын Их Хурлын бодлого аль болох ийм олон ажлын байруудыг бий болгоё, иргэдийнхээ орлогыг сайжруулъя гэсэн зүйлүүд ер нь яримаар байгаа юм л даа. Түүнээс биш нэг ийм хялбар аргаар нэг иймэрхүү энэ гадаад гадагш урсаж байгаа валютын урсгалыг хаая гэсэн байдлаар ийм хөнгөн хуумгай байдлаар хууль оруулж ирэхэд би дурамжхан хандаж байна. Тэгээд энэ ор тас хориглоё гэдэг хандлага хамгийн хялбар бөгөөд залхуу арга гэдэг дээр гишүүдтэй санал нэг байна. Ер нь цаашдаа бид энэ мөрийтэй тоглоомын асуудлыг ер нь яах юм, энэ яаж зохицуулалт хийх юм энэ тэр гэдэг дээрээ илүү тийм ул суурьтай, магадгүй тэр бие даасан хууль байдаг байсан ч уу, яадаг байсан ч уу илүү ийм илүү нарийн зохицуулалтууд хийх нь зөв байх гэж харж байна.

Тэгээд нэг зүйлийг ЗГ энэ хууль санаачлагч хэлмээр байх юм. Энэ танилцуулга, үзэл баримтлал ер нь энэ бүх зүйл дээр нэг тодорхой компанийн нэрийг дурдаад, тэгээд Монголын төр нэг тодорхой компанитай холбоотой асуудлаар бүүр ингээд нэг ийм хууль батлаад байгаа юм шиг нэг их тийм сэтгэгдэл төрүүлээд байх юм. Тэгэхээр яах вэ ер нь цаашдаа аливаа зүйл дээр хууль хэрэв бид баталж байгаа бол аль нэг тэр гаднын байна уу, дотнын байна уу нэг тодорхой аль нэг компанид зориулж бид хууль баталж болохгүй шүү дээ. Тэгэхээр тэр утгаараа энэ дээрээ та анхаармаар юм байна. Тэгээд 1 компанийн л нэр яригдаад байна шүү дээ. Би бол тэрийг дурдмааргүй байгаад байна. Тэгэхээр иймэрхүү зүйл дээр бид анхаармаар байгаад байгаа юм. Яагаад гэхээр бид цаашлаад ингээд аль

болох хувийн хэвшлийн орон зайг тэлье, ер нь л ингээд ийм компаниудад эрх тэгш, нээлттэй байдлаар л аливаа зохицуулалт чинь хийгдэж байх ёстой. Тэгэхээр энэ дээр нэг ийм зүйл байна.

Тэгээд энэ 500 сая ам.доллар гарчихлаа гээд нэг ийм сенсацын шинжтэй ийм зүйл яригдаад байгаа юм. Тэгээд яах вэ гадаад валютын албан нөөцийнхөө 10 хувийг ганцхан жилийн дотор тавиад туучихсан ийм асуудал харагдаад байна шүү дээ. Тэгэхээр энэ дээр Монголбанкнаас асуумаар байна. Та нар харин энэ гарч байгаа тэр урсгалуудаа ер нь яг бүтэн траклаж чадаж байгаа юм уу? Яг үнэхээр яг энэ чиглэлээр гараад байгаа юм уу? Тэгээд яг энэ дээр ямар гүйлгээнүүд байгаад байгаа юм бэ гэдгээ нэг хэлчихмээр байна.

Тэгээд төгсгөлд нь мөрдөн шалгах байгууллагад, ер нь цагдаагийн байгууллагад иргэдийн дансыг шалгах эрхийг олгохыг.../минут дуусав/

**Р.Сэддорж:** 1 минут Жаргалан гишүүнд өгье.

**Б.Жаргалан:** Банкны тухай хуульд нэмэлт оруулж байгаа юм байна. Тэгээд энэ иргэдийн дансны мэдээллийг прокурорын зөвшөөрөлгүйгээр шууд цагдаагийн байгууллагад нээлттэй болгох ийм зохицуулалт ороод байгаа юм байна. Тэгэхээр иргэдийн дансны мэдээлэл гэдэг маш эмзэг хувийн нууцын шинж чанартай мэдээлэл байдаг. Тэгээд өнгөрсөн хугацаанд цагдаагийн байгууллагатай холбоотой маш олон асуудлуудыг бид яриад байгаа. Тэгээд ер нь энэ эрүүгийн процессын хуульд ч гэсэндээ аль болох энэ нөгөө хувь хүний эрхтэй холбоотой асуудлуудыг илүү тийм яг ийм зөвшөөрлийн дагуу энэ тэр явах ёстой гэсэн зүйлийг ярьж байгаа хэр нь яг ийм дагалдах маягаар цагдаагийн байгууллагад ийм нэмэлт эрх олгож байгааг би ерөөсөө дэмжихгүй байгаад байна. Яагаад гэхээр бид нарын бусад салбар дээр ярьж байгаа зүйлүүд дээр, зүйлүүдтэй энэ чинь зөрчилдөөд байна шүү дээ. Тэгэхээр энэ иргэдийн дансны мэдээлэл гэдэг чинь аягүй эмзэг мэдээлэл шүү дээ. Тэгэхээр энэ дээр тайлбар.../минут дуусав/

**Р.Сэддорж:** Хариулт, эхлээд 3 номер Учрал сайд.

**Н.Учрал:** Бид нэг зүйлийг ойлгох ёстой. ЭХХШТХ-ийг буюу өнөөдрийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиар гэмт хэргийн шинж агуулсан бол прокурорын зөвшөөрлөөр тухайн дансны мэдээллийг солилцох ийм эрх зүйн зохицуулалттай. Энэ нэмэлт, өөрчлөлт орж байгаа бол тэгж прокурорын зөвшөөрөлгүйгээр тэр хүний дансны мэдээллийг шалгана гэж юу байх вэ дээ. Тийм зохицуулалт боломж ч байхгүй. Зүгээр энэ бол мэдээлэл солилцох агуулга. Гэмт хэргийн шинжийг агуулсан бол. Тэгэхээр Эрүүгийн хууль дээр нэмэлт, өөрчлөлт орж байгаа үндэслэл юу юм бэ гэхээр 1-д нэгэнт нийгмийн хор хохирлын хэмжээг тооцож байна, 2-т бид залилан, залилантай, залилангийн гэмт хэрэгтэй төсөөтэй байдлаар бид энэ Эрүүгийн хууль дээр нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа юм. Энэ цахим мөрийтэй тоглоом гэдэг чинь залилангийн шинжийг агуулаад байна гэдэг агуулгаар нь санкцыг нэмэгдүүлэхдээ ч тэр.

Тэрнээс биш прокурорын зөвшөөрөл байхгүйгээр хүний дансыг шалгана гэж тийм ойлголт, тийм эрх зүйн орчин угаасаа байхгүй, тийм ойлголт байхгүй. Энэ бол тухайн этгээд залилуулчихлаа, янз бүрийн бооцоот тоглоом, мөрийтэй тоглоомд ороод залилуулчихлаа, тэнд гэмт хэргийн шинж байна, гэмт хэргийн шинж байна. Хуулиар хориглосон үйлдэлд хэн нэгнийг татан оруулчихлаа. Тэр тохиолдолд

төрийн байгууллагууд хоорондоо мэдээлэл солилцож байж тэр хохирчихсон байгаа, хуулиар хориглогдсон үйл ажиллагаанд татагдан оролцоод мөнгө төгрөгөө алдчихсан байгаа тэр иргэний мөнгийг хурдан хугацаанд царцаах, гадагшаа гараад явахаас нь өмнө хязгаарлалт хийх боломжийг төрийн байгууллагуудын хооронд олгож байж ЗГ энэ дээр арга хэмжээ авна шүү дээ. Тэгэхээр энэ бол бидний асуудал биш. Энэ бол бараг тэр хүнээс болоод ийм үйлдэл болчихсон юм гэж хэлэхэд өнөөдрийн эрх зүйн орчин зөв байж болох ч хуулиар хориглогдсон тохиолдолд ийм үйл ажиллагаа байхгүй шүү. Тэр 110 агент тэгж дураараа авирлахгүй.

Яагаад нэг байгууллагыг дурдаад байна вэ гэхээр дурдахаас өөр арга байхгүй шүү дээ. 500 сая долларыг гаргачихсан байгууллага чинь нэг л тэр алдартай байгууллага чинь мөн шүү дээ. Тэрний чинь тэр аппликэйшн рүү хүмүүсийг уруу татаад, оролцуулаад, дансаа хэрэглүүлээд сүлжээгээ ашиглуулаад, хаягаа ашиглуулаад, дугаараа ашиглуулаад байгаа 110 агент чинь ил тод байгаа шүү дээ. 110 агент чинь. Дундаас нь 2, 5 хувийн шимтгэл аваад яваад байгаа. Тэгэхээр энийг зүгээр хараад сууна гэж байхгүй, зүгээр хараад сууна гэж байхгүй шүү. Хуулийн байгууллагыг ч тэр, Монголбанкийг ч тэр, ХХЗХ-г ч тэр Их Хурал дээр та нар асуугаад шаардаад ингээд явах хэрэгтэй.

Түрүүн тэр 500 сая долларыг сенсац гэж хэлж болохгүй. Жаргалан гишүүнээ. Энэ сенсац биш. Мөнгөний бодлогыг барьж байгаа Төв банк сенсац ярьдаггүй шүү дээ. Сенсац ярихгүй. Энэ чинь тоон дээр ярьдаг. Энэ бол Монголын арилжааны банкнуудаар дамжаад гарчихсан мөнгө шүү. Иргэд гар утаснаасаа нөгөө койноо хоорондоо шилжүүлчихсэн байгааг хэн ч мэдэхгүй. Тэрийг бүү мэд. Энэ Монголын банкнуудаар дамжаад, тэр агентууд дундаас нь 2 хувийг нь аваад гарчихсан мөнгө. Энэ тоо, энэ худлаа юм биш, энэ сенсац бас биш. Тийм учраас бүгдээрээ зүгээр иргэдийнхээ өнөөдрийн амьжиргааны түвшин үнэхээр үнэн, Жаргалан гишүүний хэлж байгаа үнэн амьжиргааны түвшнээс болж байгаа. Хялбар аргаар мөнгө төгрөг олъё гэсэн сонирхол байна. Ажлын байр байхгүйгээсээ болж байна. Тэгэхдээ энийг зүгээр хараад сууж болохгүй. Өнөөдөр гадаадын улсууд Япон, Солонгос, Тайланд, энэ Вьетнам, Индонез, цахим мөрийтэй тоглоомыг энэ улсууд бүгдээрээ хориглосон. Бүгдээрээ хориглосон.../минут дуусав/

**Р.Сэддорж:** 5 номер.

**Г.Энхтайван:** Гадаад гүйлгээтэй холбоотой мэдээллийг арилжааны банкнууд Төв банканд жил болгон гадаад гүйлгээний тайлан дээр ирүүлдэг байгаа. Монгол Улсын харьяат болон Монгол Улсын харьяат бусын хооронд хийгдсэн гүйлгээг тооцоход 21 онд 120 сая доллар, 22 онд 198, 23 онд 430 сая, 24 онд 578 сая доллар буюу нийт 4 жилийн хугацаанд 1,3 их наяд тэрбум доллартой тэнцэх хэмжээний долларыг яг энэ ангиллаар шилжүүлсэн байгаад байгаа юм ангиллаар. Тэгээд хүлээн авагч орнуудыг нь тооцохоор Лихтенштайн улс руу 55 хувь нь, АНУ руу 26 хувь, Сингапур руу 16 хувь, Хонконг руу 1 хувь гэх мэтчилэн. Тэгээд яг хүлээж авч байгаа байгууллагуудыг нь бид хэд ангилсан байгаа. Түүн дээр дийлэнх нь Payward limited, First digital trust limited гэдэг 2 компани байгаа. Энэ нийтдээ 70 хувийг нь хүлээж авч байгаа. Аль, аль нь яг ийм.../минут дуусав/

**Р.Сэддорж:** 5 номер 1 минут.

**Г.Энхтайван:** Энэ нэр дурдсан 2 компани аль, аль нь энэ крипто валютын бирж хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг. Яг энэ онлайн бооцоот тоглоом, онлайн

gambling, онлайн казинотой холбоотой гүйлгээг дэлхийн бусад улс орнуудаас хүлээж авдаг байгаа. Ажлын хэсгийн ахлагчийн хувьд агентуудын тухай мэдээллийг хөндсөн. Яг Төв банкны энэ гадаад гүйлгээний тайлан дээр агентуудын 46 хувийг ААН, 54 хувийг иргэд байгаа, 46 хувийн ААН-ийг хэд хэдэн компани бүрдүүлж байгаа. Хамгийн том нь Чойжин алтекс гэдэг компани 285 сая долларын гүйлгээг хийсэн байгаа бол хамгийн өндөр давтамжтай гүйлгээг иргэн Үнэнбаяр гэдэг хүн 253 сая долларын гүйлгээ хийсэн гэх мэтчилэн энэ мэдээллүүд гарсан байгаа. Тэгэхээр энэ банкнуудын гадаад валютын гүйлгээний тайлан яг албан ёсны тоо. Энэ дээр ямар нэгэн буруу ташаа мэдээлэл ерөөсөө байхгүй байгаа.

**Р.Сэддорж:** 3 номер нэмж хариулъя.

**Н.Учрал:** Бооцоот тоглоом гэдэг бол үр дүнг урьдчилан тооцох боломжтой үйлдлийг, мөрийтэй тоглоом гэж цахим мөрийтэй тоглоом гэдэг үр дүнг урьдчилан тооцох боломжгүй үйлдлийг хэлдэг. Гэхдээ бооцоот тоглоом дээр янз бүрийн манипуляц хийдэг, иргэдийг залилдаг үйлдлүүд тогтоогдож байгаа. Энэ юу юм бэ гэхээр энэ төлбөр таавар шүү, энэ бооцоот тоглоом шүү гэж хэлээд бооцоон дээр тавигдсан мөнгийг өсгөхийн тулд янз бүрийн үйлдлүүдийг хийж байгаа ийм үйлдлүүд тогтоогдож байгаа учраас үүнийг зохион байгуулсан дээр нь ч тэр, дэмжлэг үзүүлсэн дээр нь ч тэр, зуучилсан дээр нь ч тэр, сурталчилсан дээр нь ч тэр бүх үйлдлүүдийг хориглоё. Дээрээс нь бид нэг зүйлийг энэ Байнгын хороог иргэд харж байгаа. Монголбанк 500 сая доллар гадагшаа урсчихсан байна гээд сенсацална гэж юм байхгүй шүү. Тэгэхээр ард түмний иргэдийн 500 сая доллар гарчихсан гэж ингэж ингэтлээ худлаа сенсацалдаг юм гэж юу байх вэ дээ. Энэ зөв ойлголт өгөхгүй бол болохгүй байх.

**Р.Сэддорж:** Жаргалан гишүүн тодруулж асууя.

**Б.Жаргалан:** Цагдаагийн байгууллагад банкнаас иргэдийн харилцагчдын мэдээллийг татаж авах эрхийг Банкны тухай хуульд нэмэлт оруулах замаар авч байна гэж ойлгож байна. Тэгэхээр энэ Хууль зүйн яамнаас хүмүүс байгаа юм уу? Яагаад энэ Хууль зүйн яамнаас хүмүүс байхгүй байгаад байгаа юм. Энэ нөгөө процессын хуульдаа өөрчлөлт оруулахгүйгээр Банкны хуульд ийм өөрчлөлт оруулах замаар цагдаагийн байгууллагад ийм онцгой эрх өгнө гэдэг учир дутагдалтай харагдаж байна. Яагаад гэхлээр та мөрийтэй тоглоом тоглосон байж болзошгүй гээд хэн дуртай хүнийхээ дансны мэдээллийг татаад авах эрхийг цагдаагийн байгууллагад олгочхож байна шүү дээ. Тэгэхээр энэ бол Монгол Улсын бүх л иргэнд хамаатай асуудал байх гэж бодоод байгаа юм.

**Р.Сэддорж:** 3 номер.

**Н.Учрал:** Банкны хууль дээр ямар өөрчлөлт орж байгаа юм бэ гэхээр 7.2.12 дээр төлбөрт таавар, бооцоот тоглоом, цахим мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа эрхлэх үйл ажиллагаа эрхлэх, зуучлах агент хийх, төлбөрт таавар, бооцоот тоглоом, мөрийтэй тоглоомыг сурталчлах, цахим хэрэгслийг ашигласан залилах гэмт хэрэгт хуульд заасны дагуу мөрдөн шалгах байгууллагаас шаардсан тохиолдолд мэдээлэл солилцоно гэж. Энэ юу юм бэ гэхээр хуульд заасны дагуу гэхээр эрүүгийн процессынхоо хуулийг хэлж байгаа. Эрүүгийн процессын хууль дээр энэ үйл ажиллагааг нарийвчлан зохицуулсан байдаг. Энэ хуулийг барихгүйгээр хууль хяналтын байгууллага хэзээ ч энэ үйлдлийг хийх бололцоогүй. Энэ бол прокурорын зөвшөөрөлгүй энэ тэр гэсэн ойлголт огт биш. Яагаад гэвэл эрүүгийн процессын

хууль дээр энийг нарийвчлан зохицуулаад, прокурорын зөвшөөрөл авсан тохиолдолд л энэ мэдээлэл солилцох үйл ажиллагааг зохион байгуулагдана. Тэгэхдээ энийг тухайлан зохицуулсан. Залилах гэмт хэрэгт гэж байгаа шүү дээ энэ, энэ үйлдлүүд дээр.

**Р.Сэддорж:** Хууль зүйн яам 1 номер.

**Н.Жамъянхүү:** Банкны тухай хууль дээр Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй уялдуулаад энэ холбогдуулаад Банкны тухай хууль дээр нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа. Тэгэхдээ энэ гол нь Банкны тухай хуулийн энэ 7.2 дээр шинэ заалт нэмж байгаа. Би та бүхэнд 7.2-ыг товчхон уншаад үзье, өгье. Энэ бол банк түүний харилцагч, түүний гуравдагч этгээд нууц гэж үзсэн аливаа мэдээллийг доор дурдсанаас бусад тохиолдолд гаргаж өгөхөөр ийм мэдээллүүд байгаа. Тэгэхээр энэ бол гол асуудал нь нөгөө эрүүгийн процессын хууль буюу ЭХХШТХ-д заасан тодорхой нөхцөл шаардлагын үүднээс зөвхөн тухайлбал 22.1.3-д заасан ЭХХШТХ-ийн 22.1.3-д заасан энэ шаардлагыг үндэслээд царцаах ийм эрхүүдийг олгож байгаа байхгүй юу. Өөрөөр хэлбэл 1 дүгээр данс, 2 дугаар данс юм уу, цаашид 3 дугаар данс руу энэ мөнгө.../минут дуусав/

**Р.Сэддорж:** 1 номерт 1 минут.

**Н.Жамъянхүү:** Энэ өөрөө залилах болон энэ төрлийн гэмт хэргүүдийн ялангуяа цахимаар үйлдэгдэж байгаа гэмт хэргүүдийн нөгөө хохирлын мөнгө нь цаашаагаа 1 дүгээр данс, 2 дугаар данс ч юм уу, 3 дугаар данс руу маш хурдан шилжих ийм нөхцөлүүд байгаад байдаг. Тэгэхээр энийг маш хурдан зогсоох, энэ талаар царцаах ч юм уу энэ талаарх мэдээллийг авах үүднээс энэ төрлийн зохицуулалтын шаардлагыг Банкны тухай хуульд оруулж өгч байгаа. Гэхдээ энэ бол дур зоргоор юм уу эсвэл цагдаагийн байгууллага янз бүрийн хууль бусаар авах үйлдэл биш. Цагдаагийн байгууллага ч тэр, бусад эрх бүхий байгууллага ч тэр яг энэ төрлийн харилцаан дээр ЭХХШТХ-д заасны дагуу энэ үйл ажиллагааг явуулж байгаа. Тэгэхээр энэнтэй уялдсан ийм зохицуулалт орж өгч гэж байгаа юм.

**Р.Сэддорж:** 2 асуулт. Зөвшөөрлийн хууль дээр чинь ийм, ийм юм зөвшөөрнө гэж байгаа. Тэгээд ийм, ийм зүйлийг хориглоно гээд энэ хууль дээрээ ингээд цаашдаа энэ ингээд давтаад байх юм биш биз дээ гэсэн энэ хуулийн талаас нь асууж байна.

2 дугаарт нь энэ төлбөрт таавар, бооцоот тоглоом гэдэг дээр бооцоот морин уралдаан, спортын бооцоот уралдаан тэмцээн эд нар орж байгаа юу? Эд ингээд хамт хориглогдох уу гэсэн ийм асуулт байна. 3 номер.

**Н.Учрал:** Зөвшөөрлийн хууль дээр яагаад энэ хориглох зохицуулалтыг хийсэн бэ гэвэл энэ өөрөө нэг тийм салбарын хуультай асуудал ерөөсөө биш. Нөгөө бие даасан салбарын ямар нэгэн хууль байхгүй. 99 оны Казиногийн хууль дээр энийг нэмээд биччихье гэхээр энэ өөрөө казиногоос өөр ойлголт яваад байгаа юм. Энэ чинь нөгөө төлбөрт таавар, бооцоот тоглоом, тэгээд нөгөө бооцоот тоглоом гэдэг нэрийн доор мөрийтэй тоглоомын хэв шинжийг агуулсан үйлдлүүдийг эрхэлдэг. Төлбөрт таавар гэдэг нэрийн доор мөрийтэй тоглоомын хэв шинжийг агуулсан үйл ажиллагаа эрхэлдэг, зуучилдаг, дэмжлэг үзүүлдэг, дансаа ашиглуулдаг, энэ үйлдэлд уриалан дууддаг сурталчилдаг үйлдлүүд. Тийм учраас энийг Зөвшөөрлийн хууль дээр нэгэнт олгосон зөвшөөрөл байгаа учраас түүнийг нь

энэ хуулиас хасаад, хориглох заалтыг бичих нь л хамгийн зохимжтой гэж үзсэн. Тэгээд яах вэ ер нь хууль санаачлагчийн хувиар Зөвшөөрлийн хууль дээр энийгээ энэ үйлдлүүдээ бүхэлд нь хориглохгоод, тэгээд бусад хуулиудаа хөндье гэдэг ийм хууль.

Тэгээд Зөвшөөрлийн хуулийн гол концепц энэ хууль дээр заагдсанаас бусад төрлийн үйл ажиллагааг зөвшөөрнө гэдэг ойлголттой байхгүй юу. Үүн дээр ингээд зөвшөөрлүүд буюу энэнээс бусад үйл ажиллагаа хориглогдоно. Энэ дээр байгаанууд зөвшөөрөгдөнө л гэдэг ийм хуулийн концепцтой учраас бид энэ зөвшөөрлийнхөө хууль дээр бичих нь хамгийн зохимжтой гэж үзсэн. Тэгээд хориглоно гэж хэрвээ заахгүй бол үүнийг орхичихвол зөвшөөрөгдөнө гэдэг агуулга явчхаад байгаа юм. Зөвшөөрөгдөх юм байна гэдэг агуулга явчхаад байгаа учраас заавал энэ дээр хориглож бичихээс өөр сонголт байхгүй. Зөвшөөрлийн хууль өөрөө хориглосон заалт огт бичээгүй хууль биш. Үүн дээр хориглосон заалтууд бичсэн. Бид хаврын чуулганаар Зөвшөөрөл, мэдэгдлийн хуулийг Их Хуралд өргөн мэдүүлнэ. Үүний үеэр энийг концепцын хувьд эргэж харах шаардлагатай байгаа. Ер нь Зөвшөөрлийн хууль дээр. Зөвшөөрөл, мэдэгдлийн хуулийг Их Хуралд чуулганд өргөн мэдүүлэхээр ЗГ ажиллаж байгаа гэдгийг хэлье.

Тэр морин уралдаан бусад тэр төлбөрт тааврын үйл ажиллагаануудыг Их Хурлын гишүүн Сайнзоригоор ахлуулсан ажлын хэсгийн зүгээс хууль санаачлах гээд ажиллаж байгаа гэж бид ойлгосон. Энэ үеэр хэрвээ тодорхой шаардлагуудыг тавиад, татвар мөнгөө аваад, ингээд тухайлан зохицуулалтуудыг хийе гэвэл энэ бол мэдээж хууль батлагдсаны дараа хүчин төгөлдөр мөрдөгдөөд явах бололцоотой. Бид нэн яаралтай горимоор өргөн мэдүүлээд холбогдох арга хэмжээнүүдийг авахгүй бол нийгмийн хор хохирол хэмжээ хязгаараа давлаа. Тийм учраас зохих арга хэмжээ авъя гээд ЗГ-ын зүгээс ийм байр суурьтай байгаа. Их Хурлын гишүүд хуулиа баталбал энэ бол нээлттэй.

**Р.Сэддорж:** Гишүүд асуулт асууж дууслаа. Үг хэлсний дараа санал хураалт явагдана. Тийм учраас Байнгын хорооны гишүүдийг хуралдааны танхимдаа орж ирэхийг урьж байна. Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан дэмжсэн, дэмжээгүй байр суурь илэрхийлж үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Энхцэцэг гишүүнээр тасалъя. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн үг хэлнэ.

**О.Номинчимэг:** Хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж байгаа. Бид энэ асуудлыг үнэхээр хугацаа алдсан гэдэг дээр санал нэг байгаа. Олон жилийн өмнөөс энэ асуудал нийгмийн дунд ийм асуудал гараад бүүр ингээд алдчихсан хойно нь бид хойноос нь чадах ядахаараа арга хэмжээ авъя гээд явж байгаа. Тэгээд энэ асуудлыг анх Улсын Их Хурлын чуулган дээр хөндөж тавьснаас хойш олон ээжүүд, олон гэр бүлийн гишүүд, олон хүмүүс энийг үнэхээр яаралтай зохицуулаад өгөөч, арга хэмжээ аваач, гэр бүлээ алдлаа, амиа хорлох гэж байна, сэтгэл зүйн дарамтад орж байна гээд олон асуудлуудыг тавьсан. Тэгээд энэ дээр яаралтай шуурхай арга хэмжээ аваад тодорхой шийдэл гаргаад орж ирж байгаа ЗГ, Хэрэг эрхлэхийн дарга Учрал сайдад их баярлалаа гэж хэлмээр байна.

Тэгээд энэ яах вэ бид яах вэ ингээд нөгөө гоё, гоё юм ярьж болно л доо. Эдийн засгаа яагаад орлогоо сайжруулах ёстой эхлээд энээ тэрээ гээд. Гэхдээ энэ үнэндээ яг бодит амьдрал дээр ийм нийгмийн асуудал болчихоод байгаа учраас бид ямарваа нэгэн арга хэмжээг зоригтой аваад, үүнийхээ дагуу ажиллаад, тодорхой хугацааны дараа энэ тэр морин бооцоот байна уу, юу гэдэг юм алдаа оноон дээрээ

бид юун дээрээ хийж чадаж байна, чадахгүй байна гэдгээ дүгнээд энэ дараагийн алхмуудыг хийх боломж нь гарах байх гэж бодож байгаа юм. Тэгээд энэ гол асуудал энэ чинь энэ залуучуудын донтолт гэдэг юман дээр дөрөөлөөд залилангийн шинж чанар луу орчихсон иймэрхүү үйл ажиллагаа их байгаа учраас юуны түрүүнд хориглох арга хэмжээг аваад, энийгээ гол нь хэрэгжилтээ хангах тал дээр анхаарах ёстой. Ингээд дараа дараагийн зүйлээ тэр үедээ судалгаа тооцоотой хийх нь зүйтэй болов уу гэж харж байгаа.

Зүгээр яах вэ энэ дээр хэлэхэд энэ хууль гарснаараа бүх энэ 100 хувь энэ асуудлыг шийднэ гэдэгт би ч итгэхгүй байгаа. Энийг ард иргэддээ би бодитоор хэлэх ёстой. 100 хувь энэ донтолтын асуудлыг байдаг юм уу, мөрийтэй тоглоомын асуудлыг энэ хуулиар 100 хувь шийдэх боломжгүй. Гэхдээ тодорхой үр дүн гаргана. Энэ хуулийн зорилт өөрөө түрүүн үзэл баримтлал дээр гарч байна 60 хэдэн хувиар бид бууруулж чадна гэдэг ийм зорилт тавьж байгаа юм байна. Тэгэхээр энэ хүрээндээ л бид хуулиа гаргавал хэрэгжүүлэлтийн механизм дээрээ яаж анхаарч ажиллах вэ гэдэг дээр Улсын Их Хурал дээр гарах ажлын хэсэг анхаарч ажиллах ёстой болов уу гэж бодож байна. Тэгээд энэ хооронд асуудлуудаа цэгцлээд, тоо баримтаа гаргаад, бид нарын нөөц боломж юу байгаа билээ, иргэдийгээ соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлуудыг давхар хийж байж дараа дараагийн энэ боломжуудыг сайн зохицуулалттайгаар нээж өгөхгүй бол манайх шиг ийм улс орнуудыг target-ласан, бай оноогоо болгосон ийм үйл ажиллагаанууд үнэндээ манайд зах замбараагүй орж ирж байгаа учраас энэ дээр дэмжиж, хуулийн төслийг дэмжиж байгаа гэдгээ илэрхийлмээр байна. Баярлалаа.

**Р.Сэддорж:** Гончигдорж Уянгахишиг гишүүн үг хэлнэ.

**Г.Уянгахишиг:** Энэ дээр асуудал шийдэх гээд байгааг нь ойлгож байгаа. Тэгэхдээ түрүүн асуулт асуух үедээ хэлсэнчлэн бид хууль тогтоох байгууллага ийм зарчмаар ажиллаж болохгүй. Яагаад гэхээр ЗГ-аас хууль өргөн барьж байгаа бол хуулийнхаа зарчмыг, хуулийнхаа техникийг баримтлах ёстой. Яаралтай горимоор бид шийдье гэсэн. Гэхдээ энэ дээр хэрвээ хуулиар хориглосон гэж байгаа бол энэ нь хаа хамаагүй ямар нэгэн хууль дээр шигтгээд өгчихөөр хориглож болно гэсэн заалт биш шүү дээ. Тэгэхээр тусгайлан хуулиа оруулаад ирээч гэдэг утгаар энийг буцаамаар байгаа юм.

Зөвшөөрлийн хууль дотор хориглох заалт оруулна гэж байна. Гэтэл Зөвшөөрлийн тухай хуулийн 1.1 дээр хуулийн зорилт гэж байгаа. Энэ хуулийн зорилт нь юу вэ гэхээр эрх бүхий этгээдэс зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тэдгээрийн бүртгэл хяналт, түүнчлэн зөвшөөрлийн ангилал, жагсаалтыг тогтоохтой холбогдох нийтлэг харилцааг зохицуулахад оршино гэж байгаа юм. Тэгэхээр Зөвшөөрлийн хуулиар Учрал сайдын хэлдэг шиг өөр үйл ажиллагааг хориглочихсон юм байхгүй. Ерөөсөө энэ зөвшөөрлийн үйл ажиллагаа, зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэхтэй холбоотой үйл ажиллагаа явуулахад юуг хориглох вэ гэдэг дээр л хориглоно гэдэг үгнүүд хэрэглэгдсэн байгаа. Тэгэхээр өнөөдөр бид хууль тогтоох байгууллага ЗГ-аас өргөн барьсан цаад юу гэдэг юм агуулга нь зөв байж болно, гэхдээ энэ өөрөө зөв хууль бичигдэх ёстой байхгүй юу. Тийм учраас энийг буцаагаад, хуулийнхаа бие даасан хуулиа оруулж ирээч. Энэнийхээ дагуу зохих хуулиудад өөрчлөлт оруулаач.

Нөгөө талаасаа Учрал сайд буруу тайлбарлаад байна. Тэр Банкны тухай хууль дээр мэдээлэл авах эрхийг нь зааж өгч байгаа юм. Тэрнээс тэр царцаах бол

тусдаа явж байгаа. Үнэхээр процессын хуулиараа Эрүүгийн хэрэг байцаан шийтгэх хуулиараа явна гэж байгаа юм бол тэр чинь өөрөө 7.2.2 дээр байж байгаа шүү дээ. Прокурорын зөвшөөрлөөр мөрдөн шалгах ажиллагааны шаардлагаар гээд бүх юм нь байж байгаа байхгүй юу. Тэгэхэд энэ дээр тусгайлан оруулж ирнэ гэдэг чинь тэр прокурорын зөвшөөрлөөр орж ирэх гэдэг санааг тусад нь гаргаж ирж байгаа гэсэн үг. Тэгэхээр энэ мэтчилэн асуудлуудаа хууль тогтоох байгууллагын хувьд Их Хурлын гишүүд аягүй сайн ойлгох ёстой. ЗГ-аас хууль өргөн барьж байгаа бол энэ, энэ тал дээрээ бодолтой байх ёстой гэдгийг хэлмээр байгаад байгаа юм.

**Р.Сэддорж:** Мөнхсоёл гишүүн үг хэлнэ.

**Б.Мөнхсоёл:** Энэ залуучууд, хүүхэд багачуудын донтолттой холбогдуулаад гэр бүлийн дотоод асуудал буюу гэр бүл салалт, үр хүүхдүүдийн ийм гэртээ учруулж буй эдийн засгийн болон бусад сэтгэл зүйн асуудлуудтай холбогдуулаад, мөн цаашлаад төлбөрийн тэнцэлтэй холбогдуулаад Монголоос та 500 сая доллар гадагшилчихна гэдэг чинь том дүн. Тэгэхээр бид байнга эдийн засгийн асуудал ярьж байна, төлбөрийн тэнцэл ярьж байна энэ утгаараа чухал гээд би бол зохицуулах ёстой гэдэг талд нь байсан. Энэ хуулийн төсөл энэ зарчим орж ирээгүй байхад зохицуулах ёстой гэдэг яриаг хэвлэл мэдээлэлд өгчихсөн юм.

Гэхдээ нөгөө талдаа энэ гишүүд хүртэл эргэлзэж байна шүү дээ. Угаасаа энэ нийгэмд итгэлцлийн асуудал хаа сайгүй байгаа гэж би анх ээлжит бус чуулганаар хэлж байсан. Тэгэхээр аливаа энэ хөндөж байгаа асуудлуудаа бүүр илүүтэй сайн зөвхөн хууль оруулж ирснээрээ биш баримтжуулах шаардлагатай гэж боддог. Тухайлбал баримтат кино энэ тэр яагаад хийж болохгүй гэж. Энэ нь нөгөө талдаа яагаад энэ нь донтолт вэ гэдгийг залуучуудад мэдлэгжүүлэхэд хэрэгтэй юм болов уу. Бас нэг зүйл нь зохицуулахдаа би энэ хүн болгон өөрийнхөө өнцгөөс харж яриад байна. Хуульч хүмүүс маань зөв процедураараа орж ирэхгүй бол зүгээр нэг хуульд хориглох маягаар орж ирэхээр бусад хуулиудтайгаа зөрчил үүсэх магадлалтай гэж хэлж байгааг харгалзаж үзээсэй гэж хэлмээр байна.

Нэг өөр зүйл болохоор ер нь аливаа асуудлыг шийдэхдээ цогцоор нь шийдэхгүй бол нэг асуудлыг шийдэх гэж байгаад нөгөө сөрөг үр дагавраа өдөөж өгдөг энэ асуудал үүсэх вий. Тэр Жаргалан гишүүний хэлж байгаа асуудал, Уянгахишиг гишүүний хэлж байгаа асуудлыг давхар тооцоод, өөрсдөө энэ санал хураалтаас өмнө энийгээ шийдээд санал хураах уу, үгүй юү гэдгээ хэлчихвэл зүгээр юм байна гэж бодлоо саяын энэ үйл явцаас хараад. Одоо тэртээ тэргүй энийг дагаад бусад хуулиуд өөрчлөлт орно гэж байна шүү дээ. Хүн амын орлогын албан татвар, бусад холбогдох татварын хуулиуд. Тэгэхээр сайн бодох, нухацтай харах хугацаа хэрэгтэй юм болов уу ч гэж бодогдож байна шүү. Зохицуулах тал дээр байр сууриа илэрхийлсээр байгаа.

**Р.Сэддорж:** Батнайрамдал гишүүнийг нэмье. Мөнхчулууны Энхцэцэг гишүүн.

**М.Энхцэцэг:** Энэ хуулийг үзэл баримтлалын хувьд дэмжиж байгаа. Үнэхээр энэ хамтарсан ЗГ, Улсын Их Хурлын эрхэм зорилгуудын нэг бол бид яалт ч үгүй ард иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах. Тэгэхээр минут, секунд тутам өнөөдөр иргэд хохирч байна. Асар их хэмжээний доллар, асар их хэмжээний мөнгө төгрөг гадагшаа урсаж байна. Маш их хэмжээний хүмүүс энэ мөрийтэй тоглоомын донтолтын асуудалд өртөж байна гэдэг асуудал бид нарын нэн тэргүүний шийдэх ёстой



асуудал мөн. Тийм учраас энэ хуулийг маш яаралтай цаашаа явуулж, батлуулах нь зүйтэй юм байна гэж ингэж үзэж байна.

Дээрээс нь мэдээж Улсын Их Хурлын гишүүд эрх, үүргийнхээ хүрээнд маш олон зөв зүйтэй саналуудыг хэлж байна. Тэгэхээр энийг ингээд тусгаад, энэ хуулийг маш яаралтай батлахгүй бол минут, секундээр хэдэн мянган доллароор ард иргэд хохирч байгаа асуудлыг зайлшгүй шийдэх хэрэгтэй юм байна. Тэрнээс бид маш олон саад тотгоруудыг яриад энийг хойшоо тавиад л байх юм бол иргэд хохироод байх юм байна гэдгийг хүн болгон ингэж ойлгож байна. Тэгээд дээрээс нь мэдээж хар даа энэ бол асуудал зөвхөн Монгол Улсад байдаг асуудал биш. Бүхий л дэлхийн улс орнууд энэ асуудлыг чинь авч үзээд, ард иргэдээ яаж хамгаалах вэ, яаж хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх вэ гэдэг тал дээр нэлээн олон зохицуулалтуудыг хийчихсэн байгаа. Тэгэхээр энийг маш сайн судалж үзээд, энэ хуулиа улам цаашаа чамбайруулаад, яаралтай батлах нь зүйтэй юм байна гэж үзэж байна.

Би хэдхэн жилийн өмнө жишээ нь Монгол Улсад нэг найз руугаа 2 сая төгрөг шилжүүлээд, тэгээд тэр нь болохоор бас л залилан байсан. Банкин дээр очсон. Ерөөсөө тэр мөнгийг харсаар байгаад тэр нэг Кибер гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс дээр нь очсон. Ямар ч үйлдэл хийх боломжгүй юм байна лээ бүүр гайхалтай. Гэтэл Австрали улсад яадаг вэ гэхээр хүн рүү шилжүүлсэн мөнгө уучлаарай би энэ мөнгийг шилжүүлэхгүй гэхэд тэр мөнгө цааш нь тэр банк цаашаа шилжүүлдэггүй, тэгж хүнийхээ эрхийг хамгаалдаг. Гэтэл Монгол Улсад үгүй, бүүр харсаар байж байгаад тэр мөнгийг ингээд цаашаа явуулчихдаг юм байна лээ. Тэгээд цаашаа бүүр яаж ч, тэгэхээр энэ бол иргэдээ хамгаалах маш зөв зүйтэй хууль орж ирж байгаа юм байна. Тэгээд энийг цааш нь улам хуулийг өргөн барьсан хүмүүс Улсын Их Хурлын гишүүдтэйгээ хамтраад улам чамбайруулаад, яаралтай батлах нь зүйтэй юм байна гэсэн байр суурьтай байна.

**Р.Сэддорж:** Отгоншарын Батнайрамдал гишүүн.

**О.Батнайрамдал:** Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай энэ хуулийг 100 хувь дэмжиж байгаа. Энэ бол 500 сая долларын асуудал ерөөсөө биш юм л даа. Энэ бол яг дэлхий даяар ялангуяа тэр эмзэг орнуудад явж байгаа энэ чинь нийгмийн асуудал болчихсон байхгүй юу. Энэ залилангийн асуудал, энэ донтолын асуудал, энэ үндэстэн дамнасан мөнгө угаалтын хэрэг байхгүй юу. Өнөөдөр бид 500 сая доллар гээд доллароор яриад байгаа нь яг үнэнийг хэлэхэд нэг талдаа зохимжгүй байна. Энэний ард хэдэн 10 мянган айл өрхийн амьдрал сүйрч байгаа байхгүй юу. Тэр үр хүүхэд нь энэ онлайн bet-д ингээд донтчихсон. Донтолт гэдэг чинь өөрөө тийм амархан эмчлээд 2 долоо хоног эмчлээд алга болгочихдог зүйл биш шүү дээ. Өнөөдөр үр хүүхдээ аваад энэ донтолттой нь хэрхэн тэмцэх вэ гээд явж байгаа 10 аав, ээж тутмын 7, 8 нь энэ онлайн bet-тай холбоотой байгаа шүү.

Сая Монголбанкны Дэд ерөнхийлөгч тэр сая тоонуудыг нь хэлж байна шүү дээ. Ямар их доллар цаашаа урссан. Энэ өөрөө ашгийн талаас нь харвал энэ чинь аюултай ашигтай бизнес байхгүй юу. Орсон, урссан тэр мөнгийг нь тооцвол энэ чинь 3 жилийн дотор хэд дахин үржээд 1 тэрбум доллар даваад явж байна шүү дээ. Тэгэхээр энэ зүгээр нэг мөнгө төгрөгөөр хэмжээд байх асуудал биш учраас энэ дээр үнэхээр төр гэж байдаг юм бол энэ дээр зохицуулалтын асуудлаа заавал хийх ёстой. Сая Энхцэцэг гишүүний хэлсэн зөв. Секунд алдах тоолонд нэг айл, нэг өрхийн амьдрал л сүйрч байна гэж ойлгож болно. Тийм учраас тэр техникийн

асуудлуудыг засаж болно шүү дээ. Улсын Их Хурал дээр ажлын хэсэг байгуулагдаад л тэр техникийн асуудлууд байвал засчихъя л даа бүгдээрээ. Тийм учраас энэ хуулийг бид ямар нэгэн байдлаар явуулж асуудлаа бид заавал шийдэх ёстой. Энд амьдралаараа сүйрчихсэн байгаа аав, ээж нар яг бид нарыг эндээс ямар шийдэл гарах вэ гээд хараад сууж байгаа. Тийм учраас энэ хуулийг бодох юмгүй, эргэлзэх юмгүй 100 хувь дэмжих ёстой гэж бодож байна. Тэгээд та бүхэн маань ч гэсэн эрхэм гишүүддээ дэмжээд өгөөрэй л гэж хүсэж байна. Баярлалаа.

**Р.Сэддорж:** Гишүүнийхээ хувьд Учрал сайд үг хэлэх эрхтэй. Тийм учраас Учрал сайдыг нэмье. 3 номер.

**Н.Учрал:** Гишүүддээ баярлалаа. Тэгээд залуус нь амиа алдаж, гэр бүлүүд нь сүйрч, энэ эдийн засаг хорлогдож, 500 сая доллар жилийн хугацаанд гадагшаа урсаж, бид анхааралтай ажиглаж ажлын хэсгээ гаргасаар байтал 1 сараас өнөөдрийг хүртэл хугацаанд 87 сая доллар гадагшаа урсчхаад байна. Цаашдаа анхааралтай ажиглаад, ажлын хэсгээ байгуулаад хууль зүйн техникээ ярьсаар байвал энэ төрийн байгууллагууд ажлаа хийхэд хүндрэлтэй болж байгаа. Бид Их Хурлын чуулган дээр оруулж ирээд төрийн байгууллагуудыг шүүмжилдэг, загнадаг, зэмлэдэг. Гэхдээ энэ хүмүүст ажил хийх нөхцөл бололцоог бий болгох ёстой. Цаашдаа ер нь төрийн байгууллагынхныгаа дэмжиж ажиллуулахгүй бол энэ Их Хурлын чуулган дээр орж ирээд 126 хүнд өдөр болгон загнуулсаар байтал ЗГ-ын олон ажлын хэсэгт суусаар байтал, тэгээд бид эрх зүйн орчныг нь бүрдүүлж, ажил хийх нөхцөл бололцоогоор нь хангаж өгөхгүй мөртөө хоосон шүүмжилсээр байтал ард иргэдийн төлөө ажиллаж чадахгүй байна. Энэ тоглоом биш болчихлоо.

Ер нь энэ цахим мөрийтэй тоглоом чинь тоглоом биш шоглоом болсон шүү. Та бүхний гар утас руу олон хүмүүс мессеж бичиж байгаа. Би тэрийг мэдэж байгаа, над руу ч ирж байгаа. Энэ 110 агент чинь асар том бизнес эрхэлж байгаа, үндэстэн дамнасан бизнес эрхэлдэг нөхөд болж хувирсан байна. Энэ 110 агент чинь. Энэ ганцхан компанийг яриад байна гээд байгаа. Энийг ярихаас өөр яах юм бэ. Ганц аппликэйшнийг тойроод 1,7 их наяд, жилд бид хүүхдийн мөнгөнд 1,6 их наядыг зардаг шүү дээ. Хүүхдийн мөнгөтэй тэнцэх хэмжээний мөнгө гаргаад явуулчихсан. Би түрүүн жишээ хэлсэн шүү дээ. Эрдэнэс Тавантолгойн ноогдол ашгийг тараасан 3 өдөрт 25 сая доллар гадагшаа урсаж байгаа. Түрүүн гишүүд яриад байна. Монголбанкин дээр тэр заалт хэрэггүй гэж. Яг үнэндээ тэр чинь мөнгө царцаах эрхээс гадна тэр мөнгө царцаад аль данс руу очсон бэ гэдэг дээр нь хяналт тавих арга хэмжээ буюу залилуулчихсан байгаа тэр тухайн иргэн өөрийнх нь тэр байраа тавиад, машинаа тавиад, гэр бүлийнхээ бүх үнэ цэнийг тавиад гадагшаа алдаж байгаа мөнгө дээр нь хяналт, хязгаарлалт хийх боломжийг банканд нь өгөхгүйгээр бид цаашаа ямар хяналт тавь гэж энэ байгууллагуудыг шахаж шаардах вэ.

Төлбөрт таавар, бооцоот тоглоомын бие даасан хуулийг гарга гээд байх шиг байна. Энэ агуулгын цаана түүнийг зөвшөөр л гэсэн агуулга шүү дээ. Төлбөрт таавар, бооцоот тоглоомын бие даасан хууль оруулж ир гэдэг бол сайхан зөвшөөрөөд өг, шаардлагыг нь тавиад өгье гээд байна шүү дээ. Зөвшөөрөхгүй уучлаарай. Намайг янз бүрээр над руу мессеж бичээд, намайг янз бүрээр сошиалаар бичээд зөвшөөрөхгүй. Тийм юм байхгүй. ЗГ засах үүрэгтэй, ЗГ ажлаа хийж байна. Тийм учраас 1ХВЕТ гэдэг аппликэйшны цаана их томчууд байдаг юм гэсэн. 110 том ашигтай ажилладаг, ард түмний амьдрал, нус нулимсаар мөнгө хийдэг 110 агент ажилладаг юм гэсэн. Та нар бярттай байж болох ч ЗГ зөвшөөрөхгүй гэдгээ хэлчихье. Тийм учраас та бүхэн янз бүрийн мессежинд битгий хуурт

гишүүдээ. Ганц минут хожих гээд байгаа юм наад хэд чинь. 2 сард 87 сая доллар болчихлоо. Сая Энхцэцэг гишүүн хэлж байна шүү дээ. Австралид банк руу залгахад би залилуулчихлаа гэхэд цаана нь зогсоож чадаж байна шүү дээ. Хуулиар хориглочихвол зогсоохын төлөө л бид ажиллана ЗГ, засахын төлөө л ажиллана. Минут алдвал сарын дараа 50 шүү, 50 сая доллар шүү. Өнгөрсөн жилийн 500 сая чинь 2 сард 87 гэвэл ирэх жил 700 сая доллар алдана шүү, 2 их наяд алдана шүү. Тэгээд та бүхэн дэмжиж өгөхийг хүсье.

**Р.Сэддорж:** Бид энэ нийгэмд үүсээд байгаа олон хүний эрх ашгийг, олон хүний эрх ашгийг хөндөж байгаа энэ асуудлыг шийдэх ёстой. Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо одоо санал хураалт явуулж хэлэлцэх эсэх дээр санал хураалт явуулна. Миний хувьд дэмжиж байна. Энэ дээр фэйсбүүкээр энэ тэр залилуулсан олон хүмүүс байдаг. Тэгээд энийг энэ хууль гарснаар шуурхай илрүүлэх илрүүлэлт нь хангалтгүй байдаг юм байна. Тийм учраас шуурхай илрүүлэх тал дээр ахиц дэвшил гарах байх. Тийм учраас энэ арга хэмжээ авч оролдлого хийж явах ёстой гэдгийг хэлье. Гишүүд асуулт, үг хэлж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11 дэх хэсэгт заасныг үндэслэн хуулийн төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулъя.

1.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 10 гишүүн буюу 55,6 хувийн саналаар санал дэмжигдлээ. Улсын Их Хурлын гишүүн Энхтүвшин, Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэн нарыг дэмжсэнээр протоколд тэмдэглэе. Төхөөрөмж гацсан байна, хүрэлцэн ирсэн байна.

2.Хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Горимын санал гаргах уу, гаргах хүн байна уу? Мөнхсоёл гишүүн горимын санал гаргая.

**Б.Мөнхсоёл:** Уучлаарай горимын санал гаргая. Дахин санал хураалт авна уу, төхөөрөмж гацна шүү. Хүчингүй болгоод дахин санал хураалт.

**Р.Сэддорж:** 2 гишүүний төхөөрөмж уншигдахгүй байгаа учраас сүүлийн санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт. 61,1 хувиар дэмжигдэж санал хураалт хүчингүй боллоо. Санал хураалтыг дахин явуулъя. Хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 55,6 хувийн саналаар санал дэмжигдлээ. Гишүүд санал хураалтдаа анхааралтай оролцоорой. 3, саяын 2 дахь санал хураалт дээр Батчимэг гишүүнийг дэмжсэнээр протоколд тэмдэглэе. Мөн төхөөрөмж сайн ажиллахгүй байна.

3.Хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 55,6 хувийн саналаар санал дэмжигдлээ. Алдаржавхлан гишүүнийг дэмжсэнээр протоколд тэмдэглэе.

4.Хамт өргөн мэдүүлсэн Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье

гэсэн томъёоллоор санал хураалт. 55,6 хувийн саналаар санал дэмжигдлээ. Алдаржавхлан гишүүнийг дэмжсэнээр протоколд тэмдэглэе.

5.Хамт өргөн мэдүүлсэн Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 55,6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Хамт өргөн мэдүүлсэн Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 66,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Хамт өргөн мэдүүлсэн Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 66,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Хамт өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Миний төхөөрөмж ажиллахгүй байна. Энхцэцэг гишүүн горимын санал гаргах уу? Юугаараа хэлчих микрофоноороо. Энхцэцэг гишүүний микрофоныг нээе.

**М.Энхцэцэг:** Сая миний төхөөрөмж ажилласангүй. Тэгэхээр саяын саналыг хүчингүй болгож өгөөч гэсэн горимын санал гаргаж байна.

**Р.Сэддорж:** Энхцэцэг гишүүний гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт. 66,7 хувийн саналаар санал дэмжигдэж санал хураалт хүчингүй боллоо. Санал хураалтыг дахин явуулъя. Хамт өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 66,7 хувийн саналаар санал дэмжигдлээ. Энхтүвшин гишүүнийг дэмжсэнээр протоколд тэмдэглэе.

9.Хамт өргөн мэдүүлсэн Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 55,6 хувийн саналаар санал дэмжигдлээ. Санал хураалт явуулж дууслаа. Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд хэн унших вэ? Чуулганы нэгдсэн хуралдаанд хэн унших вэ? Мөнхсоёл гишүүн яасан уу, Батнайрамдал гишүүн унших уу? Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдал танилцуулна. Хуулийн төслүүдийг хэлэлцэж дууслаа.

14.54 цаг

**Гурав.Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Дараагийн асуудалдаа оръё. Хэлэлцэх асуудал 3. Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулъя. Хуулийн төслийн талаарх хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Их Хурлын гишүүн Энхбаярын Батшугар танилцуулна. Гишүүний микрофоныг нээе.

### **Э.Батшугар:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт олон улсын санхүүгийн зах зээлтэй холбогдсон олон тулгуурт, хүртээмжтэй санхүүгийн системийг хөгжүүлэх, банк, санхүүгийн зах зээлийн эрсдэл даах, найдвартай байдлыг хангуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилтуудыг дэвшүүлсэн байгаа. Банкны салбарын нийт активын хөрөнгийн хэмжээ 2025 оны 2 дугаар сарын байдлаар 67 их наяд төгрөгт хүрч, 2011 он харьцуулахад 7 дахин өссөн байна. Банкны системийн чанаргүй зээлийн түвшнийг харгалзан санхүүгийн тогтвортой байдлаа хадгалах зорилгоор эрх зүйн шинэчлэлийг зайлшгүй хийх шаардлагатай байна.

Өнөөдрийн байдлаар 13 банк, 400 гаруй ББСБ, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд зээлийн мэдээллийн санд иргэд, ААН-үүдийн зээлийн мэдээллийг тогтмол нийлүүлж байгаа бөгөөд зээлийн мэдээллийн санд 1,6 сая иргэн, 17 мянга гаруй ААН, нийт 4,7 сая зээлийн мэдээллийн өгөгдлийг хадгалагдаж байна. Энэхүү их өгөгдлийг үр ашигтай ашиглах, зээлдэгчийн зээлжих чадварыг тоон мэдээлэлд үндэслэн үнэлэх боломжийг одоогийн үйлчилж буй хуулиар бүрэн зохицуулагдаагүй байна. Санхүүгийн үйлчилгээний хамгийн таатай нөхцөлийг зөвхөн том ААН барьцаа хөрөнгөтэй зээлдэгчид хүртэхээс гадна санхүүгийн сахилга баттай иргэд, ААН-үүдийг урамшуулдаг нөхцөлийг бий болгох боломжтой.

Өөрөөр хэлбэл санхүүгийн сахилга баттай иргэд, ААН-үүдийн зээлжих чадварыг барьцаанд тулгуурлаж биш их өгөгдөл, дэвшилтэд технологи ашиглан тогтоож, уян хатан нөхцөлтэйгөөр зээлдэгчийн оноонд суурилсан санхүүгийн үйлчилгээ нэвтрүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна. Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдөр Улсын Их Хуралд өргөн барьсан. Хуулийн төслөөр зээлдэгчийн зээлжих чадварыг тогтоох нэгдсэн онооны аргачлал журам батлахаар шинэ зохицуулалт тусгаж, зээлийн мэдээллийг зээлийн лавлагаанд 6 жилээр тусгах зохицуулалтыг 6 хүртэл болгож өөрчилсөн.

Энэхүү хуулийн төслөөр дараах санхүү эдийн засгийн таатай боломжуудыг бий болгоно. Банк санхүүгийн салбарын үйлчилгээний хүртээмж, салбарын өрсөлдөөнийг нэмэгдүүлнэ. Зээлийн үүргийн гүйцэтгэлийг барьцаа хөрөнгөөр хангуулахаас гадна оноонд суурилсан уян хатан нөхцөлтэйгөөр санхүүгийн үйлчилгээг нэвтрүүлнэ. Зээлийн хүү буурах үндсэн суурь нөхцөлийг бүрдүүлнэ. Зээлдэгчийн хар жагсаалт гэх санхүүгийн ялыг арилгана. Банк санхүүгийн салбарын эрсдэл даах чадварыг нэмэгдүүлж, эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдалд эерэг нөлөөлөл авчирна. Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг [dparliament.mn](http://dparliament.mn) цахим хаягт байршуулсан бөгөөд олон нийтээс тусгайлан санал ирээгүй.

Иргэн, ААН-үүдийн банк санхүүгийн байгууллага, бусдаас авсан зээлийн мэдээллийн бааз сүлжээг сайжруулах, зээлжих чадварт зэрэглэл тогтоох нэгдсэн

аргачлал бий болгоно. Зээлдэгчийн мэдээллийн мэдээлэл, мэдээллийг мэдээллийн санд тусган хугацааг уян хатан тогтоох хуулийн төсөлтэй хамт Авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан тул хэлэлцэж шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхааралд хандуулсанд баярлалаа.

**Р.Сэддорж:** Батшугар гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя. Монголбанкны Дэд ерөнхийлөгч Энхтайван, Монголбанкны Хууль, эрх зүйн газрын захирал Аюуш, Банк бус санхүүгийн газрын дарга Итгэлсүрэн, Монголбанкны Зээлийн мэдээллийн албаны дарга Баттулга, Монголбанкны Зээлийн мэдээллийн албаны ахлах хянан шалгагч Дөлгөөн, Монголбанкны Хууль, эрх зүйн газрын мэргэжилтэн Тэмүүлэн. Санхүүгийн зохицуулах хорооноос хүн ирээгүй юү? Хуулийн төслийн талаарх хууль санаачлагчаас асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Батнайрамдал гишүүнээр тасалъя. Номинчимэг гишүүн. Уучлаарай Соронзонболд гишүүн ирцээрээ яагаад байгаа юм байна.

**Л.Соронзонболд:** Хуулийн төслийг ерөнхийд нь дэмжиж байгаа. Энэ шинээр нэмэлтээр оруулж байгаа энэ 14.3 дахь заалт байгаад байгаа юм. Энэ хуулийн 14.1.3-д заасан зээлдэгчийн зээлжих чадварын зэрэглэлийг Монголбанкнаас баталсан онооны аргачлалын дагуу тогтооно гээд. Энэ дээр жоохон өөрчлөлт оруулах ёстой юм болов уу гэж бодож байгаа юм хууль санаачлагчид хэлэхэд. Яагаад гэхээр Монголбанк хэрвээ өөрөө ингээд зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын бүх ажиллах оноо томъёоллыг нь заагаад өгчихвөл тэд нарын дунд ямар өрсөлдөөн бий болох вэ 1 дүгээрт?

2 дугаарт гол нь энэ зээлийн мэдээлэл лавлагааны байгууллагын чинь гол зорилго нь ер нь яг үнэн зөв, бодитой мэдээлэл гаргаад, систем санхүүгийн тогтвортой байдлыг хангахад хувь нэмрээ оруулахад оршиж байгаа. Тэгэхээр хэрвээ яваандаа Монголбанкны баталсан оноогоор бодсон нь буруу болоод системийн хэмжээнд доголдол гарвал хэн хариуцлага хүлээх вэ гэдэг ийм логикийн асуулт байгаа учраас энэ утга найруулгын хувьд жоохон засах ёстой юм болов уу гэж бодож байгаа юм. Энэ зээлжих чадварын зэрэглэлийг тогтоохдоо Монголбанкнаас баталсан зарчмыг мөрдөж ажиллана ч гэдэг юм уу нэг иймэрхүү утгатай байх нь зөв болов уу гэж бодож байна. Тэгэхгүй бол бүх юмыг нь ингээд томъёогоор бодоод өгчихөөр чинь нөгөө улсууд чинь өөрсдөө юу хийх билээ гээд. Ийм санал байна.

**Р.Сэддорж:** Санал байна. Мөнхсоёл гишүүн.

**Б.Мөнхсоёл:** Би энэ хуулийн санал, үзэл баримтлалыг дэмжиж байгаа. Зүгээр орчуулгын нэг шинжтэй алдаа гарах гээд байна уу гэсэн анзаарал байгаа юм. Нэг нөгөө scoring гэж байгаа шүү дээ англиар. Тэрийг иргэний хувьд зээлийн оноо, ААН-ийн хувьд магадгүй зээлжих зэрэглэл гээд, улс эх орны хувьд бид нөгөө зээлжих зэрэглэл гэж ангилдаг шүү дээ. Энэ 2 чинь нөгөө орчуулга орж байгаа юунаасаа хамаараад төөрөгдөл бий болгох вий, буруу ойлгогдох вий гэдэг асуудал байна. Зээлжих зэрэглэлийн чадвараа зээлжих зэрэглэл юм шиг явчихсан байна лээ шүү гэдгийг сануулж хэлэх гэсэн юм. Баярлалаа.

**Р.Сэддорж:** Санал уу, хариулах хүн байна уу? Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуулт асууя.

**О.Номинчимэг:** Credit scoring Зээлийн мэдээллийн санг яаж ажиллуулах вэ гэдэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж ирж байгаа юм байна. Ер нь энэ бид зээлийн мэдээллийн сан Credit scoring яг хөгжсөн улсын жишээг хараад энийгээ боловсронгуй болгох бол зээлийн хүүг бууруулахад, санхүүгийн итгэлцлийг дээшлүүлэхэд, хэрэгцээгүй шаардлагагүй зардал гаргахгүй байх асуудалд маш чухал ач холбогдолтой гэж үзэж байгаа. Гэхдээ энэ дээр 2 асуулт байна. 1 дүгээрт өдий хүртэл явж ирсэн энэ зээлийн мэдээллийн сан дээрх 6 жил тутам арилдаг энэ нөгөө мэдээллийн сан дээр юу хийгдэж ирсэн бэ гэхээр ямар нэгэн баяр ойртоод ирэхээр энэ нөгөө Өршөөлийн тухай хууль ч гэдэг юм уу, Credit scoring энэ зээлийн мэдээллийн санг тэр чигт нь арчаад хаячихдаг. Тэгээд эндээсээ бид юу харж байна гэхээр зээлийн мэдээллийн санг алга болгох арчаад хаях нь угаасаа нөгөө муу зээлдэгчийн хэмжээг ихэсгэдэг, энийгээ дагаад банкнуудын эрсдэлийн санг нэмэгдүүлдэг гэсэн энэ судалгаа бэлээхэн байдаг. Тэгээд Монголбанкны Ерөнхийлөгч өөрийнхөө шийдвэрээрээ баяр дөхлөө зээлийн мэдээллийн сан дээр өршөөл гаргалаа, арилгачихдаг. Энэ ер нь энэ асуудлыг ер нь энэ хууль дээр цэгцэлж байна уу? Зээлийн мэдээллийн сан өөрөө ийм улс төрийн хараат байдлаар Монголбанк ажиллах, энэнийхээ дагуу дахиад банкнуудын эрсдэлийн санг өсгөх ийм үйл ажиллагааг хязгаарлах, хориглох тал дээр энэ хуулийн төсөл дээр оруулж ирсэн санаа шийдэл байна уу гэдгийг 1 дүгээрт асуумаар байна.

2 дугаарт Credit scoring системийг оруулна гээд ингээд ороод ирсэн байна. Credit scoring систем дээр ямар, ямар мэдээллүүдийг оруулах ёстой энэ тал дээр тэгвэл Монголбанк ажлын хэсэг дээр тооцоолж боловсруулж байгаа юм байгаа юу? Одоогийн манай зээлийн мэдээллийн сан үнэхээр болхи. Зээл аваагүй хүнийг болохоор ямар нэгэн мэдээлэл байхгүй байна, эрсдэл өндөр гээд гарчихдаг. Тэгтэл энэ чинь зээлээ аваад, үнэхээр хугацаандаа төлж байна уу, хугацаандаа төлж байгаа бол хэдий хэрийг нь хугацаандаа төлж байна, 2 хоног хоцорч байна уу, 2 сар хоцорч байна уу, 2 жил хоцорч байна уу гээд маш нарийн мэдээллийг боловсруулж байж жинхэнэ Credit scoring гардаг.

Credit scoring дээр нэг ярих юм зөвхөн зээлээс гадна энэ хүүхдийн тэтгэмж шүүхийн шийдвэр гүйцэтгэлээр гарчхаад байхад төлдөггүй нөхдүүд байна. Санхүү мөнгөний боломжтой мөртөө зугтаад яваад байдаг нөхдүүд байна. СӨХ-ны төлбөрөө төлдөггүй нөхдүүд байна, маш том боломжтой төрийн албан хаагч, Улсын Их Хурлын гишүүд хүртэл амьдарч байгаа хотхон дээрээ СӨХ-ны төлбөрөө төлөхгүй яваад байдаг нөхдүүд байна. Энэ бол өөрөө тэгээд санхүүгийн сахилга бат байхгүй эсвэл төлөх ёстой юмаа төлж чаддаггүй гэсэн хүмүүсийн зан үйл авирыг гаргаж байгаа асуудал. Энийг энэ үзүүлэлтүүдийг Credit scoring систем дээр оруулах уу? Ямар юмнуудыг оруулахаар Монголбанк энэ дээрээ төлөвлөж, Монголбанкны Ерөнхийлөгчийн тогтоолоор энийгээ батална гэж байгаа вэ? Энэ дээр мэдээлэл өгөөч.

**Р.Сэддорж:** Хууль санаачлагч Батшугар гишүүн.

**Э.Батшугар:** Номинчимэг гишүүн зөв сэдэв хөндлөө. Яг энэ Credit scoring онооны системд орсноор олон улсын практик туршлагыг харахад зээлийн хүү буурдаг. 28 орны, хөгжиж буй 28 орны эдийн засгийг харахад зээлийн хүү дунджаар 3,4 хувиар буурсан байгаа юм. Бусад улс орнуудыг хөгжчихсэн улс орнууд, хөгжилтэй улс орныг харахад 2-оос 4 хувиар буурсан тийм үзүүлэлт гарсан статистикийн тоо байгаа. Мозамбик улс дээр хамгийн сүүлд хэрэгжих нь 0,6 өдөрт

зээлийн шийдвэр нь гардаг. Энэ нь нэг ёсны үйл ажиллагааны зардал буурч байна л гэсэн үг л дээ.

Сая нэг Монголбанкны 90 жил, 100 жилийн өршөөлөөр энэ зээлийн мэдээллийн санг төлчихсөн байхад нь өршөөдөг тийм жишиг гарчхаад байна. Энэ нь буруу гэж Номинчимэг гишүүн үзэж байна. Миний хувьд ч гэсэн тантай санал нэг байна. Заавал нэг ой тохиолдоод өршөөдөг биш, энэ бол нэг ёсны санхүүгийн зах зээлд доголдол үүсгээд байгаа юм. Тэгэхээр Credit scoring руугаа явж байгаад, тэгээд энэ ямар нэг өршөөл байхгүйгээр хэрвээ зээлээ төлчихсөн байгаа бол оноо нь нэмэгдээд явна. Хэрвээ зээлдээ доголдол үүсвэл оноо нь буураад явна, ахиад төлөөд эхэлбэл ахиад яваад эхэлнэ. Тийм хар жагсаалтад орно, дахиж 6 жилээр санхүүгийн ял үүрнэ гэсэн тийм зүйл байхгүй болно гэж ойлгож болно.

Харин цэвэр л онооны системээр явдаг болно. Ер нь том зургаараа манай бүх л санхүүгийн гүйлгээнүүд харьцаанууд энэ Credit scoring-д орох ёстой юм. Мобикомын төлбөр байна уу, тогны төлбөр, дээрээс нь нэмээд СӨХ төлбөр, юу байдаг юм гар утасны төлбөр түрүүн хэлсэн. Мөн зээлийн банк санхүүгийн байгууллагатай харьцаж байгаа харьцаанууд бүгд л ер нь орох ёстой байгаа юм. Тэр нь одоогийн байдлаар манай банк санхүүгийн байгууллагын дэд бүтэц бэлэн байна уу, үгүй юү гэдэг нь хараахан тийм асуудалтай байгаа. Гэхдээ ирээдүйдээ ер нь ийшээ чиглэх ёстой гэдэг нь би тантай санал нэг байна. Хүүхдийн мөнгө яригдаж байна, дээрээс нь Боловсролын зээлийн сангийн тухай зээл яригдаж байгаа.

Тэгэхээр одоогийн байдлаар ямар ч байсан эхний ээлждээ Монголбанкны Зээлийн мэдээллийн сан дотор маш их хэмжээний өгөгдөл байгаа. Энийгээ хар жагсаалт, цагаан жагсаалт гэж орохгүйгээр ямар ч байсан энэ өгөгдөлдөө суурилуулаад Credit scoring руу оруулчихъя. Энэ нь өөрөө яваандаа зээлийн хүүг бууруулна. Дээрээс нь ахиад ард иргэд 6 жилийн санхүүгийн ял үүрүүлдэг тогтолцоог нь байхгүй болгоно. Мөн цаашдаа ярихад барьцаа хөрөнгийн шаардлага ч гэсэн өөрөө буурна. Би түрүүн Мозамбикийн кэйсийг ярьсан. Энэ бол хамгийн сүүлийн кэйс байгаа юм. Барьцаа хөрөнгийн шаардлага 11,6 хувиар буурсан болчхож байгаа юм. Тэгэхээр энэ өөрөө хамгийн тийм эрүүл тогтолцоо руу явна. Цаашлаад таны хэлсэнтэй адилхан санал нэг байна том, том, бүх л том, жижиг гэхгүйгээр санхүүгийн харьцаануудыг оруулах ёстой.../минут дуусав/

**Р.Сэддорж:** Монголбанк 4 номер.

**Г.Энхтайван:** Номинчимэг гишүүний асуусан асуултад тодруулъя. Гишүүн энэ зээлийн мэдээллийн санд мэдээлэл нийлүүлэхтэй холбоотой зохицуулалтыг хөндөж байна. Зээлийн мэдээллийн сангийн 4.1-ийн, Зээлийн мэдээллийн сангийн тухай хуулийн 4.1.8 дээр мэдээлэл нийлүүлэгч гэж хэн болохыг тодорхойлсон байгаа. Энэ нь мэдээлэл нь бол үйлчилгээ үзүүлэх этгээдтэй байгуулсан гэрээний үндсэн дээр зээлдэгчийн төлбөр, төлбөрийн үүргийн талаарх мэдээллийг зээлийн мэдээллийн санд нийлүүлж байгаа зээлдүүлэгч, төрийн байгууллагыг гэж нэрлэсэн байгаа. Тэгэхээр төрийн байгууллага бол энэ дээр мэдээлэл нийлүүлэх эрх нь нээлттэй байгаад байгаа. Тухайн та түрүүн хэлсэн шүүхийн шийдвэрээр төлбөр төлөх үүргээ гүйцэтгэхгүй байгаа буюу эцэг, эхийн үүргээ гүйцэтгэхгүй байгаа асуудлыг зээлийн мэдээллийн санд хамруулах ёстой гээд байгаа. Энэ дээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас энэ мэдээллийг манай зээлийн мэдээллийн санд нийлүүлэх эрх нь нээлттэй байгаад байгаа. Гишүүн энэ зээлийн мэдээллийн санд ямар, ямар мэдээллийг нийлүүлэх ёстой юм бэ гэдэг дээр асуудал хөндлөө.



Энэ Зээлийн мэдээллийн сангийн тухай хууль дээр тухайн зээлийн мэдээллийн үйлчилгээ.../минут дуусав/

**Р.Сэддорж:** 4 номер нэмж 1 минут өгье.

**Г.Энхтайван:** Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэхэд яг ямар, ямар мэдээлэл энэ дээр орсон байх ёстой вэ гэдгийг Зээлийн мэдээллийн сангийн тухай хуулийн 6 дугаар зүйл дээр маш дэлгэрэнгүй орсон байгаа. Энэ дээр овог нэр, регистрийн дугаар, оршин суух газрын хаяг мөн гэрээний заалтуудтай холбоотой мэдээллийг бүрэн оруулсан байгаад байгаа. Мөн энэ дээр зээл эргэн төлөгдөөгүй тухай мэдээллийг ч гэсэн дахиад оруулдаг. Гишүүн түрүүн маш чухал, хамгийн гол асуудлыг нь хөндлөө. Энэ зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагаатай холбоотой ямар нэгэн тэмдэглэлт баяр ёслолыг тохиолдуулаад энэ мэдээллийг тодорхой давтамжтайгаар арчиж байгаа асуудлыг хөндлөө. Энэ нь мэдээж банк санхүүгийн байгууллагын эрсдэлийг тодорхой хэмжээнд нэмэгдүүлдэг. Энэ зээлийн мэдээллийн сангийн энэ оноо нэмэгдсэнээр онооны үйл ажиллагаа энэ дээр орж ирснээр яг энэ мэдээллийн үйл, мэдээллийг тодорхой давтамжтайгаар ингэж арчдаг үйл ажиллагаа багасна. Энэ үйл ажиллагаа зогсоно гэдэгт Төв банк ойлгож байгаа.

**Р.Сэддорж:** Номинчимэг гишүүн тодруулж асууя.

**О.Номинчимэг:** Оноожуулалтын системээ оруулж ирье гэж байгаа боловч оноожуулалтын систем дээр чинь юу, юу байх юм бэ гэдэг юм маань сайн бодогдоогүй, сайн боловсруулагдаагүй байгаа юм болов уу л гэсэн сэтгэгдэл авч байна энэ хариултуудаас. Үнэхээр credit score системийг олон улсын хэмжээнд оруулж байж л бид зээлдэгчийн чанартай зээлдэгч үү, үгүй юу ямар юутай юм гэдгийгээ, тэгээд тэр банкнуудын чинь зээл судалгааны зардал чинь угаасаа бэлэн мэдээлэл байгаа дээр багасна шүү дээ. Тэгэхгүй credit score систем дээр одоо байгаа хуулийнхаа хүрээнд энэ мэдээлэл нь л байж байна гээд ингээд ороод ирэх юм бол энэ яг үнэхээр оновчтой score-н систем үүсгэж чадах уу, үгүй юү гэдэг дээр би бол эргэлзэж байна. Энэ дээрээ аргачлал эд нар дээр тэр Монголбанкны Ерөнхийлөгч гаргана гээд байгаа юман дээр Монголбанк дээрээ яг нарийвчилсан юмаа тэр дата юу байдаг юм энийгээ боловсруулаад энийгээ зэрэг хийхгүй бол Батшугар гишүүний хэлж байгаа тэр зээлийн хүү шууд тэдэн хувь буурна гэдэг юм бол тийм амархан хийгдэхгүй байх л гэсэн бодолтой байна. Тэгэхээр түүн дээр илүү боловсруулагдаж байгаа юм байх юм бол тэрийгээ ярьж өгөөч.

**Р.Сэддорж:** Хэн хариулах вэ? 4 номер.

**Г.Энхтайван:** Энэ зээлдэгчийн зээлийн түүхийн мэдээлэл нь үнэн зөв байх ёстой, энэнтэй холбогдуулсан тийм аргачлалыг батлах ёстой гэдэг нь хуулийн үндсэн концепц нь явж байгаа. Тэгэхээр Монголбанкнаас энэ концепц хуулийн өөрчлөлтөөр орж байгаа. Тэр аргачлалыг батлахдаа холбогдох байгууллагууд болох зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий ААН-үүд Монголын Банкны холбоо болон бусад энэ зээлийн мэдээлэл нийлүүлж байгаа ААН-үүд болон мэдээлэл нийлүүлэгчид нь бүгдийнх нь саналыг нь аваад, энэ дээр нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулсны үндсэн дээрээс энэ үйл ажиллагаа аргачлалыг батална. Тэгэхээр яг одоогоор Банкны холбоо болон бусад мэдээлэл нийлүүлэгч байгууллагуудтай зөвхөн ярилцах түвшинд явж байгаа учраас бүүр яг дэлгэрэнгүй энэхүү аргачлалыг ингээд, ингээд баталчихна, яг ийм, ийм байна гэдэг дээр нарийвчилсан юм хэлэх боломжгүй байна. Мэдээж бусад олон

улсын байгууллагууд олон улсын жишиг стандартын дагуу энэ дээр нарийвчилсан дэлгэрэнгүй судалгаа хийгээд, хэлэлцүүлэг зохион байгуулсны үндсэн дээрээс энэ аргачлалыг.../минут дуусав/

**Р.Сэддорж:** Батшугар гишүүн нэмж хариулья.

**Э.Батшугар:** Баярлалаа. Одоогийн байгаа зээлийн медиа санд 4 л ангилал байгаад байгаа юм. Хэвийн, эргэлзээтэй, муу, чанаргүй гээд. Тэгэхээр ямар ч байсан эхний ээлжид scoring системд оруулаад, одоо бол 2 компани тусгай зөвшөөрөлтэй 2 компани байгаа. Тэр нь бол Сайн score, Бүрэн score гээд. Эд нар бол хэмжээндээ ямар ч байсан score-ийг нь гаргаад яваад байгаа. Гэхдээ цаашдаа бүх санхүүгийн оролцоог том big data-нд оролцуулаад, тэгээд том өгөгдөл гаргах нь зөв л дөө. Гэхдээ ямар ч байсан энэ 4 ангилалд байгаад байгаа гол асуудал нь сайнд нь орчихсон хүн л зээл аваад байгаа, нөгөө 3 ангилал байгаа эргэлзээтэй, чанаргүй, муу зээлд орчихсон нөхдүүд иргэд, ААН-үүд 6 жилээр санхүүгийн ял үүрээд, ямар ч банк санхүүгийн байгууллагатай харьцах боломжийг нь хаалгыг нь хаачаад байгаа юм. Тэгээд ямар ч байсан энэ хар жагсаалт гээд бид нэрлээд энэ нэршлийг ямар ч байсан арилгая эхний ээлждээ. Цаашлаад сая Монголбанкны Дэд ерөнхийлөгчийн хэлснээр бүх л оролцогчдыг хамааруулж байгаад том датадаа суурилсан олон улсын жишиг системийг нэвтрүүлэе гэсэн тийм том зорилго байгаа гэж танд хэлье.

**Р.Сэддорж:** Отгоншарын Батнайрамдал гишүүн.

**О.Батнайрамдал:** Баярлалаа. Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах энэ хуулийг зарчмын хүрээнд дэмжиж байна. Зээлийн мэдээллийн сан бий болоод өнөөдөр Монголбанкин дээр нэг бүтээл хэлбэртэй дата үүсээд яваад байгаа юм л даа. Тэгэхээр энэ мэдээллээ нэг ёсондоо ашиглаад, аргачлал журмыг нь гаргаад, эрсдэл удирдах нэгдсэн системийн нэг хэсэг нь заавал болгох ёстой л доо. Ер нь санхүүгийн систем нь хөгжсөн орнууд бүгдээрээ credit scoring байгаа юм. Тэгэхээр энэ төрийн Төв банкин дээр энэ төвлөрч байгаа энэ мэдээллийг л бид эдийн засгийн эргэлтэд нэг ёсондоо market failure буюу зах зээлийн бүтээмж муутайгаа газар луу нь л оруулж ашиглах ёстой нь зөв. Тэгэхээр зарчмын хувьд энэ их зөв зүйл.

Ер нь дэлхий дата мэдээн дээрээ аль түрүүн хиймэл оюун ашиглаад бүүр шал ондоо түвшинд ашиглаж байхад бид зээлийн мэдээллийн сан дээр байгаа мэдээллээ нэг ёсондоо эдийн засгийн эргэлтэд оруулж, эко системдээ бүтээмж авчирч чадахгүй л байна гэсэн үг шүү дээ. Тэгэхээр энийг өөрчилж байгаа нь энэ их өгөгдөл үүсгээд энэ зээлийн мэдээллийн санд буцаад эдийн засгийн эргэлтэд credit score-н системээр оруулж ирэх нь маш зөв. Энэ дээр энэ хууль батлагдсантай холбоотойгоор Улсын Их Хурлын тогтоолын төсөл давхар орж ирж байгаа юм байна. Бас нэг зүйл байгаа юм. Зээлийн мэдээллийн санд ялангуяа татвар төлөгчдийн мөнгөөр зээл болж очсон бол хэт ялгавартай байдал одоог хүртэл явж ирсэн.

Хамгийн тод жишээ бол жишээлбэл Боловсролын зээлийн сан байна. Дотоод зээл авсан хүүхдүүд хэрвээ эргэн төлөхгүй асуудалтай тохиолдолд Монголбанкны зээлийн мэдээллийн санд ороод бараг 10 жил болж байгаа юм байна лээ. Гэтэл гадаад зээл авсан хүүхдүүд одоо хүртэл ороогүй. Энэ бол хоёулаа яг чанарын хувьд яг ялгаагүй зээл. Өөр нэг зүйл нь энэ татварт төлөгчдийн мөнгө. Тэгэхээр ийм татвар

төлөгчдийн мөнгөөр олгосон зээл дээр ийм хэт ялгавартай байдлыг ингээд нэг ёсондоо халах ёстой. Төр ч гэсэн өөрөө зээлийн мэдээллийн санд хэрвээ тэр нь татвар төлөгчдийн мөнгөөр зээл болгож очсон бол тэр үүргээ хүлээх ёстой. Энэ хүрээнд Улсын Их Хурлын тогтоолын төсөл дээр 3 заалт байна. 1, 2 дугаар заалт нь иргэн хувийн өмч хэрвээ зээлийн өр төлбөрөө бүрэн төлсөн тохиолдолд зээлжих чадварын зэрэглэлийг уян хатан тогтоох, хэрвээ Хөгжлийн банк болон тусгай сангуудаас зээлээ төлөөгүй тохиолдолд хамруулахгүй гэж.

Тэгэхээр энэ дээр би тухайлан асуучихмаар байгаа юм. Боловсролын зээлийн сан тусгай сан. Тэгэхээр Боловсролын зээлийн сан дээр эргээд үүргээ гүйцэтгээгүй хүүхдүүдэд энэ нэг ёсондоо хамаарахгүй гэсэн үг үү? Түүн дээр тодорхой хариулт авчихъя. Баярлалаа.

**Р.Сэддорж:** Хариулт Батшугар гишүүн.

**Э.Батшугар:** Энэ тогтоолын төсөл дээр нэг гол санаа нь хэрвээ давагдашгүй хүчин зүйл болоод үер усны аюул, гал түймэр ч юм уу аль эсвэл ковид гэх мэтчилэн тухайн иргэнээс, ААН-ээс хамаарахгүйгээр орлого нь хаагдчихсан байгаа бол тодорхой хэмжээнд уян хатан байдалтай хандана гэсэн заалт оруулсан. Гэхдээ энд би ахиад нэг чухал заалт байгаа юм. Хэрвээ Төрийн мөнгө, Хөгжлийн банкны зээл, бусад ЗГ тусгай сангаас зээл авчхаад тэгээд төлөхгүй байгаа бол энэ заалт санаа хамаарахгүй. Яагаад гэвэл жишээлбэл Хөгжлийн банкнаас авчихсан иргэн, ААН-д өөртөө үйлдлээрээ тодорхой хэмжээний давуу байдал үүсгэхээд байгаа юм. Тэр нь юу вэ гэвэл урт хугацааны, бага хүүтэй зээл авчхаад тэгээд үндсэн зорилгоо биелүүлэхгүй. Асуухаар юу гэдэг вэ гэхээр төрөөс дэмжлэг байхгүй, аль эсвэл янз янзын шалтаг хэлээд байдаг.

Сая бид Төрийн хөгжлийн банкны сонсголоос сонссон ямар хэмжээний зөрчил гарч байсан бэ, шалтгаан нь маш энгийн шалтгаанаар хэлж байсан төрөөс дэмжлэг байхгүй байна, бизнесийн орчин өөрчлөгдсөн гэх мэтчилэн. Тэгэхээр үүнтэй холбогдуулан энэ нь өршөөлийн мөн уян хатан ханддаг заалт үйлчлэхгүй гэж байгаа юм. Боловсролын зээлийн сан мөн адилхан. Өнөөдрийн нөхцөл байдлаар дотоодын 2, 3 сая төгрөгийн зээл авчихсан иргэнд зээлийн мэдээллийн санд орчихдог. Тэгсэн мөртөө 20, 30 мянган долларын зээл авчихсан, 100, 150 сая төгрөгийн зээл авчихсан гадаадын сургуульд сурч байгаа иргэд тухайн зээлийн мэдээллийн санд мэдээлэл нь очдоггүй. Тэгэхээр бүгдээрээ жигд очих ёстой гэсэн байр суурин дээр хатуу байгаа гэдгийг би танд хэлье.

Цаашлаад хэлбэл энэ төрийн мөнгө, татвар төлөгчийн мөнгийг ямар нэгэн байдлаар зориулалтын бусаар ашигласан эсвэл төлөхгүй байгаа бол ямар нэг өршөөл байхгүй. Харин эсрэгээрээ энэ зээлийн мэдээллийн сангийн онооны системдээ ороод үүгээрээ дамжуулаад буурна, оноо нь буурна гэж ойлгож болно. Тийм зохицуулалт орж байгаа гэж хэлье.

**Р.Сэддорж:** Батнайрамдал гишүүн тодруулж асууя.

**О.Батнайрамдал:** Ойлголоо. Тэгэхээр одоог хүртэл яг энэ 30 жилийн хугацаанд яг үнэнийг хэлэхэд яг тийм ялгавартай байдал явж ирсэн л дээ. Татвар төлөгчдийн мөнгөөр олгосон зээл Хөгжлийн банкаар дамжуулаад, өнөөдөр Монгол Улсын ЗГ-ын дэргэдэх 24 тусгай сан байгаа. Олон нь эргэн төлөгдөх нөхцөлтэй. Яг энэ ялгавартай байдлыг бид ямар нэгэн байдлаар заавал халах ёстой. Татвар

төлөгчдийн мөнгө авахаараа тэрийгээ тэтгэлэг гэж ойлгоод явж болохгүй. Татвар төлөгчдийн мөнгөөр зээл болгож авахаараа хүүгүй гэж ойлгоод явж болохгүй. Ямар нэгэн хариуцлага байхгүй гэж ойлгож болохгүй. Тэгэхээр энэ хэрвээ уян хатан тогтоох энэ зээлжих чадварын зэрэглэлд ингээд тогтдог бол ялангуяа энэ татвар төлөгчдийн мөнгөтэй зүй бус харьцсан ч юм уу, тэрийгээ тоодоггүй, эргэн төлдөггүй, огт холбогддоггүй. Тэгэхээр энэ дээр ийм зохицуулалт хамаарахгүй байх нь миний хувьд зарчмын хувьд.../минут дуусав/

**Р.Сэддорж:** Дараа нь үг хэлэх гишүүд бэлдэж байгаарай. Энэ хууль гарснаараа нөгөө 6 жил нь багасах уу? 6 жил хүн алдаа гаргаад ч юм уу, санамсаргүй байдлаар нэг төлбөрөө төлөөгүй утасны төлбөр төлөхгүй байхад ч гэсэн энэ рүү орох юм байна шүү дээ тийм үү? Тэгэхээр энэ 6 жил хадгалагдана гэхээр хэтэрхий чанга байгаа юм биш үү?

2 дугаарт нь зээлийн хүү өндөр байгаа. Иргэдийг, ААН-үүдийг хамгийн их санаа зовоож байгаа юм энэ зээлийн хүү маш өндөр байна. Сая бодлогын хүү ингээд 2 хувиар нэмэгдчихлээ. Тэгэхээр энэ хууль гарснаараа энэ хар муу жагсаалт руу орж байгаа зээлийн нийт дүнгээрээ энэ хүмүүсийн тоо нэмэгдэх үү, хасагдах уу? Зээлийн хүү шууд хамааралтай юу? Зээлийн хүү өндөр байвал хүн төлөх магадлал нь багасна гэсэн үг. Тэгээд энэ дээр сүүлийн энэ 2 хувь дээр нэмж байгаатай холбоотой энэ муу жагсаалт руу орж байгаа, орох зээлдэгч нарын тоо ямархуу харьцаатай хамааралтай байх вэ? Энэ дээр хэлж өгөөч.

**Р.Сэддорж:** Батшугар гишүүн.

**Э.Батшугар:** Сэддорж гишүүний эхний асуултад хариулъя. Одоо бол таны ярьж байгаа зөв. Өнөөдрийн нөхцөл байдалд гар утасныхаа төлбөрөө төлөөгүй долоо хоног хоцорсноосоо болоод хар жагсаалтад ороод, 6 жилийн санхүүгийн ял үүрээд байгаа. Энэ шударга бус зүйлийг байхгүй болгож байгаа. Онооны систем рүү орж байгаа юм. Тэгээд хэрвээ гар утасныхаа төлбөрөөсөө болоод хоцрогдолтой төлчхөөд төлөөд дууссан бол оноо нь буцаад тэгээд хэлбэлзээд динамик нөхцөл байдалтай явах юм. Шууд тас гээд хаалгыг нь хаачих биш. Цаашлаад бүүр бүх төлбөр тооцоогоо цаг хугацаанд төлөөд байвал оноо нь өсөөд л явна. Өндөр оноотой иргэнд барьцаа хөрөнгө нь арай багаар хандах, илүү тааламжтай нөхцөлтэй зээл олгох тийм нөхцөл байдал бүрдэх юм.

Зээлийн хүүгийн асуудлыг ярьж байна. Өнөөдрийн банкнуудын нийт зээлийн хүүг 100 хувь гэж бодвол 63 хувь нь эх үүсвэрийн зардал явж байгаа, 15 хувь нь эрсдэл гэж явж байгаа, 22 хувь нь нэг ёсны урсгал зардал гэж явж байгаа. Тэгэхээр яг энэ хууль батлагдсанаар ямар хэмжээний зээлийн хүү буурах вэ гэвэл 1 дүгээрт эрсдэл буурна банкнуудын хувьд Яагаад гэвэл банкнууд эрсдэлтэй иргэнээ, ААН-ээ сайн санхүүгийн сахилга баттай ААН-үүдээ, иргэдээ ялгаж чадна. Тэгэхээр нийт системийн өөрийнх нь зээлийн хүү нь буурна. Одоо байгаа нөхцөл байдалд ялгаж чадахгүй байгаа болохоор нийт иргэддээ, ААН-д өндөр зээлийн хүү тавьчихаад байгаа эрсдэл өндөртэй гээд. Тэгээд тодорхой хэмжээний зээл нь дампуурвал нөгөө сайн зээлдэгч нартаа нөгөө зээлийн хүүгээ өндөр тавьж байгаад шархаа нөхөөд яваад байгаа. Тэгэхээр энэ байхгүй болно гэж ойлгож болно.

2 дугаарт зээл судална гэж тодорхой хэмжээний цаг хугацаа зардаг, зээлийн эдийн засагч бүх юмыг нь хараад, үзээд. Тэгэхээр энэ байхгүй болно. Шууд онооны системээрээ харж байгаад шууд зээлээ олгоно.

3 дугаарт санхүүгийн зах зээл дээр өөрөө өрсөлдөөн бий болох юм. Нэг ёсны өнөөдрийн хэдхэн том банкнууд дотроо дотооддоо дата баазтай. Тэр дата баазаа бусад банк санхүүгийн байгууллагуудаа өгдөггүй. Тэгэхээр 1 иргэн ганцхан Хаан банкны харилцагч бол Хаан банкандаа л очиж зээл авна. Жижиг Капитал банканд юм уу бусад жижиг банкнууд дээр очиж, Хас банк ч юм уу авъя гэхээр мэдээлэл нь байхгүй болохоор нөгөө банкнууд олгохгүй. Тэгэхээр бүх банкнууд жигд мэдээлэлтэй болсноор өрсөлдөөн үүсээд, өрсөлдөөн нь юун дээр тулгарах вэ гэхээр таатай нөхцөлөөр хүү болон бусад зүйлээр. Яг тоо хэлэхэд ийм юм байна лээ. Мозамбик, Гватемал гэсэн улс орнуудын кейсийг харахад зээлийн хүү Мозамбик жишээлбэл яасан байна билээ 1,9 хувиар буурсан. Гватемал 2,6 хувиар буурсан. Манайд зээлийн жигнэсэн дундаж хүү бол ойролцоогоор 17-гоос 18 хувь байгаа. Тэгэхээр Монголын кэйс дээр 2-оос 4 хувиар буурах бололцоотой гэж харж байгаа юм. 28 хөгжиж байгаа улс орнуудын кэйсийг судлахад 3,4-өөс 3,6 хувиар буурсан байна лээ.

Гэхдээ бид тийм аймаар өндөр хүлээлт үүсгэхгүйгээр ямар ч байсан 2-оос 4 хувиар буурах бололцоотой гэж харж байна. Чанаргүй зээлийн хувь энэ 28 улс орнуудыг хэсэг харахад ийм credit score болон зээлийн онооны систем дээр орсноор 1,9 хувиар буурсан. Өнөөдрийн Монгол Улсын банкны системийн нийт чанаргүй зээлийн хувь ойролцоогоор 5,7 хувьтай байгаа. Тэгэхээр яг энэ кэйсийг авбал энэ нь өөрөө 4 хувь руу бүрэн очих бололцоотой гэж харж байгаа юм. Яагаад гэвэл зээлдэгч нараа банкнууд ялгадаг болно 1-д. 2 дахь нь зээл авч байгаа иргэд илүү санхүүгийн сахилга баттай болно. Хэрвээ би зээлээ төлөөд байвал энэ миний санхүүгийн биет бус хөрөнгө гэж харах юм. Ирээдүйдээ авах миний зээл, хөрөнгө оруулалтын зээл, арилжааны зээл болон хэрэглээний зээл илүү таатай нөхцөл байдалд олгох юм чинь би өөрөө өнөөдөр зээлээ цаг хугацаанд нь төлж байя гэсэн тийм нөхцөл байдал үүсээд, мөн маш олон хэмжээний зэрэг зээл аваад өр орлогын хэмжээ ч гэсэн тодорхой хэмжээний зохистой болоод явах юм цаашдаа систем нь өөрөө. Энэ бол эдийн засгийн ч гэсэн санхүүгийн дархлааг нэмэгдүүлнэ гэж ойлгож болох юм.

**Р.Сэддорж:** Зээлийн хүү 2-оос 4 хувь буурах магадлалтай гэж ойлголоо. СЗХ-ноос Банк бус санхүүгийн байгууллагын газрын дарга ирсэн байна. Яг өөрсдийн чинь хариуцаж байгаа салбарууд дээр иргэдэд ямар сайнаар тусах вэ? 5 номер.

**Б.Итгэлсүрэн:** Эдийн засгийн байнгын хорооны дарга гишүүдэд энэ өдрийн мэнд хүргэе. Энэ онооны асуудлыг оруулж ирснээр ялангуяа банк бусын салбар дээр ББСБ-аас зээл авч байгаа зээлдэгчдийн хувьд нэлээд олон давуу тал үүснэ гэж бодож байгаа. 1 дүгээр асуудал зээлийн хүү дээр нөлөөлнө. Яагаад гэвэл энэ банк бус болгон өөрсдөө зээлдэгчдээ тодорхой хэмжээнд үнэлгээ хийж, үйл ажиллагааны зардал дээр тодорхой хэмжээний зардал гаргаж явж байгаа. Нийт зээлд эзэлж байгаа үйл ажиллагааны зардал 28 хувийг эзэлж байгаа. Тэгэхээр зээлжих онооны зэрэглэлтэй болсноороо тэр зардлаа бууруулаад шууд зээлдэгчдэд онооны дагуу зээл олгох боломж нь нэмэгдэнэ гэж харж байгаа юм.

Мөн дараагийн асуудал энэ Санхүүгийн зохицуулах хороо Монголбанкнаас баталсан энэ актив ангилах журмын дагуу үндсэндээ зээлдэгчдийг гуравхан хувааж үзэж байгаа. Хэвийн зээлтэй зээлдэгч, анхаарал хандуулах буюу хугацаа хэтэрсэн зээлдэгч, мөн чанаргүй зээлдэгч гэдэг байдлаар. Томоохон.../минут дуусав/

**Р.Сэддорж:** 5 номер, 5 номер 1 минут нэмж өгье.

**Б.Итгэлсүрэн:** Томоохон санхүүгийн байгууллагууд үндсэндээ чанаргүй зээлийн ангилалд орсон зээлдэгчдэд шууд зээл өгөхөөс татгалздаг. Энэ онооны систем бий болсноор мэдээж зээлээ төлөх чадвар нь нэмэгдсэн зээлдэгчдэд зээл олгох энэ боломж бүрдээд явна гэж харж байгаа юм. Ийм давуу талуудыг банк бусын салбарын зээлдэгчдэд олгоно гэж ойлгож байгаа.

**Р.Сэддорж:** Гишүүд асуулт асууж дууслаа. Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Соронзонболд гишүүнээр тасалъя. Мөнхсоёл гишүүн үг хэлнэ. Уучлаарай, ирцээрээ юм байна, Соронзонболд гишүүн үг хэлнэ.

**Л.Соронзонболд:** Төслийг дэмжиж байгаа гэдгээ түрүүн хэлсэн. Ер нь цаашдаа нэг нэг анхаарах асуудал нь яг нөгөө нэг зээлдэгчидтэй холбоотой хувийн мэдээллээ өгч байгаа иргэдийн нөгөө мэдээлэлд тодорхой хэмжээний өөрчлөлт орж байгаа. Түүнийг хянах боломжийг олгох дээр нэлээн сайн анхаарч өгөх ёстой гэж бодож байгаа. Тийм учраас хуулийн төсөл дээр энэ талын мэдээлэл хангалттай орсон байна уу, үгүй юу гээд. Яагаад энэ талаар яриад байна вэ гэхээр 1 дүгээрт мэдээж зээлийн онооны систем гаргаж байгаа байгууллага бол зээлдэгчдийг тодорхой зээлжих зэрэглэлээр нь ангилаад эхэлнэ. Тэгэнгүүт тухайн хүн маань тухайн хүний өгөгдлүүдээсээ хамаараад хэт ялгаатай ялгаварлагдан гадуурхагдсан байдлаар ч юм уу тэгж үнэлэгдэж болохгүй. Энэ тал дээр Дэлхийн банкны 2022 оны энэ тайлан гарсан байдаг юм байна лээ. Тэрийг эд нар манай төсөл боловсруулж байгаа улсууд судалсан байх гэж бодож байна. Тийм учраас би түрүүн тэр хуулийн заалтыг Монголбанкнаас баталсан зарчмын дагуу гэж өөрчлөх нь зөв юм биш үү гэдэг санал гаргаад байсан маань тийм учиртай.

**Р.Сэддорж:** Мөнхсоёл гишүүн үг хэлнэ.

**Б.Мөнхсоёл:** Ойлгочих байх гээд явчихсан. Энд нэг үг хэлэнгээ хэлчихье гэж бодож байна. Хуулийн үзэл баримтлалыг дэмжиж байгаа. Мэдээж СЗХ-ныхон ч гэсэн хэлж байгаа тухайн зээл олгогч талын зардал гэхэд л доод тал нь 28 хувиар буурна. Батшугар гишүүний хэлж байгаа ч гэсэн зөндөө давуу талууд бий болно.

Хамгийн гол нь түрүүний миний хэлэх гээд байгаа санаа нь credit rating, credit score ингээд 2 янзын ойлголт байгаа. Scoring гэхээр зээлжих чадварын чадварт нь зориулаад оноо өгч байгаа шүү дээ иргэн хүнд. Гэтэл рэйтинг гэхээр чинь нөгөө улс орныг макро түвшинд нь зээлжих зэрэглэлийг нь дээшлүүлж, доошлуулаад үнэлгээ өгдөг шүү дээ олон улсын түвшинд. Тэр лүүгээ ААН-д зээлжих зэрэглэлийнх нь оноо өгөх гэж байгаад иргэн, ААН хоёроо хольчих вий. Энэнээс болоод цаашаагаа нөгөө сөрөг үр дагаварт хүргэнэ шүү. Нэг нь хувь хүний зээл авах, төлөх ур чадвар маш өргөн хэрэглэгддэг цэвэр программ программ оноо өгдөг юм зүйл байгаа шүү дээ. Нөгөөдөх нь болохоор ААН буюу улсыг дүгнэдэг шиг зах зээлийн багтаамж, тухайн нөгөө, тийм рейтинг шүү маш олон хүчин зүйлд багтаж байгаа. Тэгээд цөөн хэрэглээтэй бүтээгдэхүүн шүү дээ. Энэ хоёрыгоо ялгахгүй бол зөрөө үүсгэх гээд, зөрчил үүсгэчих вий л гэж санаа зовоод. Тэрнээс үзэл баримтлал чухлын мэдэж байна, дэмжиж байна.

**Р.Сэддорж:** Миний хувьд дэмжиж байна. Тэгээд энэ 6 жилийг багасгаарай. Нэг ийм хэт иргэдээ барьсан нийгэм үүсэх вий дээ. Тэгээд иргэд чинь ийм өндөр зээлийн зээлтэй ийм банкны нөхцөлд амьдрахад хэцүү байгаа шүү. Тэгэхээр утасны төлбөрөө төлж чадаагүй тэр сарынх нь нэг сар байхад л ийм юунд орчих юм уу тийм ээ? Энийг уян хатан нэг жоохон 2, 3 сар, заавал утсаа, утасны төлбөрийг энэтэй холбож би зүгээр жишээ ярьж байна. Утасны төлбөрөө төлж чадахгүй байгаа хүнийг заавал энэ рүү оруулдаг юм уу банк. Тэгэхээр ийм харгис байж болох юм уу ер нь. Та бүхэн иргэдийнхээ амьдралыг нэг өнгийж хараарай Монгол банк, Санхүүгийн зохицуулах хороо. Тэгээд та бүхэн энэ өндөр хүүг төлөх гэж яаж амьдарч, хамт олон үүсгэсэн ААН-ээ авч явахын тулд яаж зүдэрч явааг та бүхэн сайн бодож байгаа биз дээ. Тэгэхээр энэ хүү 2-оос 4 хувиар буурах ийм магадлалтай маш сайн хууль байна. Дөрөвхөн оноогоор дүгнэдэг байсан бол одоо процентоор бодвол 100 оноогоор дүгнэх юм байна. Нэгхэн оноогоор зөрөөтэй хүнийг дээшээ ингээд 25 оноогоор хязгаарлаад, 25, 20 онооны зөрөөтэй хүнтэй адилхан түвшнээр үнэлж болох байсан юм байна. Энийг ингээд уян хатан болж байгаа юм байна гэдэгт баяртай байна. Зарчмын хувьд дэмжиж байна. Зээлийн хүү буурах магадлалтай энэ хуулийг манай Байнгын хорооныхон бүгдээрээ дэмжээрэй гэдгийг хувийн зүгээс хүсэж байна.

Гишүүд үг хэлж дууслаа. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11 дэх хэсэгт заасныг үндэслэн хууль, тогтоолын төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулья.

1.Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 61,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2 хамт өргөн мэдүүлсэн Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 61,1 хувийн саналаар санал дэмжигдлээ. Санал хураалт явуулж дууслаа. Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд, чуулганы нэгдсэн хуралдаанд унших гишүүд байна уу? Лувсанжамц гишүүн. Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамц танилцуулна. Хууль, тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

15.36 цаг

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж, хуралдаан үүгээр өндөрлөж байна. Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүд, ажлын хэсгийн нийт бүрэлдэхүүнүүдэд баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

